

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2019 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
11 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР /ЛХАГВА ГАРАГ-ИЙН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
ТОВЬЁГ**

№	Хэлэлцсэн асуудал	Хуудасны дугаар
1.	Хуралдааны товч тэмдэглэл:	1-11
2.	Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	
	1. Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан нарын гишүүд 2019.06.06-ны өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг/	14-50
	2. Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан нарын гишүүд 2019.06.06-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжлэл/	50-58

**Монгол Улсын Их Хурлын 2019 оны намрын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны 11 дүгээр сарын 13-ны
өдөр /Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга С.Бямбацогт ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 56 минутад Төрийн ордны “Их Эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

*Эмнэлгийн чөлөөтэй: Д.Сумъяабазар;
Тасалсан: Б.Жавхлан, Ж.Эрдэнэбат.*

Хэлэлцэх асуудлын дараалалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Эрдэнэбат, Д.Лүндээжанцан нар санал хэлэв.

Нэг. Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан нарын гишүүд 2019.06.06-ны өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан дэд ажлын хэсгийн ахлагч, Улсын Бага Хурлын гишүүн, Улсын Их Хурлын гишүүн асан Ц.Товуусүрэн, дэд ажлын хэсгийн ахлагч, Ардын Их Хурлын депутат, Улсын Бага Хурлын гишүүн асан Р.Хатанбаатар, дэд ажлын хэсгийн ахлагч, Монгол Улсын гавьяат хуульч Н.Лувсанжав, дэд ажлын хэсгийн ахлагч, Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш, хууль зүйн ухааны доктор О.Мөнхсайхан, дэд ажлын хэсгийн гишүүн, Ардын Их Хурлын депутат, Улсын Бага Хурлын гишүүн асан Д.Ламжав, дэд ажлын хэсгийн гишүүн Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, профессор, хууль зүйн ухааны доктор А.Бямбажаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Э.Түвшинжаргал, Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ж.Бямбадулам, зөвлөх Ц.Болормаа, Б.Хатантуул нар байлцав.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг Байнгын хорооны дарга С.Бямбацогт танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүн Д.Эрдэнэбат Улсын Их Хурал дахь Ардчилсан намын зөвлөлийн тавьсан зарчмын гурван саналаас Зөвшилцлийн ажлын хэсэг дээр ойлголцсон хоёр саналаар эхэлж санал хураалт явуулъя гэсэн горимын санал гаргав.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын гишүүн Д.Эрдэнэбатын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 2

Бүгд: 14

85.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга С.Бямбацогт Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 24⁶.2-т Байнгын хороо энэ хуулийн 24⁶.1-д заасан гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэхдээ зөвхөн дараах тохиолдолд санал хураалт явуулж болох бөгөөд Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүйн саналаар хэлэлцэж, шийдвэрлэнэ. 24⁶.2.1. нэгдсэн хуралдаанаар хоёр дахь хэлэлцүүлэг явуулах үед төслийн зарим зүйл, хэсэг, заалтыг гүйцээн боловсруулах чиглэл хуралдаан даргалагчаас өгсөн, 24⁶.2.2. энэ хуулийн 24⁵.4 дэх хэсэгт заасан санал, дүгнэлт, 24⁶.2.3. нэгдсэн хуралдааны хоёр дахь хэлэлцүүлгээр санал хурааж шийдвэрлэсэн боловч уг асуудлаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэн. 24⁶.2.4. Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн зүйл, хэсэг, заалтад найруулгын засвар хийсэн. 24⁶.3. Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүйн дэмжлэг аваагүй бол зарчмын зөрүүтэй саналыг төсөлд тусгах шаардлагагүй гэж үзсэн үндэслэл, шалтгаанаа Байнгын хороо санал, дүгнэлтдээ тусгана. 24⁶.4. энэ хуулийн 24⁶.1.4; 24⁶.2-т зааснаас бусад үндэслэлээр нэгдсэн хуралдааны хоёр дахь хэлэлцүүлгээр дэмжигдсэн саналыг өөрчлөх буюу хүчингүй болгох санал, дүгнэлт гаргахыг хориглоно гэсэн дэгээр санал хураалт явагдана гэдгийг танилцуулав.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн талаар Зөвшилцлийн ажлын хэсгээс гаргасан саналын томъёоллуудаар санал хураалт явуулав.

С.Бямбацогт: 12. Хоёр дахь хэлэлцүүлгийн дараах төсөлд доор дурдсан агуулгатай Гучин есдүгээр зүйлийн 4 дэх хэсэгт нэмэх:

“4.Засгийн газрын гишүүнийг Улсын Их Хурал, Ерөнхийлөгчид танилцуулснаар Ерөнхий сайд томилж, чөлөөлж, огцруулна. Засгийн газрын гишүүн Улсын Их Хуралд тангараг өргөнө.” гэсэн саналаар санал хураах шаардлагатай гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүү үг хэлж, Байнгын хорооны дарга С.Бямбацогт тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 1
Бүгд: 16

93.8 хувийн саналаар дэмжигдлээ.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын гишүүн Н.Амарзаяа, Ж.Батзандан, С.Бямбацогт, Д.Лүндээжанцан, Ж.Мөнхбат, Г.Занданшатар, Б.Пүрэвдорж, Д.Тогтохсүрэн, Л.Оюун-Эрдэнэ, О.Содбилэг, Д.Хаянхярваа, Н.Цэрэнбат, М.Энхболд, Н.Энхболд, Д.Эрдэнэбат нарын гаргасан, Хоёр дахь хэлэлцүүлгийн дараах төсөлд доор дурдсан агуулгатай Гучин есдүгээр зүйлийн 4 дэх хэсэгт нэмэх:

“4.Засгийн газрын гишүүнийг Улсын Их Хурал, Ерөнхийлөгчид танилцуулснаар Ерөнхий сайд томилж, чөлөөлж, огцруулна. Засгийн газрын гишүүн Улсын Их Хуралд тангараг өргөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүү, Д.Хаянхярваа, Ж.Мөнхбат нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 1
Бүгд: 16

93.8 хувийн саналаар дэмжигдлээ.

С.Бямбацогт: 13.а.Хоёр дахь хэлэлцүүлгийн дараах төслийн өөрчилсүгэй гэсэн 4 дүгээр зүйлд “Монгол Улсын Үндсэн хуулийн” гэсний дараа “Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалтын “Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд,” гэснийг “Ерөнхий сайд,” гэж,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүү үг хэлэв.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 1
Бүгд: 16

93.8 хувийн саналаар дэмжигдлээ.

С.Бямбацогт: 14.Хоёр дахь хэлэлцүүлгийн дараах төслийн 21 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 1, 2 дахь өгүүлбэр нэмэх:

“Улсын Их Хурлын сонгуулийг олонхийн болон хувь тэнцүүлэх зарчмыг хослуулан явуулна. Сонгогч тойрогт нэр дэвшсэн болон намын жагсаалтад орсон нэр дэвшигчийн төлөө саналаа өгнө.” гэсэн саналаар санал хураах шаардлагатай гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүү үг хэлж, Байнгын хорооны дарга С.Бямбацогт тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 2
Бүгд: 16
87.5 хувийн саналаар дэмжигдлээ.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын гишүүн Н.Амарзаяа, Ж.Батзандан, С.Бямбацогт, Д.Лүндээжанцан, Ж.Мөнхбат, Г.Занданшатар, Б.Пүрэвдорж, Д.Тогтохсүрэн, Л.Оюун-Эрдэнэ, О.Содбилэг, Д.Хаянхярваа, Н.Цэрэнбат, М.Энхболд, Н.Энхболд, Д.Эрдэнэбат нарын гаргасан, Хоёр дахь хэлэлцүүлгийн дараах төслийн 21 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 1, 2 дахь өгүүлбэр нэмэх:

“Улсын Их Хурлын сонгуулийг олонхийн болон хувь тэнцүүлэх зарчмыг хослуулан явуулна. Сонгогч тойрогт нэр дэвшсэн болон намын жагсаалтад орсон нэр дэвшигчийн төлөө саналаа өгнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүү үг хэлж, Байнгын хорооны дарга С.Бямбацогт тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 3
Бүгд: 16
81.2 хувийн саналаар дэмжигдлээ.

С.Бямбацогт: 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу Арван ес¹дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулна.” гэснийг “улсын хэмжээний бодлого дэвшүүлж ажиллана.” гэж өөрчлөх гэсэн саналаар санал хураах шаардлагатай гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 3
Бүгд: 16
81.2 хувийн саналаар дэмжигдлээ.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын гишүүн Н.Амарзаяа, Ж.Батзандан, С.Бямбацогт, Д.Лүндээжанцан, Ж.Мөнхбат, Г.Занданшатар, Б.Пүрэвдорж, Д.Тогтохсүрэн, Л.Оюун-Эрдэнэ, О.Содбилэг, Д.Хаянхярваа, Н.Цэрэнбат, М.Энхболд, Н.Энхболд, Д.Эрдэнэбат нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу Арван ес¹дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулна.” гэснийг “улсын хэмжээний бодлого дэвшүүлж ажиллана.” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүү, Д.Лүндээжанцан нар үг хэлж, Байнгын хорооны дарга С.Бямбацогт тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 2
Бүгд: 15
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

С.Бямбацогт: 2.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу Арван ёс¹ дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “зарчимд нийцэж” гэснийг “зарчимд нийцсэн” гэж, “байгуулалт нь” гэснийг “байгуулалт”, “эх үүсвэр болон” гэснийг “эх үүсвэр,” гэж тус тус өөрчлөх гэсэн саналаар санал хураах шаардлагатай гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 2
Бүгд: 15
86.7 хувийн саналаар дэмжигдлээ.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын гишүүн Н.Амарзаяа, Ж.Батзандан, С.Бямбацогт, Д.Лүндээжанцан, Ж.Мөнхбат, Г.Занданшатар, Б.Пүрэвдорж, Д.Тогтохсүрэн, Л.Оюун-Эрдэнэ, О.Содбилэг, Д.Хаянхярваа, Н.Цэрэнбат, М.Энхболд, Н.Энхболд, Д.Эрдэнэбат нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу Арван ёс¹ дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “зарчимд нийцэж” гэснийг “зарчимд нийцсэн” гэж, “байгуулалт нь” гэснийг “байгуулалт”, “эх үүсвэр болон” гэснийг “эх үүсвэр,” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 2
Бүгд: 15
86.7 хувийн саналаар дэмжигдлээ.

С.Бямбацогт: 3.Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу Зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн “тулгуурласан” гэснийг “тулгуурлаж”, “иргэн бүрт” гэснийг “ирээдүй үеийн” гэсний дараа оруулах, “бүрт” гэснийг “бүрд” гэж, мөн “эрхийнхээ хүрээнд” гэсний дараа “газрын хэвлийн баялаг” гэснийг “газрын хэвлийн баялгийг” гэж өөрчлөх гэсэн саналаар санал хураах шаардлагатай гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 2
Бүгд: 15
86.7 хувийн саналаар дэмжигдлээ.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын гишүүн Н.Амарзаяа, Ж.Батзандан, С.Бямбацогт, Д.Лүндээжанцан, Ж.Мөнхбат, Г.Занданшатар, Б.Пүрэвдорж, Д.Тогтохсүрэн, Л.Оюун-Эрдэнэ, О.Содбилэг, Д.Хаянхярваа, Н.Цэрэнбат, М.Энхболд, Н.Энхболд, Д.Эрдэнэбат нарын гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу Зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн “тулгуурласан” гэснийг “тулгуурлаж”, “иргэн бүрт” гэснийг “ирээдүй үеийн” гэсний дараа оруулах, “бүрт” гэснийг “бүрд” гэж, мөн “эрхийнхээ хүрээнд” гэсний дараа “газрын хэвлийн баялаг” гэснийг “газрын хэвлийн баялгийг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 2
Бүгд: 15
86.7 хувийн саналаар дэмжигдлээ.

С.Бямбацогт: 4.Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.” гэсэн 4 дэх өгүүлбэр нэмэх гэсэн саналаар санал хураах шаардлагатай гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 2
Бүгд: 15
86.7 хувийн саналаар дэмжигдлээ.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын гишүүн Н.Амарзаяа, Ж.Батзандан, С.Бямбацогт, Д.Лүндээжанцан, Ж.Мөнхбат, Г.Занданшатар, Б.Пүрэвдорж, Д.Тогтохсүрэн, Л.Оюун-Эрдэнэ, О.Содбилэг, Д.Хаянхярваа, Н.Цэрэнбат, М.Энхболд, Н.Энхболд, Д.Эрдэнэбат нарын гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.” гэсэн 4 дэх өгүүлбэр нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 2
Бүгд: 15
86.7 хувийн саналаар дэмжигдлээ.

С.Бямбацогт: 5.Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалт буюу Хорин хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “гуравны хоёроос доошгүй нь үзсэн,” гэснийг “гуравны хоёроос доошгүй нь үзэж” гэж, “даргатай зөвшилцөн” гэснийг “даргатай зөвшилцөж” гэж, “санал болгосноор” гэснийг “санал болгосон бол” гэж тус тус өөрчлөх гэсэн саналаар санал хураах шаардлагатай гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 4
Бүгд: 15
73.3 хувийн саналаар дэмжигдлээ.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын гишүүн Н.Амарзаяа, Ж.Батзандан, С.Бямбацогт, Д.Лүндээжанцан, Ж.Мөнхбат, Г.Занданшатар, Б.Пүрэвдорж, Д.Тогтохсүрэн, Л.Оюун-Эрдэнэ, О.Содбилэг, Д.Хаянхярваа, Н.Цэрэнбат, М.Энхболд, Н.Энхболд, Д.Эрдэнэбат нарын гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалт буюу Хорин хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “гуравны хоёроос доошгүй нь үзсэн,” гэснийг “гуравны хоёроос доошгүй нь үзэж” гэж, “даргатай зөвшилцөн” гэснийг “даргатай зөвшилцөж” гэж, “санал болгосноор” гэснийг “санал болгосон бол” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 3
Бүгд: 15

80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

С.Бямбацогт: 6.Төслийн 3 дугаар зүйлийн 7 дахь заалт буюу Дөчин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “батлагдсанд тооцож” гэснийг “баталсанд тооцож” гэж өөрчлөх гэсэн саналаар санал хураах шаардлагатай гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13

Татгалзсан: 2

Бүгд: 15

86.7 хувийн саналаар дэмжигдлээ.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын гишүүн Н.Амарзаяа, Ж.Батзандан, С.Бямбацогт, Д.Лүндээжанцан, Ж.Мөнхбат, Г.Занданшатар, Б.Пүрэвдорж, Д.Тогтохсүрэн, Л.Оюун-Эрдэнэ, О.Содбилэг, Д.Хаянхярваа, Н.Цэрэнбат, М.Энхболд, Н.Энхболд, Д.Эрдэнэбат нарын гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 7 дахь заалт буюу Дөчин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “батлагдсанд тооцож” гэснийг “баталсанд тооцож” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 3

Бүгд: 15

80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

С.Бямбацогт: 7.Төслийн 3 дугаар зүйлийн 9 дэх заалт буюу Дөчин есдүгээр зүйлийн 5 дахь хэсгийн “Зөвлөлийн үйл ажиллагааны тайланг” гэснийг “Шүүгчийн хараат бус байдлыг хангахтай холбоотой зөвлөлийн үйл ажиллагааны тайланг” гэж өөрчлөх гэсэн саналаар санал хураах шаардлагатай гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13

Татгалзсан: 2

Бүгд: 15

86.7 хувийн саналаар дэмжигдлээ.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын гишүүн Н.Амарзаяа, Ж.Батзандан, С.Бямбацогт, Д.Лүндээжанцан, Ж.Мөнхбат, Г.Занданшатар, Б.Пүрэвдорж, Д.Тогтохсүрэн, Л.Оюун-Эрдэнэ, О.Содбилэг, Д.Хаянхярваа, Н.Цэрэнбат, М.Энхболд, Н.Энхболд, Д.Эрдэнэбат нарын гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 9 дэх заалт буюу Дөчин есдүгээр зүйлийн 5 дахь хэсгийн “Зөвлөлийн үйл ажиллагааны тайланг” гэснийг “Шүүгчийн хараат бус байдлыг хангахтай холбоотой зөвлөлийн үйл ажиллагааны тайланг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13

Татгалзсан: 2

Бүгд: 15

86.7 хувийн саналаар дэмжигдлээ.

С.Бямбацогт: 8.Төслийн 3 дугаар зүйлийн 11 дэх заалт буюу Тавин долдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “хот; тосгоны” гэснийг “хотын, түүнчлэн тосгоны”

гэж өөрчлөх гэсэн саналаар санал хураах шаардлагатай гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 2
Бүгд: 15
86.7 хувийн саналаар дэмжигдлээ.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын гишүүн Н.Амарзаяа, Ж.Батзандан, С.Бямбацогт, Д.Лүндээжанцан, Ж.Мөнхбат, Г.Занданшатар, Б.Пүрэвдорж, Д.Тогтохсүрэн, Л.Оюун-Эрдэнэ, О.Содбилэг, Д.Хаянхярваа, Н.Цэрэнбат, М.Энхболд, Н.Энхболд, Д.Эрдэнэбат нарын гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 11 дэх заалт буюу Тавин долдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “хот; тосгоны” гэснийг “хотын, түүнчлэн тосгоны” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүүгийн тавьсан асуултад Байнгын хорооны дарга С.Бямбацогт хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 2
Бүгд: 15
86.7 хувийн саналаар дэмжигдлээ.

С.Бямбацогт: 9.”Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг 2020 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 12 цаг буюу арван долдугаар жарны төмөр хулгана жилийн зуны тэргүүн сарын шинийн гуравны өдрийн морин цагаас эхлэн улс орон даяар дагаж мөрдөнө.” гэсэн саналаар санал хураах шаардлагатай гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 2
Бүгд: 15
86.7 хувийн саналаар дэмжигдлээ.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын гишүүн Н.Амарзаяа, Ж.Батзандан, С.Бямбацогт, Д.Лүндээжанцан, Ж.Мөнхбат, Г.Занданшатар, Б.Пүрэвдорж, Д.Тогтохсүрэн, Л.Оюун-Эрдэнэ, О.Содбилэг, Д.Хаянхярваа, Н.Цэрэнбат, М.Энхболд, Н.Энхболд, Д.Эрдэнэбат нарын гаргасан, “Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг 2020 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 12 цаг буюу арван долдугаар жарны төмөр хулгана жилийн зуны тэргүүн сарын шинийн гуравны өдрийн морин цагаас эхлэн улс орон даяар дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 2
Бүгд: 15
86.7 хувийн саналаар дэмжигдлээ.

С.Бямбацогт: 10.Төслийн 3 дугаар зүйлийн 12 дахь заалт буюу Дөчин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “төсөв,” гэснийг “төсвийн болон” гэж өөрчлөх

гэсэн саналаар санал хураах шаардлагатай гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 4

Бүгд: 15

73.3 хувийн саналаар дэмжигдлээ.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын гишүүн Н.Амарзаяа, Ж.Батзандан, С.Бямбацогт, Д.Лүндээжанцан, Ж.Мөнхбат, Г.Занданшатар, Б.Пүрэвдорж, Д.Тогтохсүрэн, Л.Оюун-Эрдэнэ, О.Содбилэг, Д.Хаянхярваа, Н.Цэрэнбат, М.Энхболд, Н.Энхболд, Д.Эрдэнэбат нарын гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 12 дахь заалт буюу Дөчин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “төсөв,” гэснийг “төсвийн болон” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13

Татгалзсан: 2

Бүгд: 15

86.7 хувийн саналаар дэмжигдлээ.

С.Бямбацогт: 11.Төслийн 3 дугаар зүйлийн 13 дахь заалт буюу Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “тойргийн” гэсний өмнө “шүүхийг” гэж нэмэх гэсэн саналаар санал хураах шаардлагатай гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 3

Бүгд: 15

80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын гишүүн Н.Амарзаяа, Ж.Батзандан, С.Бямбацогт, Д.Лүндээжанцан, Ж.Мөнхбат, Г.Занданшатар, Б.Пүрэвдорж, Д.Тогтохсүрэн, Л.Оюун-Эрдэнэ, О.Содбилэг, Д.Хаянхярваа, Н.Цэрэнбат, М.Энхболд, Н.Энхболд, Д.Эрдэнэбат нарын гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 13 дахь заалт буюу Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “тойргийн” гэсний өмнө “шүүхийг” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13

Татгалзсан: 2

Бүгд: 15

86.7 хувийн саналаар дэмжигдлээ.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатарын гаргасан, Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд “Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлд Монгол Улсын Ерөнхийлөгчийг Улсын Их Хурлын өргөтгөсөн бүрэлдэхүүнээс сонгоно.” гэж нэмэх гэсэн саналаар санал хураах шаардлагатай гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 7

Бүгд: 15

53.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Байнгын хорооны дарга С.Бямбацогт Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 59 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан нарын гишүүд 2019.06.06-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжлэл/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан дэд ажлын хэсгийн ахлагч, Улсын Бага Хурлын гишүүн, Улсын Их Хурлын гишүүн асан Ц.Товуусүрэн, дэд ажлын хэсгийн ахлагч, Ардын Их Хурлын депутат, Улсын Бага Хурлын гишүүн асан Р.Хатанбаатар, дэд ажлын хэсгийн ахлагч, Монгол Улсын гавьяат хуульч Н.Лувсанжав, дэд ажлын хэсгийн ахлагч, Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш, хууль зүйн ухааны доктор О.Мөнхсайхан, дэд ажлын хэсгийн гишүүн, Ардын Их Хурлын депутат, Улсын Бага Хурлын гишүүн асан Д.Ламжав, дэд ажлын хэсгийн гишүүн Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, профессор, хууль зүйн ухааны доктор А.Бямбажаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Э.Түвшинжаргал, Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ж.Бямбадулам, зөвлөх Ц.Болормаа, Б.Хатантуул нар байлцав.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлэгтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батзандангийн тавьсан асуултад Байнгын хорооны дарга С.Бямбацогт, Д.Лүндээжанцан нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Эрдэнэбат, Д.Тогтохсүрэн нар үг хэлэв.

С.Бямбацогт: Ажлын хэсгээс гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 4 дүгээр зүйл нэмэх:

“4 дүгээр зүйл. Улсын Их Хурлын сонгуулийг 2024 оны ээлжит сонгуулиас эхлэн олонхийн болон хувь тэнцүүлэх зарчмыг хослуулан явуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	10
Татгалзсан:	4
Бүгд:	15

71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Д.Эрдэнэбат “Улсын Их Хурлын сонгуулийг 2020 оны ээлжит сонгуулиас эхлэн олонхийн болон хувь тэнцүүлэх зарчмыг хослуулан явуулна.” гэсэн санал гаргав.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар үг хэлж, Байнгын хорооны дарга С.Бямбацогт, Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Э.Түвшинжаргал нар тайлбар хийв.

С.Бямбацогт: “Улсын Их Хурлын сонгуулийг 2024 оны ээлжит сонгуулиас эхлэн олонхийн болон хувь тэнцүүлэх зарчмыг хослуулан явуулна.” гэсэн санал хураалтыг хүчингүй болгох гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 3
Бүгд: 15
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооны дарга С.Бямбацогт дахин санал хураалтаар ажлын хэсгээс гаргасан санал дэмжигдсэн тохиолдолд хоёр дахь санал буюу Улсын Их Хурлын гишүүн Д.Эрдэнэбатын гаргасан саналаар санал хураалт явуулахгүй болохыг танилцуулж, ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор дахин санал хураалт явуулав.

С.Бямбацогт: Ажлын хэсгээс гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 4 дүгээр зүйл нэмэх:

“4 дүгээр зүйл. Улсын Их Хурлын сонгуулийг 2024 оны ээлжит сонгуулиас эхлэн олонхийн болон хувь тэнцүүлэх зарчмыг хослуулан явуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 4
Бүгд: 15
73.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Д.Хаянхярваа үг хэлэв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Хуралдаан 2 цаг 31 минут үргэлжилж, 19 гишүүнээс 16 гишүүн ирж, 84.2 хувийн ирцтэйгээр 13 цаг 27 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

С.БЯМБАЦОГТ

Тэмдэглэл хөтөлсөн:
ПРОТОКОЛЫН АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2019 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
11 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР /ЛХАГВА ГАРАГ/-ИЙН
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ**

С.Бямбацогт: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Байнгын хорооны ирц бүрдсэн тул 2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье. Ирц 68.4 хувьтай, 19 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирсэн байна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Хоёр асуудал байгаа.

Нэгдүгээрт нь, Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх асуудал.

Хоёрдугаарт нь, Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төсөл. Улсын Их Хурлын гишүүн Лүндээжанцан нарын 62 гишүүн 2019 оны 06 дугаар сарын 06-ны өдөр өргөн мэдүүлсэн анхны хэлэлцүүлэг хийгдэнэ.

Хэлэлцэх асуудалдаа оръё. Хэлэлцэх асуудалтай холбогдуулж саналтай гишүүд байна уу. Д.Эрдэнэбат гишүүн.

Д.Эрдэнэбат: Баярлалаа. Хоёрдугаар асуудал нь Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн асуудал орсон байна л даа.

Тэгэхээр энэ төсөл нь хуучнаараа явж байгаа. Гуравдугаар хэлэлцүүлгээр эцсийн байдлаар Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд яг ямар зүйл заалт нь батлагдаж, ямар зүйл заалт нь унах нь шийдэгдээгүй байхад энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмыг өнөөдөр хэлэлцэх шаардлагагүй болов уу гэж үзэж байна.

Яагаад гэхээр бид нар эхлээд гуравдугаар хэлэлцүүлгээрээ бүх асуудлаа шийдсэний дараа, эцэслэн шийдэгдсэний дараа Үндсэн хуулийн үндсэн нэмэлт, өөрчлөлт шийдэгдсэний дараа Төрийн байгуулалтын байнгын хороо яг үүний дагуу дагаж мөрдөх журмын тухай хуулийг хэлэлцэх нь зүйтэй болов уу гэж ингэж бодож байгаа.

Тийм учраас өнөөдөр нэг л асуудлыг бүгдээрээ хэлэлцье. Энэ юу гэхээр Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн гуравдугаар хэлэлцүүлэгт оруулах зарчмын зөрүүтэй саналуудаа хэлэлцэх нь зүйтэй болов уу гэсэн бодол байна.

Тийм учраас журмын тухай хуулийг хойшлуулах нь зүйтэй энэ удаад гэсэн. Дахин дараагийн гуравдугаар хэлэлцүүлэг дууссаны дараа Төрийн байгуулалтын байнгын хороо энэ журмын хуулийг хэлэлцэх нь зүйтэй гэсэн ийм санал байна.

С.Бямбацогт: Журмын тухай хуулийг анхны хэлэлцүүлэг урд нь хийгдсэн. Зөвшилцлийн ажлын хэсгээс тодорхой санал гарсантай холбогдуулаад журмын тухай хуулийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлж хийх шаардлага байгаа.

Үндсэн хуулийн гурав дахь хэлэлцүүлэг буюу эцсийн хэлэлцүүлэг Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл хийгдэнэ. Журмын тухай хуулийн анхны хэлэлцүүлэг хийгдэнэ. Журмын тухай хууль үндсэндээ бүтэн нэг шатаар хоцорч хэлэлцэгдэж байгаа. Тийм болохоор өнөөдөртөө хэлэлцээд явж байхад эцсийн хэлэлцүүлэг шатанд журмын тухай хууль гурав дахь хэлэлцүүлэг батлагдсаны, Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн гурав дахь хэлэлцүүлэг батлагдсаны дараа журмын тухай хуулийн эцсийн хэлэлцүүлгийг хийгдэнэ. Тэр үед тодорхой асуудлыг Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлтэй холбогдуулж тодорхой өөрчлөлт орох бололцоо нээгдэнэ байх гэж бодож байна. Тийм болохоор хэлэлцээд явчихъя гэсэн бодолтой байна. Д.Лүндээжанцан гишүүн.

Д.Лүндээжанцан: Ийм л дээ. Өмнө нь бид бүхэн хоёрдугаар хэлэлцүүлгээ хийж дууссаны дараа шилжих үү, ард нийтийн санал асуулгын хуулиар батлуулах уу гэдгийнхээ үед Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт дагаж мөрдөхөд шилжих тухай журмын тухай хуулийн 7 зүйл ингэж мэдүүлснээс санал хураалт явуулаад 3 зүйлтэй болгоод үлдээсэн байгаа юм.

Энэ дээр өчигдөр Зөвшилцлийн ажлын хэсэг гараад, тэгээд Улсын Их Хурлын сонгуулийг дөрөв дэх нь 2024 оны ээлжит сонгуулиас эхлэн олонхийн болон хувь тэнцүүлэх зарчмыг хослуулан явуулна гээд ингээд хугацаа тавьсан. Энийгээ нэгдүгээр хэлэлцүүлэг, манай Байнгын хорооны нэгдүгээр хэлэлцүүлэг байхгүй юу. Ядахдаа энэ дээрээ нэг тийш нь болгоод ингээд Их Хурлаар нэгдүгээр хэлэлцүүлэг оруулах ийм нөхцөлийг бүрдүүлээд орхих хэрэгтэй байна.

Гуравдугаар хэлэлцүүлгээр баталсны дараагаар нэгдүгээр хэлэлцүүлгээ явуулаад бусад завсарлаад тэгээд эцсийн хэлэлцүүлэгт оруулах асуудал яригдаж, тусдаа. Яг сая Д.Эрдэнэбат даргын хэлдгээр тусдаа явагдана. Тийм учраас нэгдүгээр хэлэлцүүлгээ дуусгах ёстой юм гэж ингэж үзэж байгаа юм.

Ингээд баталсны дараа нэгдүгээр хэлэлцүүлэг, дахиад хоёрдугаар хэлэлцүүлэг ингээд хамт явахаар, хамт явахаар болохгүй байна гэж. Тэр Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд холбогдох хуулийг шинэчлэн батлах хүртэл хугацаанд тухайн харилцааг зохицуулж байсан хуулийг баримтална гэдэг заалт бид нар ойлголцоод явж байгаа шүү дээ. Яагаад гэхээр 5 сарын 25-нд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт хүчин төгөлдөр болоод ингээд явахад тэр болтол, тэрний дараа олон хуулиудыг шинэчлэх шаардлагатай байгаа учраас тэр болтол зохицуулагдаад явагдана.

Тухайлбал, би С.Бямбацогт даргаас асуух гэж байгаа юм. Жишээ нь. Нөгөө намын бүртгэл байна шүү дээ. Улс төрийн намын бүртгэл нэг хувь гэдэг бол хэзээнээс тооцогдох юм бэ гээд. Энэ дээр жишээ нь хариулт өгөх шаардлага гарна. Тийм ээ. Тэгэхээр хэлэлцэх эсэхийн дараа үед ер нь ярьж таарна. Жишээ нь. Гэх мэтчилэнгээр хугацаануудын асуудал яригдана. Тэрнээс биш шууд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт батлагдлаа. Шууд бүртгэл эхэлнэ

гэж үзэхгүй байгаа. Гэх мэтчилэнгээр энэ асуудлыг нэгдүгээр хэлэлцүүлгээрээ явуулахаас өөр. Эхлээд ямар ч байсан нэгдүгээр хэлэлцүүлгээ Байнгын хороон дээр дуусгах шаардлагатай гэж бодоод байгаа юм.

Тэгэхээр тэртээ тэргүй саяын Д.Эрдэнэбат гишүүний ярьдгаар гуравдугаар хэлэлцүүлэг явагдаад дууслаа. Нэгдүгээр хэлэлцүүлэг хийгдлээ. Баталлаа. Буцаж гарлаа. Дахиад шилжих журмын хуулиа эцэслэн батлах асуудал тусдаа яригдах асуудал юм гэж ингэж бодож байна.

С.Бямбацогт: Баярлалаа. Ерөнхийдөө гишүүд ойлголт авсан байх. Тэгэхээр ямар ч байсан Үндсэн хуулийнхаа нэмэлт, өөрчлөлтийн хэлэлцүүлэг болон дагаж мөрдөх журмын тухай хуулийн анхны хэлэлцүүлгийг өнөөдөр хийе. Чуулган дээр болон цаашид анхаарахдаа бид заавал Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийн эх болон дагаж мөрдөх журмын тухай хуулийг салгаж хэлэлцэх ёстой юм байна гэдэг ойлголтоор хэлэлцэх асуудалд орёё.

***Нэг. Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл
Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан нарын 62 гишүүн 2019.06.06-ны
өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг/***

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх асуудлыг хэлэлцье. Ажлын хэсгийн гишүүдийг оруулъя.

Та бүхэнд хэлэлцэх дэгтэй холбогдуулаад тодорхой хуулийн заалтуудыг тайлбарлаад өгье. Ердийн хуулиас өөр дэгээр хэлэлцдэг учраас Та бүхэн бас тодорхой ойлголттой болох нь зөв болов уу гэж бодож байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 24⁶.1-д Төрийн байгуулалтын байнгын хороо дараах журмаар Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг нэгдсэн хуралдааны гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэнэ.

24⁶.1.1. Нэгдсэн хуралдааны хоёр дахь хэлэлцүүлгээр Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний гурваас доошгүйн дэмжлэг авсан саналыг Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлд нэмж тусган эцсийн хувилбар болгон гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай санал дүгнэлт гаргах;

24⁶.1.2. Энэ хуулийн 24⁶.1.1-д заасан Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл, санал дүгнэлтийг Байнгын хорооны гишүүдэд гурваас доошгүй хоногийн өмнө урьдчилан тарааж хуралдаанаар хэлэлцэх;

24⁶.1.4. Энэ хуулийн 24⁶.2-т заасан үндэслэлээр Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн зүйл, хэсэг, заалтыг баримтлан санал хураалт явуулах бөгөөд Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүйн дэмжлэг авсан саналыг Байнгын хорооны санал, дүгнэлтэд тусгана гэсэн ийм дэгээр өнөөдрийн Байнгын хорооны хуралдаан явагдана.

Ажлын хэсэг хүрэлцэн ирсэн байна. Ажлын хэсгийг Та бүхэнд танилцуулъя. Ц.Товуусүрэн Улсын Бага Хурлын гишүүн, Улсын Их Хурлын

гишүүн асан, ажлын дэд хэсгийн ахлагч, Р.Хатанбаатар Ардын Их Хурлын депутат, Улсын Бага Хурлын гишүүн асан, ажлын дэд хэсгийн ахлагч, Н.Лувсанжав Монгол Улсын гавьяат хуульч, дэд ажлын хэсгийн ахлагч, О.Мөнхсайхан Монгол Улсын Хууль зүйн сургуулийн багш, хууль зүйн ухааны доктор, дэд ажлын хэсгийн ахлагч, Д.Ламжав Ардын Их Хурлын депутат асан, А.Бямбажаргал Монгол Улсын их сургуулийн Хууль зүйн сургуулийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, профессор, хууль зүйн ухааны доктор ийм дэд ажлын хэсэг хүрэлцэн ирсэн байна.

Та бүхэндээ Төрийн байгуулалтын байнгын хороо гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг хийе.

Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан нарын нэр бүхий 62 гишүүнээс 2019 оны 06 дугаар сарын 06-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурал 2019 оны 08 дугаар сарын 28, 29, 09 дүгээр сарын 04, 05, 07-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар явуулж хэлэлцүүлгийг амжилттай хийлгэж дуусгасан.

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт оруулах журмын тухай хуулийн 17.1-д Улсын Их Хурал төслийн хоёр дахь хэлэлцүүлэг хийж дуусаад тухайн нэмэлт, өөрчлөлтийг ард нийтийн санал асуулгаар батлах уу, гурав дахь хэлэлцүүлгээр батлах уу гэдгээ нийт гишүүний гуравны хоёроос доошгүйн саналаар шийдэхээр заасан. Үүний дагуу төслийг ард нийтийн санал асуулгаар явуулах нь зүйтэй гэж Улсын Их Хурлын нийт гишүүний гуравны хоёроос доошгүй хувь нь тогтсон болно.

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн дагуу ард нийтийн санал асуулгад оруулах төслийн нэг, хоёр дахь хэлэлцүүлгийг явуулж, ард нийтийн санал асуулга явуулах Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн эхийг батлах тухай 73 дугаар тогтоол баталсан.

2019 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Улсын Их Хурлын 73 дугаар тогтоолд бүхэлд нь хориг тавьсан.

Улсын Их Хурал Ерөнхийлөгчийн хоригийг 2019 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэн хүлээн авах нь зүйтэй гэж үзэж, ард нийтийн санал асуулга явуулах Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн эхийг батлах тухай Монгол Улсын Их Хурлын 2019 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 73 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсон болно.

73 дугаар тогтоол хүчингүй болсноор журмын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн дагуу явуулсан хоёр дахь хэлэлцүүлгээр дэмжигдсэн 19 зүйл, 35 заалт бүхий төслийг гурав дахь хэлэлцүүлэгт оруулах хууль зүйн үр дагавар үүссэн. Ингэснээр Улсын Их Хурал төслийг гурав дахь хэлэлцүүлэгт шилжүүлэн гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг, хугацааг тогтоосон Улсын Их Хурлын тогтоолыг баталсан болно.

Төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх хүрээнд Монгол Улсын Их Хурлын даргын 199 дүгээр захирамжаар байгуулагдсан зөвшилцлийн ажлын хэсэг нь 2019 оны 09 дүгээр сарын 30, 10 дугаар сарын 07, 08, 09, 11 дүгээр сарын 05, 12-ны өдрүүдэд нийт 7 удаа хуралдаж, тодорхой асуудлаар зөвшилцөлд хүрч, санал нэгдсэн бөгөөд зарчмын шинжтэй хоёр саналыг Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг хэлэлцүүлэх, бэлтгэх үүрэг бүхий Улсын Их Хурлын 2019 оны 68 дугаар тогтоолоор байгуулагдсан ажлын хэсэгт танилцуулж, уг саналыг Байнгын хорооны хуралдаанд оруулахыг ажлын хэсгийн хуралдаанд оролцсон гишүүд санал нэгтэй дэмжсэн болно.

Ард нийтийн санал асуулгын нэг хоёр дахь хэлэлцүүлгээс санал хурааж Улсын Их Хурлын нийт гишүүний гуравны хоёроос доошгүйн саналаар дэмжигдсэн тодруулга хийсэн болон найруулга, редакцийн шинжтэй нийт 11 саналаар дахин санал хураалт явуулах шаардлагатай байна.

Төрийн байгуулалтын байнгын хороо болон Улсын Их Хурлын Тамгын газар Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуульд заасны дагуу гурав дахь хэлэлцүүлгийн бэлтгэл ажлыг хангах хүрээнд Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг дараах байдлаар товч болон зурагт танилцуулга, анимейшн зэргийг бэлтгэн тараасан бөгөөд 2019 оны 10 дугаар сарын 26-ны өдөр төслийг энгийн хувилбарын хамт нийт Улсын Их Хурлын гишүүдэд, түүнчлэн хоёр дахь хэлэлцүүлэгт дэмжигдсэн саналыг тусгасан төсөл болон санал, дүгнэлтийн төслийг Байнгын хорооны гишүүдэд урьдчилан тараасан болно.

Байнгын хороо гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг Та бүхэнд хийж дууслаа.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Одоо 11 саналаар санал хураалт явагдана. Санал хураалт. Дэгийн хуулиар асуулт байхгүй. Гэхдээ яах вэ, гишүүд саналууд дээрээ асуугаад явж болох байх. Д.Эрдэнэбат гишүүн горимын санал.

Д.Эрдэнэбат: Ажлын хэсгийн оруулж ирж байгаа нэмэлт, өөрчлөлтийн төслийн талаарх саналын томъёолол дээр ийм санал байна. Ардчилсан нам гуравдугаар хэлэлцүүлэгт орохдоо 3 зарчмын санал тавьсан.

Нэгдүгээрт нь, Ерөнхий сайдыг Засгийн газраа бүрдүүлэх. Хоёрт нь, сонгуулийн холимог тогтолцоотой байх. Гуравт нь, Ерөнхийлөгчийг парламентаас сонгох гэж.

Өчигдөр ажлын хэсэг дээр зөвшилцөөд, ярилцаад Ерөнхийлөгчийг парламентаас сонгох асуудал дээр бас ойлголцолд хүрээгүй орхисон байгаа. Би тэгж ойлгож байна.

Хамгийн эхлээд бидний ойлголцсон юм гэхээр Ерөнхий сайд Засгийн газрын гишүүнийг бүрдүүлэх асуудал дээр зөвшилцөл болж ойлголцсон.

Өчигдөр ажлын хэсэг дээр холимог тогтолцооны саналын томъёоллыг ерөнхийд нь дэмжиж ойлголцсон гэж ойлгож байгаа.

Тэгэхээр саналын томъёоллын асуудал дээр эхлээд Ардчилсан намын тавьсан зарчмын гурван саналын хоёр нь орсон энэ асуудал дээр эхэлж санал хураалгая гэсэн ийм горимын санал байна. Одоо итгэлцлийн үүдэн дээрээс. Тэгэхгүй бол бүгдийг нь хураалгаад очихоор нөгөө санал дээр очоод нөгөө тийш нь дарчих магадлал их өндөр байгаа.

Тэгэхээр зарчмын хувьд зөвшилцлийн ажлын хэсэг дээр ойлголцсон томъёоллоороо цаашдаа ч гэсэн тэр, чуулган дээр ч гэсэн тэр ойлголцсон томъёоллоороо санал хураагаад тэгээд цаашаа явдаг юм руу оръё гэсэн ийм горимын санал байна. Хурлын дарга аа.

С.Бямбацогт: Зарчмын шинжтэй зөвшилцөж Монгол Улсын Ерөнхийлөгч, Ардчилсан намын зөвлөл, Улсын Их Хурал дахь ШИНЭ намын зөвлөл, Монгол Ардын намын бүлгийн төлөөллүүд зөвшилцсөн. Сая танилцуулгад дурдсан. Нэлээн хэдэн удаа зөвшилцөж ойлголцсон. Ардчилсан намаас тавьсан 3 саналаас 2 саналыг нь хүлээж авч Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд тусгаж болох гэдэг дээр ойлголцсон байгаа. Мөн бас Монгол Улсын Ерөнхийлөгчийг ард түмнээс биш парламентаас сонгох гэдэг санал дээр ойлголцол, бидний зөвшилцөл ойлголцолд хүрээгүй. Тийм болохоор Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд тусгах бололцоогүй гэж үзсэн байгаа.

Тэгэхээр зарчмын шинжтэй. Урд нь найруулгын 6 санал байж байгаа. Мөн дэд ажлын хэсгээс гаргасан найруулгын чанартай 2 санал, ажлын хэсгийн саналын дагуу тодотгох найруулгатай 2 санал, хуралдаанд даргалагч санал хураалтын үед өгсөн чиглэлийн дагуу 1 гэсэн саналууд хураагдана.

Энэ бол урд нь ард нийтийн санал асуулга, Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн эхийг батлах 73 дугаар тогтоолыг хэлэлцэх үед хураагдсан саналууд. Эдгээрээр дахин санал хураана. Үүнээс гадна сая зөвшилцсөн 2 саналаар санал хураагдах ёстой юм. Тийм болохоор Д.Эрдэнэбат даргын хэлж байгаа зөвшилцлийн итгэлцлийн үүднээс саналын томъёоллоор саналыг дэмжээд явах нь зүйтэй болов уу гэж бодож байна. Тийм болохоор горимын саналаар санал хураалт явуулъя. Д.Эрдэнэбат даргын, гишүүний гаргасан. Горимын саналаар санал хураагаад дараад нь. Санал хураалт. Дэмжье гэсэн томъёоллоор. Горимын саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 14 гишүүн оролцсоноос 12 гишүүн буюу 85.7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Одоо санал хураалтуудыг явуулъя. Хураагдаж байгаа саналууд дээр гишүүд асуултаа асуугаад үгээ хэлээд явъя.

Би Та бүхэнд бас хуулийн заалт уншиж танилцуулъя. Санал хураалт явуулахын өмнө. Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 24^б-ийн 2-т Байнгын хороо энэ хуулийн 24^б-ийн 1-д заасан гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэхдээ зөвхөн дараах тохиолдолд санал хураалт явуулж

болох бөгөөд Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүйн саналаар хэлэлцэж шийдвэрлэнэ. 24⁶-ийн 2.1 нэгдсэн хуралдаанаар хоёр дахь хэлэлцүүлэг явуулах үед төслийн зарим зүйл, хэсэг, заалтыг гүйцээн боловсруулах чиглэл хуралдаанд даргалагчаас өгсөн, 24⁶-ийн 2.2 энэ хуулийн 24⁵-ийн 4 дэх хэсэгт заасан санал дүгнэлт, 24⁶-ийн 2.3 нэгдсэн хуралдааны хоёр дахь хэлэлцүүлгээр санал хурааж шийдвэрлэсэн боловч уг асуудлаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэн. 24⁶-ийн 2.4 Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн зүйл, хэсэг, заалтад найруулгын засвар хийсэн. 24⁶-ийн 3 Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дэмжлэг аваагүй бол зарчмын зөрүүтэй саналыг төсөлд тусгах шаардлагагүй гэж үзсэн үндэслэл шалтгаанаа Байнгын хороо санал, дүгнэлтээ тусгана. 24⁶-ийн 4 энэ хуулийн 24⁶-ийн 1.4; 24⁶-ийн 2-т зааснаас бусад үндэслэлээр нэгдсэн хуралдааны хоёр дахь хэлэлцүүлгээр дэмжигдсэн саналыг өөрчлөх буюу хүчингүй болгох санал, дүгнэлт гаргахыг хориглоно.

Ийм дэгээр хуралдаан санал хураалтууд цааш явагдана гэдгийг та бүхэнд урьдчилж танилцуулъя.

Горимын санал дэмжигдсэнтэй холбоотойгоор Зөвшилцлийн ажлын хэсгээс гаргасан саналуудаар эхэлж санал хураалт явуулъя.

12 дахь санал байгаа. Та бүхэнд тараасан материалын. Хоёр дахь хэлэлцүүлгийн дараах төсөлд дор дурдсан агуулгатай Гучин есдүгээр зүйлийн 4 дэх хэсэгт нэмэх. Гишүүдийн ирц бүрэн байна уу? Тийм ээ.

“4.Засгийн газрын гишүүнийг Улсын Их Хурал, Ерөнхийлөгчид танилцуулснаар Ерөнхий сайд томилж, чөлөөлж, огцруулна. Засгийн газрын гишүүн Улсын Их Хуралд тангараг өргөнө.”

Энэ санал дэмжигдсэн тохиолдолд хууль хооронд нийцүүлэх үүднээс 13.а санал гээд доод талд нь бичигдсэн байгаа. Энэ саналаар дараад нь санал хураах шаардлагатай болно.

Та бүхэнд зарчмын зөрөөтэй саналын томъёоллыг уншиж танилцууллаа. Холбогдуулж. Үгүй. Одоо дэмжигдэх юм бол. Гуравны хоёроор дэмжигдэх юм бол дэмжигдсэнд тооцогдоод явагдана. Үг хэлж болно. Одоо энэ саналыг гишүүд гаргах гишүүд нь санал хураагдаж гаргах нь байна. Гуравны хоёроос доошгүй нь. Үүнтэй холбогдуулж эхлээд саналаа хураачаад санал дээрээ үгээ хэлэх үү. О.Баасанхүү гишүүн.

О.Баасанхүү: Би санал хураахтай холбоотой үг хэлье. Би эхлээд яагаад ийм асуудал ярих гэж байгаа вэ гэхээр Улс төрийн намын тухай хууль дээр сонгуулийн үр дүнгээр нам, эвслийн бүлэг байгуулагдаж. Хэрэв нам, эвслийн бүлэг задрах юм бол бие даагчид болдог.

Сонгуулийн үр дүнгээр Монгол Ардын Хувьсгалт нам, Монгол Ардын нам, Ардчилсан нам гээд гурван нам сонгуулийн үр дүнгээр парламентыг бүрдүүлж байгаа. Нэг бие даагчтай. Харамсалтай нь зөвшилцлийн ажлын хэсэг гэдэг

хууль бус юм гаргаад, тэндээ Монгол Ардын Хувьсгалт намыг оруулаагүй. Энэ бол үнэн.

Тэгэхээр миний асуух гээд байгаа зүйл нь яах вэ ухаантай хүмүүс нь тусдаа хурлаа хийгээд юмаа шийднэ биз дээ гээд харсан чинь 62 гишүүний санал болгосон хуулийн заалтыг ард түмнээсээ асуугаад, кнопдоод, ард түмэн үнэхээр “за” гэж байгаа бол тэр чигт нь баталъя гэсэн чинь, ороод ирсэн чинь арван хэдэн саналыг нэг ёсондоо хоёрдугаар хэлэлцүүлэгт огт яриагүй, яриад шийдсэн асуудлыг дахин хөндөж орж ирээд байгаа байхгүй юу.

Одоо сая Их Хурлын дарга зөв хэлж байна шүү дээ. Хэн тэгээд энийг чинь өргөн бариад байгаа юм. Ажлын хэсгийн саналаар гэх юм уу. Тэгвэл ажлын хэсгийг чинь хэн баталсан юм. Ямар захирамжаар баталсан юм. Монгол Улсын Ерөнхийлөгч хориг тавьж байгаа нь тавьсан хоригийг хүлээж авсантай холбогдуулан өөрчлөлт хийнэ гэх юм бол Ерөнхийлөгчийн тавьсан хоригийн хүрээнд өөрчлөлт хийх тухай яриа байгаа. Тэрнээс биш өнөөдөр ингээд Ардчилсан нам дургүйцээд байна, жагсаалтын хууль оруулъя гэж байна, Ерөнхий сайдыг ярья гэж байна, Ерөнхийлөгчийг парламентаас сонгоё гэж байна. Энэ дээр нь бүгдээрээ ярья гэж ард түмний тархийг угаангуутаа сөргүүлээд өөрсдийнхөө ингээд юу гэдэг юм төрөөр тоглож байгаа. Дээрээс нь Улсын Их Хурлаар тасралтгүй явж батлах ёстой байсан зарчмуудыг байхгүй болгоод. Тэгээд одоо яг энэ дээрээ ямар саналаар хураах вэ. Одоо энийг эхлээд үүнийг хураах уу үгүй юу, ярих уу үгүй юу, бүр ийм утгагүй байдалд хүртэл оруулж байна шүү дээ. Бид Үндсэн хуульдаа гар хүрч байгаа байхгүй юу.

Хэрвээ Үндсэн хуульдаа гар хүрч байгаа бол, зөвшилцөж байгаа бол энэ Улсын Их Хурлыг бүрдүүлж байгаа нам, эвслийн бүлгүүдийн хооронд зөвшилцөл явах ёстой болохоос. Хуульд огт байхгүй. Жишээлбэл, өнөөдөр би нэг нам байгуулаад дахиад л зөвлөл гээд нэрлээд орох уу. Ямар хууль дээр зөвлөл гэж хуулийн заалт байгаа юм. ШИНЭ намын зөвлөл ч гэх шиг. Хоёр шинэ галзууг оруулчихсан. Тэгээд тэрийгээ бас зөвлөл гэж яриад байгаа шүү. Ингэж төрөөр тоглохоо боль. Энэ чинь түүхэнд үлдэнэ.

Угаасаа намууд зөвшилцөж байгаа бол энэ парламентад суудалтай намууд зөвшилцье. Эвсэл, бүлгээр зөвшилцөж байгаа бол эвсэл, бүлгээ хамтад нь оруулаад зөвшилцье. Дээрээс нь өнөөдөр энэ тодорхой заалтуудаар сайжруулах. Мэдээж энэ Монгол төрийг тогтвортой байлгая гэдэг асуудлаар ярих гэж байгаа бол энэ нийт ард түмнээрээ зөвшилцье.

Энэ байдал чинь сонгуулийн үр дүнгээр байгуулагдсан гээд байгаа энэ нөхцөл байдлыг өнөөдөр парламентад эрх мэдэл авангуутаа дураараа өөрчилж, дураараа ярих эрх байхгүй. Одоо тэгээд юу вэ гэх юм бол дөнгөж одоо л ярих гэж байна л даа. Тэр юу вэ гэвэл хуучин хоёрдугаар хэлэлцүүлгээр хийсэн саналыг өөрчлөх асуудлаар санал хураах гэдэг чинь нөгөө ажлын хэсгийг байгуулахын өмнөх ярих гуравны хоёр байхгүй юу. Ийм ийм заалтуудаар бүгдээрээ ярьж болох уу гэж. Ярьж болно гээд гуравны хоёроор шийдчихлээ. Шийдэж байгаа бол тэгвэл одоо суугаад зөвшилцье. Ийм л асуудал байгаа байхгүй юу.

Тэрнээс биш та нарын хуйвалдааныг бид нар өнөөдөр батлах гэж энэ ордонд суугаад, энд өнөөдөр юу гэдэг юм сонгуулийн үр дүн гэж ярих эрх байхгүй. Тийм учраас өнөөдөр ийм бохир зүйл хийхээ болиоч ээ гэдгийг анхааралтай авч хэлмээр байна.

Тийм учраас энэ зөвшилцөхдөө Монгол Ардын Хувьсгалт намыг оруулах ёстой гэдгийг хатуу анхааруулж хэлмээр байна.

С.Бямбацогт: Энэ дээр тайлбар хийхгүй бол жаахан буруу ойлголт яваад байх шиг байна.

Энэ одоо хураагдах гэж байгаа арав гаруй саналуудын дийлэнх нь буюу хоёрхон саналаас бусад нь 73 дугаар тогтоолоор батлагдсан ард нийтийн санал асуулга явуулах тухай болон Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн эхийг батлах тухай 73 дугаар тогтоолыг хэлэлцэж байх үед санал хураагдсан, дэмжигдсэн ийм саналууд байгаа.

Тэгэхээр 73 дугаар тогтоол маань хүчингүй болж байгаа учраас дахиж гурав дахь хэлэлцүүлэгт хураах шаардлага үүссэн. Энд ямар нэг засвар, өөрчлөлт, үг үсэг өөрчлөгдсөн зүйл нэг ч юм байхгүй.

Дараад нь хураагдах гэж байгаа зөвшилцлөөс 3 санал, Ардчилсан нам гаргасан 3 саналаас 2 санал нь саналаар хураагдах гэж байгаа. Энэ 2 санал хураалт бол Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд анхнаасаа байсан. Хоёр дахь хэлэлцүүлгийн явцад олонхийн дэмжлэг аваагүй ийм санал.

Энэ саналыг бид нар Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль болон Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуульд заасны дагуу одоо гишүүд хэрвээ дэмжих юм бол цааш нь санал хураагдана. Дэмжихгүй бол санал хураагдахгүй. Гишүүд энэ саналыг гаргая гэсэн гишүүдийн гуравны хоёроос дээш гаргая. Энийг бас ярих нь чухал, зөв гэж үзэх юм бол энэ саналыг дэмжсэн гишүүд гаргаад зарчмын зөрөөтэй саналын томъёоллоор санал хураагдана. Дэмжихгүй бол хураагдахгүй. Үүнийг Та бүхэн бас ойлгоорой.

Зөвшилцлийн ажлын хэсэг хуралдсан. 68 дугаар тогтоолоор байгуулагдсан ажлын хэсэг хуралдсан. 199 дүгээр тогтоол гаргасан ажлын хэсэг хуралдсан. Тийм болохоор бас ойлголтын зөрүүг арилгах үүднээс энэ мэдээллийг Та бүхэндээ хэлье.

Саяын уншиж танилцуулсан саналыг гаргая гэдэг гишүүд одоо дэмжих, дахиж санал хураалт явагдана. Асуудлаар нь.

Тэгэхээр хоёр дахь хэлэлцүүлгийн дараах төсөлд доор дурдсан агуулгатай 39 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийг нэмэх гэсэн саналыг гаргая гэсэн гишүүд саналаа өгнө үү. Дахин санал хураалтад оруулъя гэдгийг дэмжих тийм үү.

Засгийн газрын гишүүнийг Улсын Их Хурал, Ерөнхийлөгчид танилцуулснаар Ерөнхий сайд томилж, чөлөөлж, огцруулна. Засгийн газрын

гишүүн Улсын Их Хуралд тангараг өргөнө гэсэн хоёр дахь хэлэлцүүлэг явсан, унасан энэ саналыг дахиж оруулъя гэдгийг дэмжиж байгаа гишүүд саналаа. Санал хураалт явуулъя. Гуравны хоёроор босох юм бол дэмжигдэнэ. Санал хураалт.

Санал хураалтад 16 гишүүн оролцсоноос 15 гишүүн буюу 93.8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Энэ санал дэмжигдсэн тул одоо энэ 15 гишүүний гаргасан санал болгоод энэ зарчмын зөрүүтэй саналыг дахиж хураалгана. Үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Ж.Мөнхбат гишүүнээр тасаллаа. О.Баасанхүү гишүүн.

О.Баасанхүү: 12 гэдэг тоон дээр өнөөдөр дөрөв дэх хэсгийг нэмэх гээд оруулж ирж байна. Сая ажлын хэсэг гэдэг зүйлээ өнөөдөр сая албажуулсан байдлаар оруулж ирээд энийг ярьж гээд хэлж байгаа учраас ярих гэж байгаа асуудал дээр протоколд асуудал оруулж хэлье.

Монтескьён /Шарль Луи де Монтескьё/ онолоор өнөөдөр засаглалын гурван хэлбэр байдаг. Улсын Их Хурал, Засгийн газар, шүүх гээд. Хэдийгээр бие даасан тусдаа байлаа ч гэсэн институцийн хувьд хоорондоо аль нэг нь төрийн эрх барих дээд байгууллага буюу төрийн өнөөдөр засаглалын хэлбэр нь тодорхой байх ёстой.

Өнөөдөр энэ заалтыг ингээд уншаад үзэх юм бол Засгийн газрын гишүүнийг танилцуулах юм байна. Ийм хүн орж байгаа шүү гээд утсаар хэлэх юм байна л даа. Эсвэл орж ирээд ямар мэнгэтэй юм, нөгөө нэг юу гэдэг юм ямар зүстэй юм, царайтай юм, нөгөө У.Хүрэлсүх гээд нөгөө сэлэмтэй, жадтай нөгөө залуу мөн үү, цэргийн энэ тэрээ юу гээд амандаа баахан юм яриад за танилцлаа танилцлаа, уг нь чамайг сонгоод дэмжмээргүй л байна, эсвэл дэмжье гээд хэлэх ямар ч боломжгүй. Танилцаж байгаа юм чинь. Цаасаар өгөхөд л болох юм байна л даа.

Тэгсний дараа нөгөө хүнээ юу вэ гэхээр Ерөнхий сайдаа Засгийн газрын гишүүн чөлөөлж, Ерөнхий сайдаа томилж, чөлөөлж, огцруулаад Ерөнхий сайд нь доошоо хүмүүсээ томилж, огцруулна гээд. Одоо манайд өнөөдөр аймшигтай сайдууд байгаа. Тэмбүүдсэн гэж хэлж болно. Өчнөөн өвчтэй болсон. Өчнөөн хүн өнөөдөр аваар осолд ороод 8, 9-өөрөө өнөөдөр нас бараад хууль хяналтын байгууллагаар шалгах ёстой асуудлууд байгаа. Саарал жагсаалтад орлоо гээд асуудал. Яриад л байдаг яриад л байдаг. Огцруулаач ээ. Одоо зүгээр наад зах нь саарал жагсаалт хоёр сайдыг шийдье. Энэ хариуцлага тооцье гэхээр нөгөө Ерөнхий сайд бол ордоггүй. Яаж хариуцлага тооцох юм?

Засгийн газрыг өнөөдөр дахиад огцруулъя даа энэ нөгөө хоёроо огцруулдаггүй гээд. Хоёрхон хүнээс болж 14 хүнийг, 13 нь ч юм уу, 12 нь ч юмуу магадгүй сайн ажиллаж байж болно. Нөгөө хоёр гайгаа чөлөөлөхгүй байснаас болоод ингээд Засгийн газраараа тоглоё гээд. Одоо тэгээд сайжирсан нь хаана байгаа юм.

Одоогийн Үндсэн хууль дээр тодорхой бичээгүй ч үгүй гэсэн бид нар Засгийн газрын тухай хуулиараа шүд сугалдгийг болиуллаа гээд Ланд машиныг

тухайн үеийн Үндсэн хуулийн цэцийн дарга Ж.Амарсанаад өгсөн. Тэгээд Ж.Амарсанаагаа мулталсан. Тэгээд сайдыг огцруулдаггүй жаргаж байгаа гэсэн. Одоо жаргаж байгаа нь хаана байгаа юм.

Бүгдээрээ аман дээр очоод өнөөдөр яриад байгаа шүү дээ. Бид нар ямар ч байсан энэ энэ сайдыг чөлөөлчихвөл. Уг нь 6 сар юм даа. Нам нь 64 юм даа. Одоо өөрсдөө шийднэ биз дээ гээд байхгүй. Энэ зовлон байж байхад дахиад Үндсэн хууль дээрээ оруулж ийм утгагүй юм хийж явах ямар хэрэгтэй юм бэ? Нэгдүгээр асуудал ийм байна.

Хоёрдугаарт нь, хэнийг томилохоо бид мэдэхгүй. Одоо яагаад гэвэл томилж, чөлөөлөхгүй юм чинь бид тэр Их Хурал дээр нэг сонссон чинь Сангийн сайд нь нэг хүн байгаа юм билээ. Хөөрхий дипломгүй л юм гэж дуулсан. Одоо яах вэ дээ, Хэнтийн талын хамаатан нь юм байлгүй дээ. Найз нөхөд нь юм байлгүй дээ. 60 тэрбумаа өгсөн байхаа гээд л шар мэдээний хэмжээнд сонсоод. Тэгээд нөгөө хүн нь Монгол төрөөр тоглоод явах юм байна л даа.

Тэгэхээр ийм нөхцөл байдлууд зөндөө байгаа. Ийм нөхцөл байдлууд нэлээн гарч ирнэ. Тэгээд дахиад нөгөө бужигнаан. Дахиад л нөгөө асуудлууд. Тэгээд юу нь энд тийм чухал хэрэгтэй болоод ингээд яваад байгаа нь ойлгомжгүй. Дээрээс нь өнөөдөр хуйвалдаанаа зогсоогооч ээ. Зөвшилцөнө гэдэг бол ярилцана. Зөвшилцөнө гэдэг бол онолын хувьд, практикийн хувьд, нөхцөл байдлын хувьд ойлголцоно, тохиролцоно гэсэн үг. Олонхоороо шийднэ гэсэн үг. Түүнээс биш ганцаараа сонгогдсон юм чинь галзуу гэдэг нэр өгөөд хөөж гаргана гэсэн үг биш. Эсвэл үгийг нь тасална гэсэн үг биш. Эсвэл янз бүрийн хууль хяналтын байгууллагаар сүрдүүлнэ гэсэн үг биш. Эсвэл өнөөдөр ямар нэгэн байдлаар Засгийн газрын Үндсэн хуулийн хэлэлцүүлэгт оруулахгүй гэсэн үг биш.

Тийм учраас хүний олон хүнээ барихгүй, намын олон намайг дээрэлхэхгүй. Одоо Та бүхэн ямар ч байлаа гэсэн энэ дарамталж байгаа энэ байдлаар хоорондоо ярьсан нэрээр зохион байгуулалттайгаар Засгийн газрын гэдэг нэрээр. Одоо удахгүй Жагсаалын хууль орж ирэх юм байна билээ. Удахгүй өнөөдөр энэ хэлэлцүүлэг дотор орж ирсэн овоо гайгүй байсан юмаа балласан шүү. Одоо ард түмэнтэйгээ тэр 15-нд болох жагсаалд нь очиж үг хэлдэг юм уу яадаг юм. Харахад их л төвөгтэй хүмүүс байсан.

Гэхдээ өнөөдөр та нар намайг ингээд ямар ч зөвшилцөлдөө оруулаагүй, ямар ч ажлын хэсэгт оруулаагүй. Би ядаж хуульч хүн. Энэ хууль зүйн утгыг нь ядаж яриад байхад тэрийг нь хүлээж авдаггүй. Бичгээр саналууд өгсөн. Нэг ч саналуудыг тусгаагүй. Нэг ч нөхцөл байдлыг нь аваагүй. Тэр дээр чинь бас эрдэмтэн доктор С.Нарангэрэл багшаас эхлээд мэдлэгтэй, боловсролтой. Энэ ордонд л дандаа ухаантай хүн байдаггүй юм шүү дээ бас. Гудамжинд ч гэсэн бас гайгүй хүмүүс байдаг. Тэр гудамжны гээд байгаа сүрхий хүмүүсээс чинь судалгаа аваад, мэдлэгийг нь аваад хийгээд санал хэлээд байхад юу ч байхгүй. Тэгээд одоо орж ирж байгаа зүйл нь ухралт. Өөрөөр хэлэх юм бол парламентыг хүчингүй болгож, шап шофтоо орох л юм байна л даа.

Одоо сая бас 30 хоногоор өнөөдөр юу гэдэг юм тэр нөгөө визгүй зорчуулья гээд байсан парламент дээр орж ирсэн учраас бид өнөөдөр Ө.Энхтүвшин гэдэг сайдад хариуцлага тооцох уу, яах вэ гээд ярих эрхтэй учраас

тэр хүн бас айхгүй ч гэсэн аягүй байдлаар ярьж байсан. Одоо бол Ерөнхий сайдтай ярьсан учраас би хамаагүй гээд л явчих юм байна шүү дээ.

Ямар ч баталгаа, нотолгоо байхгүй. Тэр Шадар сайд нь сайн хүн байх уу, Сангийн сайд нь сайн хүн байх уу, Хууль зүйн сайд нь сайн хүн байх уу гэдгийг чинь ард түмэн хяналтдаа байлгая гээд байна шүү дээ. Ард түмэн хяналтдаа байлгана гэдэг чинь ард түмэн гэдэг чинь төлөөллийн ардчиллаараа сонгогдоод, сонгоод ирсэн гишүүнээрээ дамжуулж хяналтаа тавина шүү дээ. Тэрнээс биш ард түмэн гээд ордонд орж ирээд мянгаараа, зуугаараа орж ирээд та нар тэг ингэ гэдэг ч юм биш.

Тийм учраас өнөөдөр ард түмний хяналтыг байхгүй болгож, ард түмний засаглалыг байхгүй болгож, өнөөдөр албан тушаалтны тийм засаглал руу орж байна л даа. Энэ нь эргээд феодалын дэглэм рүү орно шүү. Одоо үр удмуудаа та нар тэгээд янз бүрийн байдлаар улс төр рүү оруулаад эцэст нь тэгээд сайдаар л тавих нь л дээ. Тэрний Ерөнхий сайдын хамаатан буюу Ерөнхий сайдтай ойр байж байгаа хүн ингээд сайд болно биз дээ гэж. Ийм утгагүй байдлаар өнөөдөр явж байгаад харамсаж байна. Ард түмэндээ гарч үгээ хэлнэ.

С.Бямбацогт: Энэ заалт бол Засгийн газрын гишүүнийг Улсын Их Хурал, Ерөнхийлөгчид танилцуулснаар Ерөнхий сайд томилж, чөлөөлж, огцруулна гэсэн энэ заалт бол Д.Лүндээжанцан нарын 62 гишүүний төсөлд байсан заалт. Өргөн барьсан төсөлд. Өргөн барьсан төсөлд байсан. О.Баасанхүү гишүүн бас өөрөө бас гарын үсэг зурсан. Та бас оролцоод гарын үсэг зурсан.

Танилцуулснаар гэдэг маань одоо өнөөдөр ямар болчихоод байгаа юм гэвэл Улсын Их Хуралд нэр бүхий сайд болгоноор нэг бүрчлэн томилдог, чөлөөлдөг, огцруулдаг. Ингэхийн тулд Улсын Их Хурлын гишүүд Улсын Их Хурал дахь бүлэглэл, фракцад таалагдсан хүнийг Ерөнхий сайд оруулж ирэхгүй бол асуудал болдог. Оруулаад батлагдсаных нь дараа одоо яг өөрийн чинь хэлж байгаагаар тийм үү, 14 нь сайн ажиллаад байдаг, 2 сайд нь муу ажиллаад байх юм бол 2 сайдаа чөлөөлье гэж Их Хуралд оруулахаар Их Хурал нь нөгөө бүлэглэл, фракцынхаа сайдыг хамгаалдаг учраас Ерөнхий сайд нь тэрийгээ чөлөөлж чаддаггүй. Өнөөдрийн бодит процесс ч гэсэн ийм л байж байгаа.

Тийм болохоор Ерөнхий сайд нь парламентын өмнө өөрийнхөө толгойгоор хариуцлагаа хүлээдэг байя. Өөрөө сайд нартаа хариуцлагаа хүлээлгэдэг байя гэдэг агуулгаар энэ олон жил яригдсан асуудал. Урд өмнө болж байсан асуудал. Ерөнхий сайддаа захирагддаггүй олон сайд нар байдаг. Яагаад гэвэл би Их Хурлаас томилогдсон. Чамтай адилхан Их Хурлаас томилогдсон учраас чи надад заагаад байхгүй. Чи надад хариуцлага тооцож чадахгүй гэдэг. Тийм учраас Ерөнхий сайдыг бас эрх мэдэлтэй байлгая. Хяналт тэмцлийг нь нэмэгдүүлье гэдэг үүднээс орж ирсэн.

Танилцуулна гэдгийг та юу гэдэг юм утсаар танилцуулна гэж битгий мушгиж ярь. Дээд шүүхийн шүүгч танилцуулдаг, Элчин сайдыг танилцуулдаг. Үүнтэй адилхан энэ дэгээр Улсын Их Хурлын чуулганы хуралдаанд нэг бүрчлэн асуулт асуугаад, үгээ хэлдэг энэ дэгээр явна. Ийм байдлаар ойлгоорой гэдгийг бас хэлье.

Ингээд Д.Хаянхярваа гишүүн асуултаа асууя.

Д.Хаянхярваа: Тэгэхээр Ардчилсан намаас оруулж ирсэн энэ зарчмын зөрөөтэй саналыг Ерөнхий сайд кабинетаа томилж, чөлөөлнө гэж байгаа. Үүнийг угаасаа хоёр дугаар хэлэлцүүлгийн үед би дэмжиж байсан. Энэ дээрээ тэнд бас цөөнх болсон. Энийг дэмжиж байгаа. Энэ зөв зүйтэй санал гэдгийг хэлмээр байна.

Энэтэй холбогдуулаад би юу хэлэх гэж байна гэхээр Ерөнхий сайдын эрх мэдэл нэлээн өргөн хүрээтэй болж байгаа. Их эрх мэдлийг дагаж их хариуцлага ирдэг гэж ярьдаг. Энэ дээр би юуг хэлэх байна гэхээр Ардчилсан намын гурав дахь саналаа татаж авсанд нь харамсаж байгаагаа илэрхийлж байгаа юм.

Аваагүй юм уу? Зөвшилцлөөр унасан юм уу. Энэ чинь надад татаж авсан гэж өглөө хүн тайлбарласан. Тэгвэл надад буруу тайлбарласан байна.

Үнэхээрийн энэ зөвшилцөл дээрээ энэ хэрвээ үнэхээр ингээд унаж байгаа бол энэ үнэндээ буруу байна. Би яагаад энийг ингэж хэлэх гээд байгаа юм бэ гэхээр уг нь бид нар үнэндээ Үндсэн хуулийн өөрчлөлтөө батлах ёстой гэдгийг би одоо 100 хувь хүлээн зөвшөөрч, дэмжиж байгаа. Энд ингээд бид нарын амьдралаас ингээд гарсан туршлагаас харахад манай засаглалын тогтворгүй байдал улс төрийн тогтворгүй байдал юунаас үүдэлтэй байна вэ гэхээр ерөөсөө л Ерөнхийлөгч, Засгийн газар хоёрын хоорондын эрх мэдэл тодорхой биш байдалтай байгаагаас болоод энэ зөрчил дутагдал өнөөдрийг хүртэл үргэлжиллээ.

Энэ өнөөдрийг хүртэл энэ үргэлжилж байгаа зөрчил бол одоо өнөөдрийн Х.Баттулга Ерөнхийлөгчийн үед бий болсон юм биш. Үе үеийн Ерөнхийлөгч нар өөрийн эрх мэдлийг нэмэгдүүлэх хуулийг оруулж батлуулсаар байж байгаад ийм болсон.

Би судалгаа гаргуулсан юм. Монгол Улсын Ерөнхийлөгчид Монгол Улсын Үндсэн хууль, Ерөнхийлөгчийн тухай хууль болон бусад хуулиар олгогдсон бүрэн эрх, үүрэг гээд энийг одоо ингээд судалгаа гаргаад үзэхэд бид нар одоо ингээд 46 хуулиар Улсын Их Хурал Монгол Улсын Ерөнхийлөгчид олгох эрх мэдэл, энэ юмнуудыг нэмэгдүүлж өгсөн байгаа юм. Үүнээс болоод гүйцэтгэх засаглалтайгаа эрх мэдлээ булаацалдах ийм юм руу Ерөнхийлөгчийн институц өөрийн эрхгүй өөрөө яваад орчихсон. Өнөөдөр уг нь бид нар хэрвээ одоо болдог байсан бол энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөрөө энэ хоёрыг салгах гарцаа байхгүй шаардлага байсан. Энэ бол өнөөдөр Монголчуудын хувьд бид нарын амьдралд тохиолдож байгаа гарцаагүй үнэн, гашуун ч гэсэн яг энэ мөн үү гэвэл гэвэл мөн.

Ерөнхийлөгчийг хэрвээ бид нар үнэхээр парламентаас сонгодог болоод Ерөнхий сайдынхаа эрх мэдлийг одоогийн энэ өгч байгаа эрх мэдлийнхээ хүрээн дотор нэмэгдүүлээд өгч чадсан бол гүйцэтгэх засаглал нь ч гүйцэтгэх засаглалынхаа түвшинд, хууль тогтоох байгууллага нь хууль тогтоох хүрээндээ, Ерөнхийлөгч нь Ерөнхийлөгчийнхөө хүрээн дотор ажиллаад, яг одоо бид нарын ярьдаг дуурайдаг Герман маягийн зөв хэв шинж рүүгээ ороод явах нөхцөл бүрдэх юм байна гэж би ингэж харж, энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг

хэлэлцэх эхний үеэс эхлээд Д.Лүндээжанцан даргад болон ажлын хэсэгт би байнга ийм саналыг тавьж байсан.

Өнөөдөр өглөө Ардчилсан нам татаад авлаа гэж Д.Тогтохсүрэн дарга надад хэлсэн шүү. Ер нь тэгээд энэ зөвшилцлөөрөө унасан юм байна. Тэгэхээр ингэж уг нь бие биедээ худлаа чулуу хөөлгөх хэрэггүй юм байгаа шүү. Яг одоо болсон юмаа. Энэ чинь Үндсэн хуулийн хэлэлцүүлэг. Зүгээр тоглоом биш. Үндсэн хуулийн хэлэлцүүлэг учраас зөвшилцөл дээр унасан гэвэл унасан гэдгээ хэлэх ёстой. Нэгэнт зөвшилцөөд унасан юм дээр бид нар энийгээ цааш хэлэлцээд явах нь зүйн хэрэг гэж нэг ийм зүйлийг би хэлье гэж бодож байна.

Ингэхлээр цаашдаа одоо энэ хоёр эрх мэдэл чинь ахиад зөрчилдсөөр байх болно. Дахиад зөрчилдсөөр байх болно. Тэгэхийн тулд бид нар Үндсэн хуулийнхаа нэмэлт, өөрчлөлтийг баталсныхаа дараагаар энэ Ерөнхийлөгчид олгогдсон эрх, үүргүүдээ цааш нь яах юм бэ гэдэг юмыг бас яаралтай авч үзэж энэ хуулиуддаа нэмэлт, өөрчлөлтөө оруулаад энэ Засгийн газар нь үнэхээр нэг эрх мэдэлтэй хэвийн ажиллах, өөрийнхөө толгойгоор ажиллах нөхцөл бололцоог бүрдүүлэхэд анхаарах ёстой гэдэг зүйлийг би онцолж нэг хэлмээр байна.

Хоёрдугаарт юу хэлмээр байна гэхээр, Ерөнхий сайд хүн намын дарга байна гээд ерөнхийдөө бичигдээгүй хуультай явж байгаа. Энэ эрх мэдлийг, их эрх мэдлийг тойроод улс төрийн хүчнүүд дарга тойрсон хэсэг бүлэглэлтэй болчих вий гэдэг болгоомжлолыг би хэлж байгаа юм. Ингэхийн тулд улс төрийн намууд дотоод ардчиллаа маш сайн хадгалж, улам боловсронгуй болгох тал руугаа явах ёстой. Улс төрийн нам дотоод ардчилалгүй болоод эхлэх юм бол үнэхээр гарцаа байхгүй эрх мэдэл бүхий намын дарга, Ерөнхий сайд, Засгийн газраа өөрөө томилж чөлөөлдөг, энэ их эрх мэдлийг дагаж хэсэг бүлэглэл үүсээд ингээд нам доторх зөрчил дутагдал магадгүй нөгөө мафижсан төр гэдэг юм уу одоо бид нарын яриад байдаг өнөөдрийн тэр байхгүй байгаа юмыг бий болгосоор байгаад хонгил манан болгоод явсан шиг юмнууд чинь жинхэнэ утгаараа бий болоод энэ төрийг чинь ажил бас өрөөсгөл тал руугаа явдаг ийм хандлага руу орчих вий гэдэг энэ болгоомжлолыг улс төрийн намууд, энд байгаа улс төрчид, Засгийн газрын тэргүүнээр цааш цаашдаа мэдээж сонгуулийн дараа ажиллах энэ улс төрийн байгууллага анхааралдаа авч энэ бүх зүйлүүдийг хууль эрх зүйн талаас нь өшөө цаашид явал боловсронгуй болгож, явал бид нар аль болох ардчиллын тодорхой элементүүдийг хэрэгжүүлж авч явахад боломжтой байх хууль эрх зүйн орчин бий болгох вэ гэдэг талаас нь бодож ажиллах нь зүйтэй байна гэсэн ийм саналыг хэлээд энэ саналыг дэмжиж байгаа гэдгээ хэлье.

С.Бямбацогт: Баярлалаа. Ж.Мөнхбат гишүүн асуулт асууж үгээ хэлье.

Ж.Мөнхбат: Монгол Улсын Ерөнхий сайд танхимынхаа сайд нарыг томилж, чөлөөлж, огцруулдаг энэ саналыг дэмжиж байгаа.

Бид нарын энэ өнөөдрийн өөрчилж байгаа Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт бол бид нарын өнөөдрийн баримталж байгаа Монгол Улсын Үндсэн хууль бол Монгол Улс парламентын засаглалтай улс. Энэ парламентын засаглалынхаа чадвар, чадавхийг сайжруулж нэмэгдүүлэх энэ чиглэлд бид нар

алхам хийж байгаа. Тийм учраас олон улсын, дэлхий нийтийн жишиг, чиг хандлагыг дагасан ийм ажил, алхам хийж, энэ шийдвэрийг гаргах нь зөв гэж бодож байгаа.

Өнөөдөр Японыг хар. Хөгжлөөрөө дэлхийд ямар билээ. Ёс суртахуунаараа, улс төрийн соёлоороо. Германыг хар. Бүх сайд нараа танхимын сайд нарыг Ерөнхий сайд нь томилдог, чөлөөлдөг, огцруулдаг, хариуцлага тооцож чаддаг.

Монголд яагаад өнөөдөр О.Баасанхүүгийн яриад байгаагаар сайд нараа оруулж ирж чөлөөлүүлж хариуцлага ярьж чаддаггүй вэ гэхээр Улсын Их Хурал дээр энэ нь улс төр болоод нэг сайд, хоёр сайддаа хариуцлага тооцох биш бүтэн танхимаараа хариуцлага тооцуулах улс төрийн том доргилт болчих гээд байдаг учраас үе үеийн сайд нар, Ерөнхий сайд нар энэ кабинетынхаа сайд нартаа, танхимын сайд нартаа хариуцлага тооцох юмыг хийж ирэхээс жийрхэж ирсэн. Яг ний нуугүй хэлэхэд.

Энэ заалтыг оруулж ирэх юм бол тэртээ тэргүй ард нь Ерөнхий сайд нь кабинеттай нь хариуцлага тооцох Улсын Их Хурлын бүрэн боломж эрх нь нээлттэй байж байгаа. Хуучнаараа. 19 гишүүн Ерөнхий сайдыг огцруулах асуудлыг өргөн бариад ингээд олонхоор шийдвэр гаргаад явах боломж нээлттэй байгаа.

Сая улс төрийн онол нэлээн яриад байх шиг байна. Энэ засаглалыг хуваах зарчим, засаглалыг хуваах онол гэдэг юмыг бид нар бас Монгол Улс сүүлийн 30-аад жилд холион бантан болгож авчирсныг засах ийм боломж энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр байсан.

Тэр Шарль Луи де Монтескьё, Жон Локк нарын яриад байгаа тэр засаглалыг хуваах зарчим, онол гэдэг чинь бол хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх гэсэн гурван институтийн асуудал яригддаг байхгүй юу. Манайд болохоор Ерөнхийлөгч, Их Хурлын дарга, Ерөнхий сайд гээд гурван хүний асуудал яриад яваад өгдөг. Төрийн гурван өндөрлөг гээд. Институтээ орхиод явчихдаг.

Энэ гаж буруу юмнаас чинь болоод өнөөдөр түрүүн зарим гишүүдийн яриад байгаа Ерөнхийлөгч нь Ерөнхий сайдын хооронд эрх мэдлээ булаацалдсан, өөрсдийнхнөө эрх мэдлийг нэмэгдүүлэх гэсэн. Үүндээ хууль хүч, шүүхийн байгууллагыг татан оролцуулдаг юм бол Монгол Улсын Ерөнхийлөгч П.Очирбат, Н.Багабанди, Н.Энхбаяр нарын үеэс эхлээд тэр Д.Бямбасүрэн, П.Жасрай нарын Ерөнхий сайд нарын. Тэр нөгөө дөрөв огцордог Ерөнхий сайд нарын чинь үеэс эхлээд 1992 онд энэ ардчилсан Үндсэн хуулийг баталсны маргаашаас эхлээд өрнөсөн үйл явц.

Энэ үйл явц өнөөдөр ч гэсэн явж байгаа. Тийм учраас энийг нэг уг нь талд нь гаргах шаардлага бол байсан. Би Улсын Их Хурлын чуулганы танхим дээр хэлж байсан шүү дээ. Парламентын засаглалтай байя гэж байгаа энэ парламентынхаа засаглалын энэ онолын дагуу, дэлхий нийтийн жишгийн дагуу ингээд явах хэрэгтэй. Ерөнхийлөгчийн засаглалтай байя гэж байгаа бол Үндсэн хуульдаа Ерөнхийлөгчийн засаглалтай гэж оруулаад л Ерөнхийлөгчийн засаглалын энэ зарчмын дагуу дэлхий нийтийн жишгийн дагуу явах ёстой.

Өнөөдөр Монгол Улс бол холимог тогтолцоотой дэлхийд байхгүй ийм цөөхөн улсын нэг болсон. Хоёр аавтай. Нэг аав нь өглөө босоод өдөржингөө үүрэг даалгавар өгч юм ярина. Нэг аав нь шөнө босож ирээд бүгдийг унтуулахгүй. Дахиад өөр үүрэг даалгавар өгөөд яриад байдагтай агаар нэг. Үлгэрлэвээс.

Тэгэхээр энэ энэ зүйлийг одоо цаашдаа бид нар бас бодох нь зөв гэж ингэж бодож байгаа. Тийм учраас энэ Ерөнхий сайдын кабинетаа одоо томилдог, чөлөөлдөг, огцруулдаг энэ зарчмыг дэмжиж байгаа юм.

Ер нь бол энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хийх гэж олон парламент дамжиж ярьсан. Олон Улсын Их Хурлын гишүүд ярьсан. 2016 оны парламент бүрдсэнээс хойш Үндсэн хуулийн асуудал бас нэлээн олон түвшинд яригдаж байж энэ хүрч. Өнөөдөр бас гуравдугаар хэлэлцүүлгээ хийж байгаад би бол баяртай байгаа. Монгол Улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбатын Засгийн газрын үед Ерөнхий сайд Ж.Эрдэнэбатын захирамжаар ажлын хэсэг байгуулагдаж тухайн үеийн Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын сайд миний бие, энэ Хууль зүйн сайд С.Бямбацогт, тэгээд хуульчид, эрдэмтэн судлаачид оролцсон ажлын хэсэг байгуулагдаж 2016 оны сонгуулийн дараа. Энэ Үндсэн хуулийг өөрчлөх шаардлага байна уу, байхгүй юу. Байвал яаж өөрчлөх вэ гэдэг энэ асуудал яригдаж төслийг нь хийж өгсөн. Энэ төсөлд бол сая миний яриад байгаа энэ бүх юм бол тодорхой орж ирсэн.

Ингээд одоо Д.Лүндээжанцан нарын Улсын Их Хурлын гишүүдэд энэ төсөл дээр тулгуурлан өргөн барьж, өнөөдөр одоо ингээд гуравдугаар хэлэлцүүлгээ хийгээд явж байна. Энэ нэмэлт, өөрчлөлтөөр бол олон давуу талтай сайн юм орж байгаа. Энийг ард түмэнд энэ хэвлэл мэдээллийнхнээрээ дамжуулж үнэнийг бас хэлэх хэрэгтэй. Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татдаг болж байна. Улсын Их Хуралтай хариуцлага тооцдог, хугацаанаас нь өмнө тараах асуудлыг, Улсын Их Хурал ажлаа муу хийх юм бол хариуцлага тооцдог энэ асуудал маш тодорхой болж орж ирж байгаа.

Их Хурлын ирц. Нөгөө нэг төгөлдөр хуурчид гэж яриад байдаг нөхөд хүний кноп дардаг энэ бүх юм бол байхгүй болж байгаа. Ажлын өдөр хоног нь хаврын намрын чуулганаар нэмэгдэж байгаа. Давхар дээлийг тайлна гэж бид нар ингээд олон жил ярьсан. Би өөрөө бас энийг ярьж жагсаал хийж явсан гишүүний нэг. 2016 онд бид нар засаглалын эрхийг авахад давхар дээл 96 хувьтай, 100 хувьтай Н.Алтанхуяг, Ч.Сайханбилэг Ерөнхий сайдын үед байгуулагдаж байсан юм байна лээ. Энийг 50 хувь болгож бууруулж байсан. Өнөөдөр бол Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр давхар дээл гэж яриад юм Их Хурал, Засгийн газрын гишүүнийг хавсран хийх юм 30 хувь болж орж ирж байгаа.

Ингээд яриад байх юм бол шүүхийн бас дэвшил өөрчлөлтүүд гарч ирж байна. Шүүхийн Ерөнхий зөвлөл дээр. Тэр одоо шүүгчтэй хариуцлага тооцдог, хяналт тавьдаг механизм дээр нь. Ингээд олон олон давуу юмнууд бий. Тийм учраас би бас энэ үг хэлэх завшааныг тохиолдуулж энэ Монгол Улсын нэмэлт, өөрчлөлтийн төлөө ажилласан үе үеийн ажлын хэсгүүд, дэд ажлын хэсгүүд, мөн одоо Улсын Их Хурлын гишүүддээ бас талархал илэрхийлье. Энэ Үндсэн

хуулийг 2016 оны сонгуулийн дараа өөрчлөх ажлын хэсгийг, анхны ажлын хэсгийг нь ахалж ажиллаж байсан хүний хувьд талархал илэрхийлье гэж бодож байна. Тэгээд амжилт хүсье.

С.Бямбацогт: Гишүүд үг хэлж дууслаа. Сая энэ саналыг Улсын Их Хурлын Д.Лүндээжанцан нарын 62 гишүүний анх өргөн мэдүүлсэн төсөлд байсан. Хоёр дахь хэлэлцүүлгийн явцад бас унасан. Энэ саналыг бас эргүүлж оруулъя гэдэг саналыг Ардчилсан намын зөвлөл гаргасан. Сая оруулах уу, эсэх үү гэдэг дээр Байнгын хорооны гишүүдийн дийлэнх нь оруулъя гэсэн санал хураагдаад дэмжигдлээ. Тийм учраас зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг Та бүхэнд уншиж танилцуулъя.

Хоёр дахь хэлэлцүүлгийн дараах төсөлд доор дурдсан агуулгатай Гучин есдүгээр зүйлийн 4 дэх хэсэгт нэмэх.

4.Засгийн газрын гишүүнийг Улсын Их Хурал Ерөнхийлөгчид танилцуулснаар Ерөнхий сайд томилж, чөлөөлж огцруулна. Засгийн газрын гишүүн Улсын Их Хуралд тангараг өргөнө.

Санал гаргасан. Н.Амарзаяа, Ж.Батзандан, С.Бямбацогт, Г.Занданшатар, Д.Лүндээжанцан, Ж.Мөнхбат, Л.Оюун-Эрдэнэ, Б.Пүрэвдорж, О.Содбилэг, Д.Тогтохсүрэн, Д.Хаянхярваа, Н.Цэрэнбат, М.Энхболд, Н.Энхболд, Д.Эрдэнэбат гэсэн гишүүд санал гаргасан. Зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг уншиж танилцууллаа.

Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 16 гишүүн оролцсоноос 15 гишүүн буюу 93.8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Дараагийн санал хураалтын томъёоллыг Та бүхэнд бас уншиж танилцуулъя. Түрүүнийхтэй яг адилхан зарчмаар явагдана.

Хоёр дахь хэлэлцүүлгийн. Энэ санал дэмжигдсэнтэй холбоотойгоор. Тийм. Энэ санал шууд санал хураалт байгаа шүү.

13.а гэсэн санал Та бүхэнд тараасан байгаа.

Хоёр дахь хэлэлцүүлгийн дараах төслийн өөрчилсүгэй гэсэн 4 дүгээр зүйлд “Монгол Улсын Үндсэн хуулийн” гэсний дараа “Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалтын “Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд,” гэснийг “Ерөнхий сайд,” гэж,” гэж нэмэх. Санал гаргасан түрүүний гишүүд. Уншсан. Тийм ээ? Асуулт асууж, үг хэлэх гишүүн. О.Баасанхүү гишүүнээр тасаллаа.

О.Баасанхүү: Баярлалаа. Барын амнаас гараад арслангийн аманд орно гэж үг байдаг л даа. Нэг талаасаа үнэн байх л даа. Их Хурлын ингээд нам байгуулаад нам нь.

Ер нь анх миний мэдэж байгаагаар эхлээд энэ 1996-2000 оны хооронд фракц гэж ойлголт байсан юм. Дараа нь 2000-2004 оны хооронд МАНАН гэж

ойлголт бий болсон. 2004-2012 оны хооронд МАНАН бүлэглэл гэдэг болсон. Одоо бол шинэ МАНАН гэдэг буюу өнөөдөр нөхцөл байдал бол цусан төрлийн МАНАН гэж нэрлэж болно л доо. Ураг төрлөөрөө холбогдчихсон. Гишүүд нь хоорондоо үр хүүхдүүдээ гэрлүүлж суулгачихсан. Тэгээд төрийг хувьчилж авахад ингээд бэлэн болчихоод байгаа яг энэ түүхэн цаг хугацааны өмнө өнөөдөр энэ засаглалын тогтолцоондоо гар хүрч байгаа юм байна.

Ингээд хүрэхдээ одоо ямар ойлголтод хүрэх вэ гэхээр нам бол намын дарга бол Ерөнхий сайд байх юм байна. Нам нь өөрөө Засгийн газрын гишүүн гээд хүмүүсээ томилох юм байна. Намын дарга бөгөөд хаалтан дотор Ерөнхий сайд.

Тэгэхээр Ардчилсан намд эмгэнэл илэрхийлье. Яагаад гэвэл Ардчилсан нам чинь нам төртэй төрийн тогтолцоог халж. Нөгөө нэг юу билээ. Хангамжийг байхгүй болгож, хар машиныг унахгүй байлгаж, тэгээд өнөөдөр юу гэдэг юм албан ёсоор одоо ингээд ардчилал, эрх чөлөөг тунхаглана гээд өлсгөлөн, янз бүрийн зүйл хийж гарч ирсэн л дээ.

Санжаасүрэнгийн Зориг гэдэг агсныг одоо амь насыг Ардчилсан намын үед амиа алдсан. Ардын намын үед илрэхгүй байсаар байгаад одоо Ардчилсан намын үед бас илэрлээ гэдэг нь худлаа гэж Ардын намынхан яриад ингээд юунд итгэхэд ойлгомжгүй болсон яг энэ үед намын дарга бөгөөд Ерөнхий сайд Улсын Их Хуралд хамааралгүйгээр нөгөө хүмүүстэйгээ ажиллах юм байна.

Өнөөдөр Улсын Их Хурлын гишүүн гэдэг бол нийт ард түмнээсээ бас сонгогдож байгаа. Нийт ард түмнээсээ сонгогдохдоо өнөөдөр юу вэ гэх юм бол энэ Засгийн газарт өнөөдөр хяналт тавих үүрэгтэй байгаа. Ерөнхий сайдад өнөөдөр албан ёсоор миний санаж байгаагаар бол Ардчилсан намын зүгээс ч хэлж байсан байх. Миний зүгээс ч хэлж байсан. Зарим сайдууддаа хариуцлага тооцоо гэдэг. Тооцдоггүй. Тооцох хууль байхгүй учраас би өргөн барьж чадахгүй байгаа юм. Хуулиа бол өргөн барьж бол болно л доо. 19 гишүүнтэй Ерөнхий сайдыг огцруулж болдог хэрнээ нь 24 гишүүнтэй сайдыг огцруулж болохгүй. Ийм л тогтолцоотой өнөөдөр явж байгаа. Яагаад вэ гэвэл хуулийн заалтыг нь аваад хаячихсан. Тухайн үед Төрийн байгуулалтын байнгын хороон дарга байхад Нямаагийн Энхболд даргад би хэлж байсан. Наад одоо Үндсэн хууль нэгэнт өөрчлөгдсөн юм бол наадахдаа 15 хоногийн дотор чөлөөл, заалтаа өөрчлөө. Ядаж 19-өө тэгвэл 18, 19 гэдэг ч юм уу оруул л даа гэж.

Өөрөөр хэлэх юм бол сайдыг өнөөдөр сайд парламентад барьцаалагддаг гэсэн ойлголт яриад байж болохгүй. Эсвэл Ерөнхий сайд нь өнөөдөр сайдууддаа одоо юу гэдэг юм Ерөнхий сайд гэдэг намын даргадаа л барьцаалагдах нь байна шүү дээ.

Одоо Та бүхэн мэдэж байгаа. Бүх Засаг дарга, намын дарга хийдэг. Бүх Засаг дарга. Ялсан нам нь аймгийн намын хорооны дарга бөгөөд Засаг дарга. Төрийн мөнгөөр намын хурал хийдэг. Намын уулзалт хийдэг. Намын арга хэмжээ хийдэг. Эмэгтэйчүүдийн, залуучуудын гээд толгойн дээрээ улаан малгайгаа өмсөөд гудамжаар алхаад явж байдаг. Үгүй энэ Засаг дарга нарыг чинь манай засаг ноён уу, МАНАН-ы засаг ноён уу гээд ингээд талцал, хуваагдал бий болдог. Одоо Ерөнхий сайдыгаа тийм болгох юм байна л даа.

Сайдуудаа тийм болгох нь байна. Хууль зүйн сайд нь намын дарга бөгөөд Ерөнхий сайдад шууд хамааралтай. Тэр хүнд л таалагдана. Нэг хүнд таалагдах тухай яриа яваад байгаа байхгүй юу.

Бид нар бол шулуухан хэлэхэд танилцаж байгаа гэдэг нь одоо юу юм эрэгтэй юу эмэгтэй юу, хөрөнгөтэй юу хөрөнгөгүй юу. Тэр намын даргатайгаа гоё яриарай. Огцров доо чи. Намын дарга чинь одоо чамайг огцруулна гээд бичиг өгчхөөр би яах юм бэ. Яг ингээд шууд хамааралтай өөрөөр хэлэх юм бол Засгийн газрыг намд хувьчилж өгөх ийм нөхцөл байдал үүсчихлээ. Намд. Яагаад гэхээр намын дарга нь Ерөнхий сайд байдаг гэдэг энэ зүйлийг бараг хуульчилчихсан байгаа. Одоо энэ Үндсэн хуульдаа нэлээн хатуу оруулаад өгсөн байгаа.

Тэгэхээр би өнөөдөр энэ Монгол Улсын Үндсэн хуульд гар хүрэхдээ зөвшилцөл нэртэй хуйвалдаан хийж тэр хуйвалдаандаа өнөөдөр юу гэдэг юм Монгол Ардын Хувьсгалт намыг одоо татан оруулаагүй явдалд маш их баярлалаа. Ард түмэн нэг талдаа, авилгачид нөгөө талаа гарна биз дээ. Тэртэй тэргүй энийг өөрчлөх хувь заяа, түүх хэрвээ эргээд бидэнд ногдох юм бол ямар ч байсан энийг зөв сайнаар нь өөрчилнө гэж хэлмээр байна.

Одоогийн байгаа яг та нарын энэ оруулж байгаа чинь ерөөсөө өнгөлөн далдлалт буюу косметик гэж хэлдэг тийм засвар л оруулж байна. Өөрөөр хэлэх юм бол намдаа та нар Ерөнхий сайдыг бэлэглэж байна. Засгийн газрыг бэлэглэж байна. Парламент чинь эрээвэр, хураавар байдаг учраас өнөөдөр л 65 гэж байгаа ч гэсэн 5 нам орж ирээд Засгийн газарт хяналт тавих боломж байгаа. 34 нам орж ирээд Засгийн газарт хяналт тавих боломж байгаа. Харин өнөөдөр юу вэ гэх юм бол Засгийн газарт хяналт тавих тэр парламентын хяналтыг байхгүй болгож байгаа.

Тэгээд дургүй хүргэвэл Ерөнхий сайдаа л өргөн бариад явъя даа одоо. Ингээд жинхэнэ утгаараа Засгийн газраар тоглох болоод байгаа юм. Нэг сайдыг өөрчлөхөд амархан шүү дээ. Болно. Засгийн газрын бодлого нь тогтвортой л байна биз дээ. Үнэхээр өгзөг барьчихсан байвал яах юм. Огцруулахаар өөр яах юм. Өнөөдөр Үндсэн хуулийн цэцийн дарга нь тийм юм хийгээд явчихсан байна шүү дээ. Түүн шиг өнөөдөр Хууль зүйн сайд нь өнөөдөр есөн шидийн зүйлд орооцолдоод яриад л, надад таван хэрэг өнөөдөр үүрүүлчихсэн байгаа юмаа гээд яриад явж байна шүү дээ. Янз бүрийн саарал жагсаалтад өнөөдөр оруулчихаад намайг сайшаасан, магтсан гээд тэнэгтээд сууж байна шүү дээ.

Энийг огцруулах хуулийн заалтаа оруулж ирэхийн оронд энийгээ бол намын даргадаа үлдээе. Тэгээд намын дарга өөрөө хувь заяаныхаа эрхээр ингээд хоорондоо шийдээрээ л гэж хэлнэ.

Тэгэхээр жинхэнэ утгаараа Ерөнхий сайдыг барьцаанд оруулах боломж үүсэж байгаа шүү. Яагаад гэвэл ганц хүнийг бүлдэгдэхэд амархан. Бүхэл бүтэн парламентыг бол чадахгүй. Парламентын хяналт доор байлгах тэр бололцоог байхгүй болгож байгаад их харамсаж байна. Эсвэл одоо тэгвэл Ерөнхий сайд парламентыг тараадаг эрхтэй болго. Эсвэл одоо энийг хийж байгаа бол яршиг. Ерөнхий сайдын бодлогыг дэмжихгүй байгаа над мэт шиг ингээд яриад одоо энэ чинь ингээд Засгийн газар, парламентын хооронд жинхэнэ хагарал үүснэ.

Яагаад гэвэл та нар миний яриад байгаа бодлогыг дэмжихгүй байна. Сайдуудтайгаа би ажиллаж байгаа юм чинь гээд. Одоо ерөөсөө Засаглалын чинь хамгийн чухал санаа нь энэ шүү дээ. Ерөнхий сайдыг Засгийн газрын сайдуудын чөлөөлөх эрх нь парламентад байна уу, эсвэл Ерөнхий сайд буюу Засгийн газрын гишүүд нь парламентыг тараах эрхтэй байна.

Бид дандаа ингээд Японоор, Америкаар жишээ авдаг. Тэд нар шиг өнөөдөр эдийн засгаа хөгжүүлчих л дээ. Тэр нар шиг өнөөдөр юу гэдэг юм хаан гээд ёс зүйтэй, уламжлалтай болчих л доо. Өнөөдөр 30 жил гэж хэлчхээд өнөөдөр яг нарийндаа хэлэхэд бол хоёр тийш ээ л явлаа шүү дээ. Нэг нь улс төр лүү, нэг нь бизнес рүү. Хоёулаа л баяжлаа шүү дээ. Ард түмэн чинь ядуу байна шүү дээ. Тэр ард түмэн гээд байгаа энэ олон нийтийгээ ядуу болгосон учраас энэ олон түмэн чинь ууртай байна шүү дээ. Дотор нь солиотой, галзуу, тэнэг хүмүүс тэрийг чинь ашиглаад... /минут дуусав/

С.Бямбацогт: Баярлалаа. Үг хэлчихлээ. Сая бас О.Баасанхүү гишүүн бол энэ төслийг санаачлагч байгаа. Энэ төсөлтэй анх өргөн барьсан төсөлд байсан заалт шүү гэдгийг бас гишүүд бас ойлгоорой. Тэгээд санал хураалт явуулъя.

Саналын томъёоллыг би уншиж танилцуулсан. 13а. Дахиад уншихъя.

Хоёр дахь хэлэлцүүлгийн дараах төслийн өөрчилсүгэй гэсэн 4 дүгээр зүйлд “Монгол Улсын Үндсэн хуулийн” гэсний дараа “Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалтын “Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд,” гэснийг “Ерөнхий сайд” гэж нэмэх.

Санал гаргасан түрүүний гишүүд. Н.Амарзаяа, Ж.Батзандан, С.Бямбацогт, Г.Занданшатар, Д.Лүндээжанцан, Ж.Мөнхбат, Л.Оюун-Эрдэнэ, Б.Пүрэвдорж, О.Содбилэг, Д.Тогтохсүрэн, Д.Хаянхярваа, Н.Цэрэнбат, М.Энхболд, Н.Энхболд, Д.Эрдэнэбат.

Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 16 гишүүн оролцсоноос 15 гишүүн буюу 93.8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Дараагийн санал хураалт. 14 дэх санал хураалт гэж томъёолол Та бүхэнд тараагдсан байгаа. Мөн адил зарчмаар явна. Гишүүд хэлэлцэх эсэхийг нь. Энэ “б” хураах шаардлагагүй юм. Энэ дэмжигдээгүй тохиолдолд гэсэн байсан юм. Тийм.

Хоёр дахь хэлэлцүүлгийн дараах төслийн 21 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 1, 2 дахь өгүүлбэр нэмэх:

“Улсын Их Хурлын сонгуулийг олонхийн болон хувь тэнцүүлэх зарчмыг хослуулан явуулна. Сонгогч тойрогт нэр дэвшсэн болон намын жагсаалтад орсон нэр дэвшигчийн төлөө саналаа өгнө.”

Энэ саналыг гаргаж урьд нь бас яригдсан асуудал. Гаргах саналтай гишүүд байна уу? Тэгэх үү? За тэгье. Энэ саналаар санал хураалт явуулчихъя.

Босгох уу, үгүй юу. Тийм ээ. Энийг? Санал хураалт явуулах уу, үгүй юу. Энүүгээр. Асуулт, үгтэй гишүүд нэрсээ өгье. Дэгээр бол байхгүй. Гэхдээ яах вэ, үг өгье. Нээлттэй ярилцъя. Өөр асуулт, үгтэй гишүүн байна уу? О.Баасанхүү гишүүн.

О.Баасанхүү: Би дахиад хэлэх гээд байна л даа. Босгох уу, үгүй юу. Одоо энэ саналыг оруулах уу, үгүй юу гэдгээ ард түмнээсээ асуучих ёстой байсан юм л даа.

Анх би танайд бичиг өгч байхдаа ард нийтийн санал асуулга явуулах гэж байгаа таван асуудлаар асууя.

Нэгдүгээрт нь, ямар асуудал вэ гэхээр би энэ одоо холимог байх юм уу, мажоритар байх юм уу?

Хоёрдугаарт нь, өнөөдөр тэр байгалийн баялгаа яах юм?

Гуравдугаарт нь, өнөөдөр энэ гишүүдийн тоо нэмэх юм уу, багасгах юм уу?

Дөрөвдүгээрт нь, өнөөдөр энэ Их Хурлын хугацааг 5 байх юм уу гэх мэтчилэн ард түмэн гэж яриад байгаа олон түмэн өнөөдөр нийт Монгол Улсын иргэд өнөөдөр энэ Үндсэн хууль хамааралтай учраас иймэрхүү тодорхой зүйлээр асуумаар байгаа юм.

Сая би тойргийнхоо иргэдтэй уулзахад тойргийн иргэд хэлж байгаа байхгүй юу. Та нар яагаад биднээс асуухгүй Үндсэн хууль өөрчлөөд байгаа юм бэ гэж. Тэгээд би тодорхой зүйл асуухыг бол би шаардаж байгаа. Тодорхой биш одоо зарим хүмүүст огт хамааралгүй гэж хэлж болох, нөгөө талаасаа нэг их сонирхох боломжгүй. За яах вэ дээ тэрийг нь бол мэргэжлийн хүмүүсийн шийдээд явчихна биз гэсэн зүйл болгоныг бол хэцүү. Сонгууль өнөөдөр энэ Үндсэн хуулийн 60, 70, 80 хувь нь гайгүй байгаа бол 20 ийм ойлгомжгүй заалтаас болоод санал хураахаар уначих гээд байна гэсэн.

Гэтэл харамсалтай нь өнөөдөр хаалгаар өшиглөөд гаргасан юмыг тооноор нь ороод ирнэ гэдэг шиг одоо энэ жагсаалтын хууль гэж бид нарын хэлдэг энэ юм ороод ирж байна л даа. Тэгээд жагсаалтад орсон нэр дэвшигчийн төлөө саналаа өгнө гэж. Тэгээд нэр дэвшигчийн төлөө саналаа өгөхгүй өөр юуны төлөө өгөх юм. Нэр дэвшигчийн төлөө гээд байгаа байхгүй юу. Доромжлоод байгаа юм уу яагаад байгаа юм. Намуудад байгаа лидерүүд нь гоё юмаа гэж, Их Хурлын гишүүд маань гоё юмаа гэж хэлээд санал өгөх юм байна л даа.

Намын бодлого нь зөв юм байна, буруу юм байна гэж санал өгөх эрхгүй болчихсон. Үндсэн хуулийг шууд үгээр нь ойлгоно шүү дээ. Нэр дэвшиж байгаа хүн нь хөөрхөн байх уу, муухай байх уу гээд. Тэгээд одоо доромжлох юм байна л даа. Одоо тэр жагсаалтад хэрвээ н.Гантулга гээд залуу орчихсон байвал залуу үе гээд орсон чинь ийм асуудал болбол та нар энэ хүний төлөө саналаа өгсөн шүү дээ гэж. Та нар биднийг л сонгосон шүү дээ гэх юм байна л даа. Хэлэх эрх байхгүй. Намаа Монгол Ардын нам хэдэн хүнд тавих юм. Тэгээд

тэрийг нь хараад, тэрийг нь гоё юм байна, муухай юм байна. Сүхбаатар жанжны юм уу, Чойбалсанг тавьчаарай. Нэр дэвшигчийн төлөө гэж байгаа бол. Тэртэй тэргүй одоо хэдийгээр, эсвэл Чингис хааныг тавьчихгүй юу. Тэгвэл арай хүн чинь ойлгомжтой. Ямар ч байлаа гэсэн нам нь ажил хийх юм байна. Дэвшиж байгаа хүн нь хамаагүй юм байна. Чингис хаан л мундаг юм чинь гээд явсан нь дээр юм шиг байна.

Ийм нэр дэвшигчийн төлөө, нэр дэвшигч чинь тэгээд хэний төлөө юм. Иргэд нэр дэвшигчдийн төлөө ажиллах юм байна. Харин нэр дэвшигч хэний төлөө ажиллах юм? Намын төлөө ажиллана шүү дээ. Намын жагсаалт юм чинь. Та нарыг гаргасан юм чинь. Та нарыг жагсаалтад эрэмбэлсэн юм чинь нам өнөөдөр энийг оруулсан юм чинь гээд ярина л даа. Хувь тэнцүүлэх зарчмаар гээд байгаа байхгүй юу. Хувь тэнцүүлэх гэдэг чинь өөр юу байгаа юм.

Тэгээд одоо сонгоогүй бол тэр нэр дэвшигч одоо муухай хүн болж таарах уу? Хувь тэнцүүлээд нэг нь 40 хувь, нэг нь 20 хувь. 40 хувь илүү гэхээр нь тэр 20 хувь нэр дэвшигчийн төлөө санал өгөөгүй гэсэн үг үү? Нэр дэвшигчийн төлөө санал өгөөгүй болох нь байна шүү дээ. Ингэж энэ чинь яваандаа юу вэ гэвэл нэр дэвшигч дээрээ өнөөдөр талцах үндэсний цөөнх, олонхын асуудал, ястан угсаатны асуудал ч яригдахыг үгүйсгэхгүй шүү дээ.

Тэгэхээр ийм байдлаар өнөөдөр хийж болохгүй. Тэрнийхээ оронд нь одоо яршиг зүгээр нам хэрвээ үнэхээр холимог юм оруулах гээд байгаа бол нам дотор тодорхой лидер гэж байгаа хүнээ тавина. Тэр лидерт нь дүнгээ тавья даа одоо. Удирдагчийнх нь төлөө гэдэг юм уу, одоо юу гэдэг юм. Нэр дэвшигч гээд байгаа байхгүй юу. Юу намын жагсаалтад ямар хүн дэвшээд байгаа юм. Дэвшүүлсэн нь одоо Монгол Улсын Үндсэн хууль дээр сонгох, сонгогдох эрх чөлөөт гэж.

Сонгогдох эрх чөлөөг нь өнөөдөр сонгох эрх чөлөөнийх нь дээр тавьчаад байгаа байхгүй юу. Сонгох эрх чөлөөг бол боож байгаа юм байна л даа. Ингэж өнөөдөр толгой дээр ингэж гарахгүй. Ардын намынхан. Та нар 65-уулаа ойлгож байна. Та нар олонхоороо ойлгож байна. Үндсэн хууль та нар дангаараа өөрчлөх гэж байгааг ойлгож байна. Та нар хажуудаа өнөөдөр нэг бүлэгтэй байсан намаа бүлэггүй болгож байгаад, бүлдгийг нь сайн базаж байгаад өнөөдөр өөрсдийнхөө сонирхлоор хөдөлгөж байгааг ойлгож байна. Гэхдээ та нарын тэр сонирхолд чинь над шиг хүн орохгүй. Зарчим байвал хамтран ажиллана. Зарчим байвал явъя. Тэрнээс биш сонгогч тойрогт нэр дэвшсэн болон намын жагсаалтад орсон нэр дэвшигчийн төлөө саналаа өгнө. Тойрогт хүнээ дугуйлна. Ийм байдлаар өнөөдөр.

Би нэр дэвшигчийн төлөө саналаа өгмөөргүй байна. Би сонгуульд саналаа өгөхдөө намын бодлого, мөрийн хөтөлбөр, үзэл баримтлалынхаа төлөө саналаа өгмөөр байна. Итгэл үнэмшлийнхээ төлөө саналаар өгмөөр байна. Тэрнээс биш хувь хүний боол биш. Та нар нэртэйгээр нь Манжийн дарлалд байлгасан шигээ үзэхгүй юу. Яагаад гэвэл та миний одоо харьяатад ор гээд. Харьяатад орох эрхээ өгөх юм уу? Таны төлөө саналаа өгснөөрөө таны харьяат болох юм уу? Тэгээд саналаа өгөөгүйн нь яах юм? Саналаа өгөөгүйн нь яах юм? Энэ асуудал чинь өөрөө ойлгомжгүй байна. Нэр дэвшигчийн төлөө гэдэг ойлголт чинь өөрөө надад маш утгагүй. Хоёрдугаарт нь гэвэл ер нь.../минут дуусав/

С.Бямбацогт: Би бас тайлбар хийчихгүй бол жаахан юу яагаад байх шиг байна.

Тэгэхээр О.Баасанхүү гишүүн бидний өргөн мэдүүлсэн, 62 гишүүн өргөн мэдүүлсэн төсөлд Улсын Их Хурлын сонгуулийн тогтолцоо, журмыг хуулиар тогтооно гэсэн үгтэй байсан. Хоёр дахь хэлэлцүүлгийн явцад энэ бас дэмжигдээгүй, олонхын 57 гишүүний санал аваагүй. Үүний дараа бас ард нийтийн санал асуулгаар бид нар Үндсэн хуулиа баталъя гээд ард түмнээс асууж батлуулъя гэсэн тогтоол баталсан. Харамсалтай нь Монголын Улсын Ерөнхийлөгч хориг тавьсан. Хоригийг бид хүлээж авсан. Үүнтэй холбоотойгоор 3 дахь хэлэлцүүлгээр Үндсэн хуулийнхаа нэмэлт, өөрчлөлтийг батлахаас өөр аргагүй болж байгаа. Энийг та бас ойлгож байгаа байх гэж бодож байна.

Энэ явцад бид нар зөвшилцье. Монгол Улсын Ерөнхийлөгчтэйгөө, Ардчилсан намтай, Хувьсгалт намтай, ШИНЭ намтай гээд одоо бас парламентад байгаа намуудтайгаа зөвшилцье гэж зөвшилцсөн. Энэ явцад одоо Ардчилсан намын зөвлөлөөс маш тодорхой саналыг маш хатуу хоёр дахь хэлэлцүүлгийн явцад ч ярьж байсан. Одоо ч ярьж байгаа энэ хүрээндээ энэ сонгуулийн тогтолцоо, журмыг хуулиар тогтооно гэдгийг өшөө тодорхой оруулъя гэсэн саналыг гаргаж энийг бас бид намуудтайгаа зөвшилцье. Зөвшилцөнө гэдэг маань одоо олонх нь одоо юу гэдэг юм, 65 суудалтай нам хүч түрэх биш ээ. Энэ Үндсэн хуулийг хүч түрж батлахгүй. Аль болох харилцан ойлголцож зөвшилцөж байж баталъя гэдэг хүрээндээ энэ саналыг авъя. Авахдаа 2024 оноос хэрэгжүүлье гэдэг байдлаар бид ойлголцоод явж байгаа.

Ингэхдээ одоо томъёолол нь Улсын Их Хурлын сонгуулийг олонхийн болон хувь тэнцүүлэх зарчмыг хослуулан явуулна. Сонгогч нэр дэвшсэн болон намын жагсаалтад орсон нэр дэвшигчийн төлөө саналаа өгнө гэсэн томъёолол дээр ойлголцсон.

Энэ юу гэсэн үг вэ гэхээр үндсэндээ сонгогч тойрогт нэр дэвшсэн гэдэг нь 76 тойрог. Одоо жижиг тойргоор бид нар явж байгаа шүү. Заримдаа бид нар томсгосон 76 тойргоор явуулдаг. Олон мандаттай, томсгосон тойргоор. Үүнээс гадна намын жагсаалт буюу одоо улсад нэг тойрог болох ийм жагсаалт гаргая. Улсад нэг тойрог. Энэ жагсаалтад нэр дэвшихдээ бид нар нэр дэвшсэн хүнийхээ төлөө санал өгье. Урд нь бас холимог тогтолцоогоор сонгууль явуулж үзсэн. Тэр үед намын жагсаалт, намын төлөө санал өгч байсан бол одоо намын төлөө биш, хувь хүнийх нь төлөө улсад нэг тойрог болгоод саналаа өгье гэдэг ийм томъёоллоор Үндсэн хуульд оруулж өгье.

Өөрөөр хэлэх юм бол жалга, довын депутатууд гэж бид нар ярьдаг. 76 тойргоор гарсан нэг аймаг дотроо хоёр, гурав хуваагдаад нэр дэвшсэн. Тэгвэл аймгийн төлөө биш, тэр тойргийн төлөө ажилладаг. Тойрогтоо төсвийн хөрөнгийн татах гэж бөөн юм болдог. Улс орны бодлого, тийм үү. Том эрх ашиг, хөгжлийн асуудлаар бид нар ярьдаггүй. Энийг одоо ярьдаг болгохын тулд улс нэг тойргоос дэвшүүлдэг больё. Ингэх юм бол улсынхаа эрх ашиг, улсынхаа хөгжлийн бодлого, том бодлогоо ярьдаг болох юм байна. Тэгэхгүй 76 жижиг тойргоос 76 жижиг асуудлаа ярьдаг болчихоод байна. Энэ алдааг л засъя гэдэг үүднээс холимог тогтолцоо байя. Ингэхдээ нам дугуйлдаг биш, улсын эрх

ашгийн төлөө ажилладаг, том бодлого ярьдаг ийм тогтолцоог бас холимгоор оруулъя ирье гэдэг агуулгаар Ардчилсан намын бүлгийг гаргасан гэж ойлгож байгаа. Бидний нар бас ингээд явчих нь зөв юм болов уу гэж бодож байгаа.

Өөрөөр хэлэх юм бол аймгийн наадамд барилддаг бөх, тийм үү. Улсын наадамд барилддаг бөх 2 чинь өөр шүү дээ. Үүнтэй адилхан бас нэг улсын наадамд барилддаг бөхтэй адилхан улсаасаа сонгогддог нэр дэвшигчийн төлөө гэдгийг ингэж ойлгоорой гэдгийг бас хэлье. Ийм агуулгаар бид нар Зөвшилцлийн ажлын хэсэг дээр ярьж ойлголцсон. Тэгээд энийг иргээд одоо хуульдаа, Үндсэн хуулийнхаа нэмэлт, өөрчлөлтийн төсөлдөө оруулах шаардлагатай юу, үгүй юу гэдгээр одоо санал хураалт явуулъя. Шаардлагатай гэх юм бол шаардлагатай гэж үзсэн гишүүдийн санал болж дахин зарчмын зөрүүтэй саналаар хураагдана. Шаардлагагүй гэж олонхийн дэмжлэг авахгүй бол энэ хураагдахгүй.

Ингээд санал хураалт явуулъя. Саяны уншсан томъёоллыг тийм үү.

“Улсын Их Хурлын сонгуулийг олонхийн болон хувь тэнцүүлэх зарчмыг хослуулан явуулна. Сонгогч тойрогт нэр дэвшсэн болон намын жагсаалтад орсон нэр дэвшигчийн төлөө саналаа өгнө.” гэсэн томъёоллыг Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтдөө суулгах шаардлагатай гэдгийг дэмжсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 16 гишүүн оролцсоноос 14 гишүүн буюу 87.5 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Энэ санал дэмжигдсэн учир зарчмын зөрүүтэй санал болгож одоо санал хураалт явуулна.

Хоёр дахь хэлэлцүүлгийн дараах төслийн 21 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 1, 2 дахь өгүүлбэр нэмэх:

“Улсын Их Хурлын сонгуулийг олонхийн болон хувь тэнцүүлэх зарчмыг хослуулан явуулна. Сонгогч тойрогт нэр дэвшсэн болон намын жагсаалтад орсон нэр дэвшигчийн төлөө саналаа өгнө.” Санал гаргасан Н.Амарзаяа, Ж.Батзандан, С.Бямбацогт, Г.Занданшатар, Д.Лүндээжанцан, Ж.Мөнхбат, Л.Оюун-Эрдэнэ, О.Содбилэг, Д.Тогтохсүрэн, Д.Хаянхярваа, Н.Цэрэнбат, М.Энхболд, Н.Энхболд, Д.Эрдэнэбат гэсэн гишүүд санал гаргаж байна. Зарчмын зөрүүтэй санал. О.Баасанхүү гишүүн. Өөр үг хэлэх гишүүд байна уу? Асуулт, үг. Алга байна.

О.Баасанхүү: Баярлалаа. Би хуульч хүний хувьд нэг үг хэлмээр санагдаад байгаа юм.

Одоогийн сонгуулийн хууль болон Үндсэн хууль дээр болохоор сонгуулийн журмыг Улсын Их Хурал тогтооно гэж. Тэгсэн хэр нь 7 удаа сонгууль явахдаа дандаа тогтолцоог Улсын Их Хурал тогтоож байсан байгаа юм. Томсгосон, жижгэрүүлсэн, холимог, жагсаалтын өөр юу гэдэг юм. 7 удаа явахдаа. Ялсан нам өөрөө дүрмээ зохиодог. Тэгээд ялагддаг. Ялагддаг нь сайн

юм даа. Энэ одоо 7 удаа дээр ямар ч байсан дүрмээ зохиосноороо 4 удаа Ардын нам, 3 удаа Ардчилсан нам одоо юу гэдэг юм ялагдаж байсан байгаа юм.

Тэгэхээр өнөөдөр асуудлын гол нь юу вэ гэх юм бол одоо та бүхэн тэгэнгүүт нь ямар асуудал вэ гэвэл, за яах вэ 2024 он хүртэл ирээдүйгээ бодоод оруулчихъя гэж жүжиг тоглоод, дараа нь журмын тухай хууль дээр одоо яг оруулъя гээд хийх гэж байгаа юм.

Одоо та нарын хэлдгээр гудамжинд байгаа, та нарын хэлдгээр. Уг нь гудамжныхан чинь бид нарыг ордонд оруулаад байгаа шүү дээ. Би энэ гудамжны чинь нэг хэсэг байхгүй юу. Гудамжнаас төрсөн Их Хурлын гишүүн. Жолоочийн хүүхэд. Тийм учраас өнөөдөр энэ жирийн иргэдтэй уулзахад надад ерөөсөө эмзэглээд байх юм байдаггүй юм. Тэгээд тэр нөхөдтэйгөө уулзаад ярихад хатуу нэг л юм хэлж байгаа юм. Би гараараа мэдэж тэр нэр дэвшиж байгаа хүнийгээ гараараа мэдэрч, амын сугалж сонсмоор байна гэж. Би тэгээд тэдэнд хэлсэн юм. Танд дэвшихдээ юу амлаж байсан бэ? Амлалтыг нь л, та нар амыг нь асуу л даа. 4 жил болохоор мартагнуулж байгаад тойргоо сольчихдог. Өнөөдөр та нар 65 дотор өнөөдөр нэлээн олон хүн тойргоо солих гээд аргаа бараад энэ жагсаалт дотор ороод би ард түмний хүү, 7 удаа сонгогдсон. Ах нь бол өнөөдөр МАНАН мафитай тэмцэж байгаа, амь авраарай, юу юу ч гэдэг юм. Ингээд нэр дэвших гээд үзээд байгааг ойлгож байгаа.

Тэр утгаараа юу гэдэг юм архагууд нь өнөөдөр 30 жил ордонд байсан учраас энэ жагсаалтад орох гээд тийчилж байгааг ч би мэдэж байна. Тэгээд мэдээж бүх зурагт та нарынх, бүх хуулийн байгууллага та нарынх, бүх мөнгө та нарынх, бүх эрх мэдэл та нарынх, өдөр болгон хурал хийх нэрээр сонгуулийн сурталчилгаа хийж байгааг би харж байгаа. Тэгэхээр ийм тохиолдолд хамгийн ёс зүйтэй зүйл юу вэ гэвэл ер нь бол анхныхаа дүрмээр тоглогчихвол яасан юм.

Та нар 65-уулаа болсон юм чинь, 65-уулаа байсан юм чинь, сайн ажилласан бол 76 л болно биз, саар ажилласан бол 1-хэн хүн сонгогдоно биз. Эсвэл 2-хон сонгогдоно биз. Ард түмэн дүнгээ тавимаар байна шүү дээ. Дүнгээ тавихаас нь өмнө очиж ингэж тогтолцоог өөрчилж, дүнгээ тавихаасаа өмнө одоо ингэж толгойг эргүүлж. Шинэ хуулийг нь ойлгох гэсээр байтал, юу билээ гэсээр байтал нөгөө сүлжээнийхээ бизнесээр орно л доо. Сүлжээний бизнес гэдэг чинь юу вэ гэвэл хэлээд байна шүү дээ. Аймгийн дарга болгон чинь намын дарга. Өнөөдөр төрийн албанд байгаа дарга болгон чинь нөгөө намын харьяаллаар сонгогдсон хүмүүс. Ажилтайгаа үлдэхийн тулд тэгээд одоо юу гэдэг юм багаар бодоход 10. Тэгээд дээрээс нь намын гишүүн нэртэй ингээд өчнөөн хүмүүс орно.

Тэгэхээр цөөнхдөө боломж өгөхгүй байгаа нь харамсалтай байгаа юм. Ардчиллын чинь зарчим та надад таалагдахгүй үг хэллээ ч гэсэн таныг үг хэлэх боломжийг би олгож байгаа шүү гэдэг нь ардчиллын зарчим. Харамсалтай нь өнөөдөр та нар зөвшилцөхдөө 3-хан нам байгаа юм. Энэ ордонд 3-хан нам байгаа. Дараагийн сонгуулиар 30 нам ороод би үгүйсгэхгүй. Тэгээд 3-хан нам дотор Монголын Ардын Хувьсгалт намыг та нар зөвшилцөлдөө оруулаагүй. Тэгээд өнөөдөр та нарыг орж ирээд за яах вэ одоо хуульч ухаантай, мэдлэгтэй сүрхий хүмүүс байгаа юу гэхээр одоо ингээд ард түмнийг өнөөдөр худалдаж авахаар боллоо. Ард түмнийг өнөөдөр ядарсан байгааг нь ашиглаад энэ ордондоо ингээд мөнх морилох боллоо.

Хүмүүс ууртай байна шүү, гадаа бол аймшигтай байна шүү. Жинхэнээсээ уурлаж байна, жинхэнээсээ бухимдаж байна. Өмнө нь бол тайвширдаг байсан бол одоо бол ерөөсөө тайвшрахгүй байна шүү. Та нар захаар яваад үз, эмнэлгээр яваад үз. Энэ гудамжаар яваад үз. 20 жил болохоор хүнээ таньдаггүй гэж байгаа шүү. 30 жил болоход таг мартдаг. Энэ 30 жил суучихсан учраас өнөөдөр энэ жагсаалтын хуулийг оруулж ирэх гээд улайрч байгаад би их харамсаж байна. Хүчээр батал. Гэхдээ ард түмэн нэг талдаа гарна. Та нарын хууль дүрмээрээ явж байгаа гээд байгаа энэ зүйл чинь тэдэнд таалагдахгүй бол хувьсгал гарна шүү гэдгийг би хариуцлагатайгаар хэлмээр байна.

С.Бямбацогт: Намын жагсаалт биш нэр дэвшигчдийн төлөө саналаа өгнө гээд биччихсэн байгаа гэдгийг бас ойлгож байгаа байх.

Саналаа хураачихъя. 2024 оноос тийм ээ? Одоо Монгол Ардын нам 65 суудалтайдаа өнөөдөр 2020 оноос хийх гээд байгаа юм биш. Ардчилсан намын зөвлөл одоо удаа дараа шаардлага тавьж Ардчилсан намтайгаа зөвшилцөж байж энэ одоо Ардчилсан намын зөвлөлийн саналыг бид хүлээж авч оруулж ирж байгаа гэдгийг та бас ойлгож байгаа байх. Тийм болохоор 2024 оноос хэрэгжинэ гэдгийг та бас ойлгоорой. Тэгээд өнөөдөр Монгол Ардын нам олонхоороо өөрсдөө гаргаж байгаа санал биш шүү гэдгийг та бас зөв ойлгоорой гэдгийг бас хэлье.

Хоёр дахь саналын томъёоллыг уншиж танилцуулъя.

“Улсын Их Хурлын сонгуулийг олонхийн болон хувь тэнцүүлэх зарчмыг хослуулан явуулна. Сонгогч тойрогт нэр дэвшсэн болон намын жагсаалтад орсон нэр дэвшигчийн төлөө саналаа өгнө.” Санал гаргасан түррүүн уншсан гишүүд. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Д.Лүндээжанцан гишүүн. Протоколд тэмдэглээд явдаг юу бас байгаа тийм ээ? Техникийн асуудал. Хамрын тамхиа болчихвол гайгүй болчихно л доо.

Д.Лүндээжанцан: Би энэ. Сая ингээд миний кноп ажилласангүй. Энэ дээр би протоколд тэмдэглүүлж оруулъя. Дэмжиж байна.

С.Бямбацогт: Санал хураалтад 16 гишүүн оролцсоноос 13 гишүүн саналаар энэ санал дэмжигдлээ.

Дараагийн санал хураалт.

Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу Арван ес¹дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулна.” гэснийг “улсын хэмжээний бодлого дэвшүүлж ажиллана.” гэж өөрчлөх. Энэ бол найруулгын санал. Ард нийтийн санал асуулга, Үндсэн хуулийн эхийг батлах үед бас санал хураагдсан. Энэ санал дээр санал хураалт явуулъя.

Энийг гишүүд ойлгож байгаа. Тийм үү? Саяны зарчмаар явах уу, тийм ээ? Энийг одоо санал хураалгах шаардлагатай гэж үзсэн. Санал хураах

шаардлагатай гэсэн томъёоллоор санал хураалт эхлээд явуулъя. Санал хураалт.

Нийт гишүүд. Санал хураалтад 16 гишүүн оролцсоноос 13 гишүүн буюу 81.2 нь энэ саналыг төсөлд бас нэмж оруулах шаардлагатай гэж үзсэн тул оруулъя. Томъёоллын одоо уншиж танилцуулъя. Томъёолол дээр асуугаарай та.

Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу Арван ес¹дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулна.” гэснийг “улсын хэмжээний бодлого дэвшүүлж ажиллана.” гэж өөрчлөх.

Санал гаргасан Н.Амарзаяа, Ж.Батзандан, С.Бямбацогт, Г.Занданшатар, Д.Лүндээжанцан, Ж.Мөнхбат, Л.Оюун-Эрдэнэ, О.Содбилэг, Д.Тогтохсүрэн, Д.Хаянхярваа, Н.Цэрэнбат, М.Энхболд, Н.Энхболд, Д.Эрдэнэбат.

О.Баасанхүү гишүүн. Д.Лүндээжанцан гишүүн. Д.Лүндээжанцан гишүүн эхлээд.

Д.Лүндээжанцан: Энэ чуулганы хоёрдугаар хэлэлцүүлгийн явцад гүйцээн боловсруулж энэ дээр саналаар яагаад. О.Баасанхүү гишүүн санал гаргаж бид бол энийг найруулж оруулаад, тэгээд одоо дөрөвний гурваар Их Хурал дээр дэмжсэн. Харамсалтай нь Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авсантай холбогдуулж энэ заалт хүчингүй болсон учраас хоёрдугаар хэлэлцүүлэг дээр гарсан энэ асуудлыг гүйцээн боловсруулах асуудлыг дахин санал хураалгах шаардлагатай болсон.

Үүнтэй холбогдуулаад хэлэхэд тэр сонгуулийн насны иргэдийн 1 хувьтай байж нам бүртгэх тухай асуудал байгаа. Тэгэхээр энийг одоо шилжих хуульд бол суулгахаар байна шүү дээ бас нөгөө энийг одоо тусгайд нь зааж өгнө, өгөхгүй гэж их яригдсан л даа. Дэд ажлын хэсэг дээр. Өөрөөр хэлбэл Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн холбогдох хуулийг шинэчлэн батлах хүртэлх хугацаанд тухайн харилцааг зохицуулж ирсэн хуулийг баримтална гэдэг энэ заалт бол шилжих журмын хуульд бол байж байгаа.

Яг одоо ингээд энэ заалт, саяны энэ заалт батлагдаад намын хэсэг орчихоор Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт 2020 оны 5 сарын 25-наар ингээд үйлчлээд явахад энэ 2020 оны сонгуульд хамаарах уу, үгүй юу. Бүртгэл яаж явагдах вэ, шинэ нам бүртгэгдлээ гэхэд гэх мэтчилэнгээр асуултууд гараад байгаа учраас энэ дээр тодруулж хариулт өгөх шаардлагатай байгаа юм.

Ажлын хэсэг Байнгын хороон дээр зөндөө өмнө нь ярьсан. Гэлээ гэхдээ энэнээс Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга бас энд нь бол тодруулж хариулт өгөх нь зүйтэй гэж ингэж бодож байна.

С.Бямбацогт: Хариулт өгье. Тэгэхээр бидний өргөн мэдүүлсэн төсөлд бол “нам улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулна” гэсэн ийм зохицуулалттай байсан. Одоо бол өөрчлөгдөөд бид нар “улсын хэмжээний бодлого дэвшүүлж ажиллана” гэж өөрчилж байгаа. Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулна гэдэг маань Монгол Улсын 21 аймаг, 330 суманд салбар нэгжтэй, даргатай, цэрэгтэй. Ингээд ийм хэмжээнд одоо улам л намыг өргөжүүлэх ийм бүтэц зохион

байгуулалтын хувьд бас нэлээн хүндрэлтэй байдал руу оруулахаар болсон байна гэж үзсэн учраас ажлын хэсэг маань бас хэлэлцүүлгийн явцад “улсын хэмжээнд бодлого дэвшүүлж ажиллана” гэж өөрчилж байгаа. Энэ маань үндсэндээ улсын хэмжээний бодлого дэвшүүлнэ, мөрийн хөтөлбөртэй байна. Заавал улсын хэмжээнд салбар, нэгжтэй, бүтэцтэй байх албагүй, шаардлагагүй гэдэг байдлаар ойлгогдохоор ингэж томьёолсон.

Хоёр дахь асуудал тэр 1 хувийн сонгогчдын, Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэдийн 1 хувиас доошгүй иргэн эвлэлдэн нэгдэж байгуулна гэдэг энэ заалт чинь бас нэлээн хатуу болчихжээ гэдэг асуудал ярьж байгаа. Энэ заалтыг бол 7 дугаар сарын 16-нд Монгол Улсын Ерөнхийлөгч Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Үүнийг хэлэлцэхтэй холбоотойгоор Монгол Улсын Ерөнхийлөгчөөр ахлуулсан ажлын хэсэг бас гарч ажилласан.

Ерөнхийлөгчийн өргөн мэдүүлсэн төсөлд бол үндсэндээ нийт иргэдийн 50 мянга 1-ээс доошгүй иргэдийн саналыг нэгтгэж байж нам байгуулагдана гэсэн ийм нэлээн өндөр босготой байсан. Энийг одоо бас зөвшилцлийн явцад, мөн одоо улс төрийн намуудтай өнгөрсөн 7 сарын 20-иодоор бас хэлэлцүүлгүүд хийсэн. Энэ явцдаа бас нэлээн ярилцаж байж бид нар 1 хувь болгож буулгасан. Өөрөөр хэлэх юм бол сонгуулийн насны иргэдийн 1 хувь буюу 20 орчим мянган иргэн эвлэлдэн нэгдэж байж улс төрийн нам байгуулах ийм заалтыг Үндсэн хуульд оруулж байгаа.

Нэг талаасаа бол бас нэг борооны дараах мөнгө шиг болсон энэ олон намууд, 35 нам, хүн болгон одоо нам байгуулдаг болчихсон энэ улс төрийн намуудын нэр хүнд унаж байгаа. Тийм болохоор бас улс төрийн намуудыг цэгцлэх зохион байгуулалт, бүтэц, үзэл баримтлал, бодлого, үйл ажиллагааны хувьд бас цэгцлэх шаардлага байгаа. Гэхдээ нөгөө талдаа бас хэтэрхий хатуу шалгууртай байж болохгүй гэж үзсэн. Энэ үүднээсээ 50 мянга биш 20 орчим мянган иргэдийг бас нэгдэж нийлэх бололцоо боломжтой болгоё. Нөгөө талаасаа бас энэ заалт нь 2020 оны сонгуульд үйлчлэхгүй. Улсын Их Хурлын гишүүдэд, Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо, Тамгын газарт бол энэ заалт чинь одоо ирэх сонгуульд үйлчлэх нь цөөхөн одоо 20 мянгаас дээш гишүүнтэй цөөхөн нам улс төрийн сонгуульд оролцох юм байна, бусад нь оролцох бололцоо боломжгүй болох юм байна гэсэн тийм буруу ойлголтууд бас нэлээн явж байна.

Тийм болохоор сонгуулийн жил 2020 оны 01 сарын 01-нээс эхэлчихнэ. Үндсэн хууль бол 2020 оны 05 сарын 25-наас хүчин төгөлдөр үйлчилж эхэлнэ. Тийм болохоор энэ заалт бол энэ сонгуулиас үйлчлэхгүй. 2024 оны сонгуулиас үйлчилнэ гэж олон нийт, улс төрийн намууд бас ойлгох нь зөв байх. Ийм байдлаар ойлгож явахгүй бол буруу ойлголт яваад байх шиг байсан гэдгийг тайлбарлаж хэлье. О.Баасанхүү гишүүн.

О.Баасанхүү: Нам иргэдийн улс төрийн хүсэл зоригийг илэрхийлж улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулна гэсэн үг байсан. Энийг бол нам бол бодлогын болон салбарын хоёулаа байх ёстой. Бодлого нь тодорхой байх юм бол ард түмэн нь дэмжвэл салбартай байна уу, салбаргүй байна уу. Ардын нам байна

уу, Ардчилсан нам байна уу үл хамааран бодлого таалагдлаа гээд аль ч намыг сонгох эрх нь сонгогчдод нээлттэй байх ёстой гээд.

Тэгэнгүүт энийг О.Баасанхүү гишүүн хэлээд байгаа юм чинь засъя гээд зассан гэж яриад байгаа. Тэгэхдээ засахдаа буруу зассан байгаа юм л даа. Уг нь бол нам Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 10-т заасны дагуу байгуулагдаж, Үндсэн хуулийн дагуу бодлого дэвшүүлж ажиллана. Үндсэн хуульд нийцсэн бодлого дэвшүүлж ажиллана гэж оруулмаар байгаа юм. Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн бодлого дэвшүүлж ажиллана гэж.

Гэтэл улсын хэмжээний бодлого гээд. Улсын хэмжээний бодлого, улсын хэмжээний биш бодлого гэж юу байдаг юм. Би бас тэрийг ойлгохгүй байгаа. Хувь очоод хувь хүний хувьд нэг юм ярьдаг. Зөвхөн мөрийн хөтөлбөрийг ярь гэсэн үг юм уу. Орон нутгийн өнөөдөр сонгуульд нэр дэвшдэг. Орон нутгийн янз бүрийн асуудлуудыг ярьдаг. Нэг хүн нь одоо юу гэдгийн та одоо нэр дэвшвэл энд байгаа сургууль, цэцэрлэг яах вэ гэхээр наадах чинь улсын хэмжээний бодлого биш байна. Манай нам ийм юм яриагүй гэх юм уу?

Дээрээс нь өнөөдөр гэр хорооллын асуудал, утааны асуудал ярихаар наадах чинь гэр хорооллын хэмжээний бодлого болохоос биш улсын хэмжээний биш гэх юм уу. Эсвэл одоо нэг малын, малчны асуудал ярихаар хүн бүр малчин биш хүн бүр мал малладаггүй учраас энэ чинь бол одоо юу гэдэг юм хөдөө аж ахуйн бодлогын асуудал болохоос улсын хэмжээний бодлогын асуудал биш гэх юм уу?

Тэгэхээр энэ нэг улсын хэмжээний гэдэг механик үгээ бодлого гэдэг үгээр аргалаад засчихсан гэвэл энэ шиг утгагүй юм байхгүй. Миний яриад зүйл бол нам бол салбар байгуулаад явах одоо яах вэ сайнаар хэлбэл хандив, тусламж сайтай юм. Муугаар хэлбэл хахууль сайн авдаг юм. Ингэж хэлээд энэ тэндээ очоод салбараа байгуулаад сүлжээгээрээ нэр дэвшигч сонгогдох гээд гарч ирж байгаа бол тэр намын бас эрх. Нөгөө талаасаа өнөөдөр тодорхой бодлого яриад жишээ нь авилгачдыг байхгүй болгоё гэдэг бодлогыг ярихаар тэр нь ард түмэнд таалагдаад энэ намд саналаа өгөхөөр наад чинь улсын хэмжээний бодлого биш байна. Бүх хүн авилгачин биш гэх юм уу? Цөөхөн хүнийг ингэж орууллаа гэх юм уу?

Тэгэхээр хүчтэй нь хүчгүйгээ барьж идэж болохгүй. Нөгөө талаас аваад үзэхэд Үндсэн хууль зөрчсөн бодлого ярьж болохгүй шүү дээ. Бүх хүний өрийг тэглэ гээд. Ардчилсан намынхан өнөөдөр Ерөнхийлөгчийн сонгууль болж байхад Ерөнхийлөгчид нэр дэвшиж байгаа хүнд гурван зүйлийн шаардлага өгсөн шүү дээ. Нэг нь миний ойлгож байгаагаар цалинг нь тэглэ. Цалингийн зээлийг тэтгэвэр, тэтгэврийн зээлийг тэглэ. Дээрээс нь оюутны зээлийг тэглэ гээд. Үндсэн хууль зөрчсөн шүү дээ. Сонгуулийн хууль зөрчсөн. Тэгээд одоо тэрэнд нь огт анзаараагүй байсан. Одоо бараг энэ нэр дэвшигчид санал өгсөн хүн болгон надаас нөгөө өр хэзээ тэглэх вэ л гээд байгаа шүү дээ.

Ардын нам ч гэсэн өнөөдөр ингээд ард түмэнд худлаа хэлж өчнөөн юм ярьж гарч ирсэн шүү дээ. Хүн болгоныг орон сууцтай болгоно гээд л ярьдаг. Нөгөө сургууль, цэцэрлэгтэй болгоно хүүхэд болгоныг. Танайхан ярьсан шүү дээ. Танай тэр бодлого дотор хэчнээн гоё гоё юм байсан. Хэрэгжсэн бол Монгол

Улс өнөөдөр төмөр замтай болчихсон. Авто замтай болчихсон. Авлигагүй болчихсон. Тэгээд худлаа ярьчихсан байгаа байхгүй юу. Тэгээд худлаа ярьчихсан байгаа байхгүй юу. Тэгээд худлаа ярьсан ямар ч хариуцлага байхгүй. Улсын хэмжээнд хэрэгтэй юм даа гээд авсан. Улсын хэмжээнд хэрэгжүүлээгүй. Тэгээд одоо ичихгүй одоо дахиад даагаа нэхэх гээд сууж байдаг.

Үндсэн хуульд нийцсэн бодлого ярьж байж болно шүү дээ. Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн бодлого. Шударга байх, аюулгүй орчинд байлгах, амьдрал ахуйг нь дээшлүүлэх, гадаад дотоод бодлогоо сайжруулах ийм юмыг яриад л нам тэгээд бүртгүүлээд явъя л даа. Монгол Улсын Үндсэн хууль нийт.

Одоо улсын хэмжээний, хувийн хэмжээний гэдэг маргаан үүсэх гээд байна шүү дээ. Хувийн хэмжээний маргаан байна. Энэ чинь хувийн асуудал байна гэх юм уу? Эсвэл орон нутгийн хэмжээний юм ярьчихсан байна. Энэ намыг татан буулга гээд дайрах юм уу? Үндэстний асуудал ярьчихсан байна гэх юм уу? Тэгэхээр энэ болгон чинь нөгөө миний яриад байгаа, хүсээд байгаа зүйл бол дандаа зөвхөн салбарын намыг та нар дэмжих гээд байна. Бодлогын намыг дэмжээч гээд хэлсэн нь биш. Тэгэнгүүт нь бодлогын нам нь зөвхөн улсын хэмжээнд л байна. Ингэж болохгүй.

Бие даагчийг яах юм? Бие даагч бас улсын хэмжээний юм ярих юм уу? Эсвэл тойргийн хэмжээний юм ярих юм уу? Бие даагч. Бие даагч гэж бас юмаа бид нар арилгачхаагүй байлгүй дээ. Тэр Монгол Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж чадахгүй шүү дээ. Институт байхгүй. Тойргийн хэмжээндээ очоод юм ярьж болно шүү дээ. Тэр ард түмэндээ таалагдаад манайхан өнөөдөр нэр дэвшигчийг өнөөдөр малчин хүнийг тавья гэж хэлж болно шүү дээ. Тэгэхээр өнөөдөр зөвхөн намд зориулсан... /минут дуусав/

С.Бямбацогт: О.Баасанхүү гишүүн ээ. Та бас битгий мушгиж яриад байгаач гэж хэлмээр байна.

Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулна гэсэн төслийг та бид нар хамт санаачилсан. Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулна гэсэн саналыг Та гарын үсэг зураад санаачилсан. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт дээр.

Дараа нь Улсын хэмжээний бодлого гэдэг үгийг Та бас өөрөө өөрчилсөн. Санал гаргаж. Улсын хэмжээний бодлого гэдгийг. Тэгээд Улсын хэмжээний бодлого гэдэг маань өнөөдөр юу гэдэг юм жалга довын нам, шашны нам, үндэстэн ястны нам, аймгийн нам ийм байгуулагдахгүй байх ёстой. Энэ улсын хэмжээнд бодлого, үйл ажиллагаагаа явуулах ёстой шүү гэдэг агуулгаар л бид нар ярьсан шүү дээ. Та өөрөө үндэстний хэмжээнд үйл ажиллагаа явуулна гэж. Тэгэхгүй бол нэг шашны нам байгуулаад, тэгэхгүй бол нэг үндэстэн, ястны нам байгуулагдаад, тэгэхгүй бол нэг аймгийн нам байгуулагдаад Монгол Улсын үндэстний аюулгүй байдал, тусгаар тогтнолд асуудал болчихвий агуулгаар Та ч гэсэн ярьж байсан. Бид нар тэгээд дэмжээд бас ингээд Улсын хэмжээний бодлого болгоод явсан шүү дээ. Өөрөө ярьчихаад өөрийнхөө ярьсныг одоо бас үгүйсгээд ингээд битгий яриад бай л даа.

Санал хураалт явуулъя.

Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу Арван ес¹ дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулна.” гэснийг “улсын хэмжээний бодлого дэвшүүлж ажиллана.” гэж өөрчлөх. Санал гаргасан. Түрүүн уншсан, тийм ээ? Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 15 гишүүн оролцсоноос 12 гишүүн буюу 80.0 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Д.Лүндээжанцан гишүүн дэмжсэн байх. Тийм ээ? 13 санал, 13 гишүүн дэмжлээ.

Дараагийн санал хураалт. Энэ найруулгын саналууд явж байгаа шүү дээ. Гишүүд ээ. Бас ойгоорой. Гэхдээ бас ирцтэйгээ баймаар байна шүү.

Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу Арван ес¹ дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “зарчимд нийцэж” гэснийг “зарчимд нийцсэн” гэж, “байгуулалт нь” гэснийг “байгуулалт”, “эх үүсвэр болон” гэснийг “эх үүсвэр,” гэж өөрчлөх. Энэ санал хураалтыг хураах шаардлагатай гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 15 гишүүн оролцсоноос 13 гишүүн буюу 86.7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Дэмжигдсэн тул зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу Арван ес¹ дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “зарчимд нийцэж” гэснийг “зарчимд нийцсэн” гэж, “байгуулалт нь” гэснийг “байгуулалт”, “эх үүсвэр болон” гэснийг “эх үүсвэр,” гэж өөрчлөх. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал гаргасан Н.Амарзаяа, Ж.Батзандан, С.Бямбацогт. Энэ саналаа хүчингүй болгочихъё. Энэ бас уншихгүй бол болохгүй бас. Сая саналын томьёоллыг уншсан.

Санал гаргасан Н.Амарзаяа, Ж.Батзандан, С.Бямбацогт, Г.Занданшатар, Д.Лүндээжанцан, Ж.Мөнхбат, Л.Оюун-Эрдэнэ, О.Содбилэг, Д.Тогтохсүрэн, Д.Хаянхярваа, Н.Цэрэнбат, М.Энхболд, Н.Энхболд, Д.Эрдэнэбат нарын гишүүд энэ саналыг гаргаж байна. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 15 гишүүн оролцсоноос 13 гишүүн буюу 86.7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Гурав дахь санал хураалт. Найруулгын. Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу Зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн “тулгуурласан” гэснийг “тулгуурлаж”, “иргэн бүрт” гэснийг “ирээдүй үеийн” гэсний дараа оруулах, “бүрт” гэснийг “бүрд” гэж, мөн “эрхийнхээ хүрээнд” гэсний дараа “газрын хэвлийн баялаг” гэснийг “газрын хэвлийн баялгийг” гэж өөрчлөх.

Энэ саналыг хураалгах шаардлагатай гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 15 гишүүн оролцсоноос 13 гишүүн 86.7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Дэмжигдсэн тул зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг та бүхэнд уншиж танилцуулъя. Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу Зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн “тулгуурласан” гэснийг “тулгуурлаж”, “иргэн бүрт” гэснийг “ирээдүй үеийн” гэсний дараа оруулах, “бүрт” гэснийг “бүрд” гэж, мөн “эрхийнхээ хүрээнд” гэсний дараа “газрын хэвлийн баялаг” гэснийг “газрын хэвлийн баялгийг” гэж өөрчлөх.

Санал гаргасан Н.Амарзаяа, Ж.Батзандан, С.Бямбацогт, Г.Занданшатар, Д.Лүндээжанцан, Ж.Мөнхбат, Л.Оюун-Эрдэнэ, О.Содбилэг, Д.Тогтохсүрэн, Д.Хаянхярваа, Н.Цэрэнбат, М.Энхболд, Н.Энхболд, Д.Эрдэнэбат нарын гишүүд энэ саналыг гаргаж байна. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 15 гишүүн оролцсоноос 13 гишүүн буюу 86.7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Дөрөв дэх санал. Хуралдаан даргалагчаас чиглэл өгсний дагуу Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.” гэсэн 4 дэх өгүүлбэр нэмэх. Шаардлагатай гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал хураалтад 15 гишүүн оролцсоноос 13 гишүүн буюу 86.7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Дэмжигдсэн тул зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг Та бүхэнд уншиж танилцуулъя. Санал хураалт явуулна.

Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.” гэсэн 4 дэх өгүүлбэр нэмэх.

Санал гаргасан Н.Амарзаяа, Ж.Батзандан, С.Бямбацогт, Г.Занданшатар, Д.Лүндээжанцан, Ж.Мөнхбат, Л.Оюун-Эрдэнэ, О.Содбилэг, Д.Тогтохсүрэн, Д.Хаянхярваа, Н.Цэрэнбат, М.Энхболд, Н.Энхболд, Д.Эрдэнэбат нарын гишүүд энэ саналыг гаргаж байна. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Энэ саналыг би бас санал хураалт явуулахын өмнө бас тайлбарлачихъя. Энэ бас нэлээн чухал санал байгаа учраас. Бас олон нийтэд бас жаахан буруу зөрүү ойлголтууд төрөөд байх шиг байсан. Үр өгөөжийн гэдэг үгийг бид нар бас түрүүн энэ саналыг хураалгахдаа бас тайлбарласан. Нийгэм, эдийн засгийн үр

өгөөж гэдэг утгаар нь ойлгоно. Энд татвар, хураамж, төлбөр, татварын дараах ногдох ашиг гэсэн өргөн ойлголтоороо энэ “үр өгөөж” гэдэг үгийг бас ойлгож органик хуульдаа бас тусгах ёстой.

Мөн одоо “дийлэнх” гэдэг үгийг бас бид нар тийм үү “ердийн олонх”, “дийлэнх олонх”, “үнэмлэхүй олонх” гэдэг агуулгаар биш 50 дээр нэмэх нь 1 гэсэн утгаар бас ойлгож явна гэж урд өмнө нь бас Төрийн байгуулалтын байнгын хороон дээр ингэж томъёолж санал хураалгасан. Энэ зарчмаараа бас ойлгогдож явна. Органик хуульдаа бас ингэж явах ёстой шүү гэдгийг протоколд тэмдэглэж үлдээе.

Тэгээд “үр өгөөж” нь “дийлэнх” гэдгийг одоо бас юу гэдэг юм төрийн өмчит компани байгуулаад ерөөсөө л төрийн өмчит компани 50-иас дээш хувь нь эзэмших юм байна гэдэг агуулгаар биш компани тийм үү хэдэн хувь ч төр эзэмшиж болно. Гэхдээ мэдээж тэр түрүүн хэлсэн “нийгэм, эдийн засгийн үр өгөөж” буюу татвар, төлбөр, хураамж, татварын дараах ногдол ашгийн олонх, дийлэнх гэдэг утгаар нь агуулагдаж цааш цаашдаа бас органик хуульдаа тусгах ёстой шүү гэдгийг бас томъёолъё. Санал хураалт явуулъя.

Санал хураалтад 15 гишүүн оролцсоноос 13 гишүүн буюу 86.7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Тав. Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалт буюу Хорин хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “гуравны хоёроос доошгүй нь үзсэн,” гэснийг “гуравны хоёроос доошгүй нь үзэж” гэж, “даргатай зөвшилцөн” гэснийг “даргатай зөвшилцөж” гэж, “санал болгосноор” гэснийг “санал болгосон бол” гэж тус тус өөрчлөх. Шаардлагатай гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Найруулгын санал. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 15 гишүүн оролцсоноос 11 гишүүн буюу 73.3 хувийн саналаар энэ саналыг төсөлд тусгая гэсэн санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналыг Та бүхэнд уншиж танилцуулъя.

Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалт буюу Хорин хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “гуравны хоёроос доошгүй нь үзсэн,” гэснийг “гуравны хоёроос доошгүй нь үзэж” гэж, “даргатай зөвшилцөн” гэснийг “даргатай зөвшилцөж” гэж, “санал болгосноор” гэснийг “санал болгосон бол” гэж тус тус өөрчлөх саналыг Н.Амарзаяа, С.Бямбацогт, Д.Лүндээжанцан, Г.Занданшатар, Д.Тогтохсүрэн, Л.Оюун-Эрдэнэ, О.Содбилэг, Д.Хаянхярваа, Н.Цэрэнбат, М.Энхболд, Н.Энхболд, Ж.Батзандан, Д.Эрдэнэбат нар гаргасан байна. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 15 гишүүн оролцсоноос 12 гишүүн буюу 80.0 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Дараагийн санал хураалт. Найруулгын санал. Төслийн 3 дугаар зүйлийн 7 дахь заалт буюу Дөчин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “батлагдсанд тооцож” гэснийг “баталсанд тооцож” гэж өөрчлөх. Шаардлагатай гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал хураалтад 15 гишүүн оролцсоноос 13 гишүүн буюу 86.7 хувийн саналаар энэ санал дэмжигдсэн тул зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Төслийн 3 дугаар зүйлийн 7 дахь заалт буюу Дөчин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “батлагдсанд тооцож” гэснийг “баталсанд тооцож” гэж өөрчлөх. Санал гаргасан Н.Амарзаяа, Ж.Батзандан, С.Бямбацогт, Д.Лүндээжанцан, Г.Занданшатар, Д.Тогтохсүрэн, Л.Оюун-Эрдэнэ, О.Содбилэг, Д.Хаянхярваа, Н.Цэрэнбат, М.Энхболд, Н.Энхболд, Д.Эрдэнэбат. Санал хураалт.

Санал хураалтад 15 гишүүн оролцсоноос 12 гишүүн буюу 80.0 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Дараагийн санал хураалт. Төслийн 3 дугаар зүйлийн 9 дэх заалт буюу Дөчин есдүгээр зүйлийн 5 дахь хэсгийн “Зөвлөлийн үйл ажиллагааны тайланг” гэснийг “Шүүгчийн хараат бус байдлыг хангахтай холбоотой зөвлөлийн үйл ажиллагааны тайланг” гэж өөрчлөх. Шаардлагатай гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Энийг төсөлд тусгах шаардлагатай.

Тодотгож байгаа санал. Урд нь бас хураагдсан.

Санал хураалтад 15 гишүүн оролцсоноос 13 гишүүн буюу 86.7 хувийн саналаар зарчмын зөрүүтэй саналыг төсөлд тусгая.

Зарчмын зөрүүтэй саналыг уншиж танилцуулъя.

Төслийн 3 дугаар зүйлийн 9 дэх заалт буюу Дөчин есдүгээр зүйлийн 5 дахь хэсгийн “Зөвлөлийн үйл ажиллагааны тайланг” гэснийг “Шүүгчийн хараат бус байдлыг хангахтай холбоотой зөвлөлийн үйл ажиллагааны тайланг” гэж тодотгож өөрчилж гэсэн саналыг Н.Амарзаяа, Ж.Батзандан, С.Бямбацогт, Д.Лүндээжанцан, Г.Занданшатар, Д.Тогтохсүрэн, Л.Оюун-Эрдэнэ, О.Содбилэг, Д.Хаянхярваа, Н.Цэрэнбат, М.Энхболд, Н.Энхболд, Д.Эрдэнэбат нар гаргасан байна. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 15 гишүүн оролцож, 13 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

Ес дэх санал. Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг 2020 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн. Наймдугаар санал. Уучлаарай.

Төслийн 3 дугаар зүйлийн 11 дэх заалт буюу Тавин долдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “хот; тосгоны” гэснийг “хотын, түүнчлэн тосгоны” гэж өөрчлөх. Шаардлагатай гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Шаардлагатай. Дараад нь зарчмын зөрүүтэй санал дээр хэлчхээрэй.

Энэ саналыг төсөлд тусгах шаардлагатай гэж 15 гишүүнээс 12 нь үзсэн тул зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя.

Төслийн 3 дугаар зүйлийн 11 дэх заалт буюу Тавин долдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “хот; тосгоны” гэснийг “хотын, түүнчлэн тосгоны” гэж өөрчлөх. Санал гаргасан Н.Амарзаяа, Ж.Батзандан, С.Бямбацогт, Д.Лүндээжанцан, Г.Занданшатар, Д.Тогтохсүрэн, Л.Оюун-Эрдэнэ, О.Содбилэг, Д.Хаянхярваа, Н.Цэрэнбат, М.Энхболд, Н.Энхболд, Д.Эрдэнэбат.

О.Баасанхүү гишүүн асуулт асууж, үгээ хэлье.

О.Баасанхүү: Цахилгаан дайн гэдэг шиг дэндүү цахилгааны хурдаар их явж байна. Зөвшилцсөний чинь ойлгож байна. Тохиролцсоныг нь ойлгож байна. Ханцуйн дотроо бас ярьсныг нь ойлгож байна.

Ялангуяа одоо шүүгчийн хараат бус, энэ тэр юм юу болж байна. Ажлын хэсэгтээ оруулаагүй. Оруулаагүй учраас анхны мэдэгдэхүүнийх шиг одоо юу гэдэг юм асууж байж магадгүй. Гэхдээ ард түмэн чинь ажлын хэсэгт бас ороогүй. Ард түмнээрээ та нар өнөөдөр юу гэдэг юм асуугаад Үндсэн хуулиа батлаагүй. Одоо та нар гурав дахь хэлэлцүүлгээр шууд баталж байгаа. Ядаж надад хэрэггүй байж болно. Монголын ард түмэнд хэрэгтэй болов уу гэж бодоод чадлаараа одоо юу гэдэг юм нөхцөл байдлыг чинь тодотгох, болохгүй байгаа юмыг чинь болиулах, болоод байгаа юмыг чинь бас нэг ард түмэнд ойлгуулах гээд яриад байгаа юм.

Яриулж л бай л даа гээд яриад байгаа байхгүй юу. Доромжлоод байгаа юм уу, хаашаа юм. Би ярихын тулд энд суугаагүй. Надад ярих шаардлага ч байхгүй. Гэхдээ Монголын ард түмнээс та нар асуухаа больсон шүү дээ. Монголын ард түмнээс өнөөдөр юу гэдэг юм нийтийн санал асуулгаар та нар өнөөдөр явуулахаа больчихсон. Тийм учраас нэг ч гэсэн одоо намайг харж байгаа коммент, твиттерээрээ муулдаг ч гэсэн тодорхой хэмжээнд бас юу ярих гээд байна гээд сонсдог нэг цөөхөн хүн байлаа ч гэсэн тэд нартаа зориулж би асуух гээд байгаа юм.

Өнөөдөр 57.2 дээр ямар үг байгаа вэ гээд. Улсын болон орон нутгийн харьяалалтай хот, тосгоны эрх зүйн үндэс, тэдгээрийн өөрийн удирдлага болон засаг захиргааны зохион байгуулалтын зарчмыг хуулиар тогтооно гэж.

Би санаж байгаагаар бол О.Содбилэг, Д.Дамба-Очир, миний нэртэй хүмүүс юу гэж хэлсэн бэ гэвэл хот гэдгээ бүр тодорхой нэр зааяаа. Эрдэнэтийн, Дарханы, Улаанбаатар. Одоо юу байдаг юм, Эрдэнэтийн, Дарханы болон Чойбалсан ч гэдэг юм уу. Ингээд тодорхой жаргалын найман хотоо нэртэй нь оруулъя гэсэн. Үндсэн хуулийн хэлэлцүүлгээр нэр нь тодорхой орсон гэж би ойлгосон.

Хоёрдугаарт нь, өнөөдөр юу вэ гэвэл эрх зүйн үндсийг тогтоолоо гэхэд тосгон, хот хоёрыг хольж болохгүй. Хот чинь өөрийн санхүүтэй, өөрийн захирагчтай, өөрийн газартай байдаг. Тосгон чинь бол өнөөдөр арай өөр түвшинд байгаа.

Тэгээд өнөөдөр юу вэ гэх юм бол энэ дээр хотын, түүнчлэн тосгоны гэдэг маань бол хотын эрх зүйн байдал, мөн түүнчлэн тосгоны эрх зүйн байдлыг гэж тусад нь оруулахгүй бол хотын, тосгоны эрх зүйн байдал гээд ингээд хоёуланг

нь өнөөдөр нэг доор оруулах гэж байгаагаар харагдаад байгаа юм. Уг нь хотын статус, тосгоны статусыг тус тусад нь эсвэл. Тус тусад нь эрх зүйн байдлыг хуулиар зохицуулна гээд тус тусад нь гэж үг байж болох байхгүй юу.

Тэгээд би ажлын хэсэгт орсон бол та нарт их тус болох байсан л даа. Ядаж тус тусад нь гэдэг үг маань орж байгаа нь ганцхан үг орж байгаа юм шиг та нарт санагдаж болно. Тэгээд ингээд нөгөө ёстой бүдүүлгийн дээдээр бүдүүлэг юм орж ирж байгаа байхгүй юу. Түрүүн би ингээд л үгээр нь та нарт ярихад зөндөө юм байгаа байхгүй юу. Аягүй бол ямар санаа орсон бэ гэвэл за яах вэ, нээрээ тус тусдаа эрх зүйн байдлын хуультай байя гэх болов уу гэж. Бид өнөөдөр хотын бүхэл бүтэн тусдаа хөгжил, стратеги, янз бүрийн оруулъя гэхэд одоо ингээд шууд алхаа цохилоо дөрөв дэх хэлэлцүүлэг байхгүй.

Энэ Дарханаас сонгогдсон, Эрдэнэтээс сонгогдсон энэ гишүүд өөрсдөө иргэддээ очиж юу гэж ярих вэ? Хотын тосгоны эрх зүйн байдал гэдэг нэг хуультай болж байгаа юм байна гэх юм уу? Уг нь хот, тосгон тус тусдаа эрх зүйн байдлын хуультай болж байгаа учраас хотын статусыг зориулсан тусдаа хууль гаргах гэж байгаа. Ийм чухал юм байгаа гэж ярих юм уу? Тэгэхээр өнөөдөр хотын, тосгоны гэдэг энэ “ын” гэдэг үсэг оруулснаараа юу ч гийгүүлэх вэ дээ. Юу нь ч ач холбогдол байх вэ дээ. Уг нь бол хот гэдэг үг байхгүй юм байна. Энийг оруулчихъя.

Тэгэхдээ бүр оруулахдаа бүр тусгайлан нэрээр нь заагаад оруулчихъя гэж ярьж байгаад тодорхой хэмжээнд орсон учраас одоо тэр тусгайлан газар болгон чинь өөр өөрийн онцлогтой. Өөр өөрийн. Одоо жишээ нь зүүн чиглэлийн төмөр зам баригдлаа гэхэд тэр Чойбалсан хотыг ямар байдлаар хөгжүүлэх вэ гээд тусад нь хуулийн эрх зүйн зохицуулалт хийж болно. Дархан бас нэг арай өөр онцлогтой. Эрдэнэт нэг өөрийн онцлогтой. Тус тусад нь зохицуулсан хууль гаргаж болно. Яагаад гэвэл яаж захирагчаа томилох юм. Яаж газраа томсгох юм. Яаж өөрийн төсвөө хуримтлуулах юм гэдэг онцлогууд байгаад байгаа байхгүй юу.

Тэгээд хотод зориулсан тэр эрх зүйн статусыг бие даасан эрх зүйн зохицуулалтаар хий гэсэн чинь “хотын тосгоны эрх зүйн зохицуулалт” гэдэг байдлаар “ын”, “ны”. Одоо энийг арай эрлийз, хурлийз хүмүүсээ уншаад бичсэн юм биш биз дээ гэдэг хүртэл санаа зовж байна. Найруулгын хувьд ч байхгүй, агуулгын хувьд ч байхгүй. Тэгээд ийм юмаа өнөөдөр дангаараа та нар шийдчихээд тэгээд алхаа цохиод яваад байдаг.

С.Бямбацогт: Хариулт өгье. Үндсэн хуулийн 57.2-т угаасаа хот, тосгоны эрх зүйн байдлын үндсийг эрх зүйн хуулиар тогтооно гэж заачихсан байж байгаа. Энэ дээр бид нар тийм үү улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны өөрийн удирдлага, зохион байгуулалт, эрх зүйн үндсийг хуулиар тогтооно гэж тийм үү, аль болох Эрдэнэт, Дарханы асуудал, 21 аймгийн төвийг хот болгох асуудлыг Үндсэн хуульдаа тусгаж өгөх зорилгоор одоо Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг бид оруулсан.

Энийг Та санаачлаад гарын үсэг зурсан. Үүнийг чинь өшөө илүү таны хэлж байгаа тийм үү, хотын тосгоны, хот, тосгоны гээд адилхан байгаад нэг зиндаанд байгаад байна гээд таны шүүмжлээд байгаа чинь ялгаатай болгох гэж улсын

болон орон нутгийн зэрэглэлтэй хотын, түүнчлэн тосгоны өөрийн удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн үндсийг хуулиар тогтооно гэж салгаж өгч байгаа юм.

Мөн дээрээс нь дагаж мөрдөх журмын тухай хууль дээр бас бид нар санал гаргаад та бүгдийн саналаар О.Содбилэг гишүүн, Д.Хаянхярваа гишүүн, Б.Жавхлан гишүүн гээд одоо Эрдэнэт, Дархангаас сонгогдсон гишүүдийн саналыг бас тусгаад журмын тухай хууль дээр засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний эрх зүйн байдалтай холбогдох хууль тогтоомжийг 2020 оны эхний хагас жилд багтаан шинэчлэн баталсны үндсэн дээр Засгийн газар Дархан, Эрдэнэт хотыг улсын зэрэглэлтэй хот болгох асуудлыг судлан Улсын Их Хуралд өргөн мэдүүлж шийдвэрлэнэ гэсэн зүйл нэмье гээд бид нар оруулж байгаа.

Ийм байдлаар асуудлыг шийдээд яваад байгаа л даа, О.Баасанхүү гишүүн ээ. Энийг тэгэхэд та битгий мушгиж яриад байгаа чээ гэж дахин хүсье.

Санал хураалт явуулъя. Төслийн 3 дугаар зүйлийн 11 дэх заалт буюу Тавин долдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “хот; тосгоны” гэснийг “хотын, түүнчлэн тосгоны” гэж өөрчлөх. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал гаргасан түрүүчийн гишүүд.

Санал хураалтад 15 гишүүн оролцсоноос 13 гишүүн буюу 86.7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг 2020 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 12 цаг буюу арван долдугаар жарны төмөр хулгана жилийн зуны тэргүүн сарын шинийн гуравны өдрийн морин цагаас эхлэн улс орон даяар дагаж мөрдөнө гэсэн саналыг урд нь бид нар дэмжсэн байгаа. Одоо энийг оруулах шаардлагатай гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал хураалтад 15 гишүүн оролцсоноос 13 гишүүн энэ заалтыг Үндсэн хуулийн төсөлд тусгах шаардлагатай гэж үзсэн тул зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя.

Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг 2020 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 12 цаг буюу арван долдугаар жарны төмөр хулгана жилийн зуны тэргүүн сарын шинийн гуравны өдрийн морин цагаас эхлэн улс орон даяар дагаж мөрдөнө. Санал гаргасан Н.Амарзаяа, Ж.Батзандан, С.Бямбацогт, Д.Лүндээжанцан, Г.Занданшатар, Д.Тогтохсүрэн, Л.Оюун-Эрдэнэ, О.Содбилэг, Д.Хаянхярваа, Н.Цэрэнбат, М.Энхболд, Н.Энхболд, Д.Эрдэнэбат. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Д.Лүндээжанцан гишүүн дэмжсэн тооцно. Хуруу, техник ажиллаагүй. Санал хураалтад 15 гишүүн оролцсоноос 13 гишүүн буюу 86.7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Дараагийн санал хураалт. Төслийн 3 дугаар зүйлийн 12 дахь заалт буюу Дөчин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “төсөв,” гэснийг “төсвийн болон” гэж

өөрчлөх шаардлагатай гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал хураалтад 15 гишүүн оролцсоноос 11 гишүүн буюу 73.3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй санал. Энэ санал дэмжигдсэн тул зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Төслийн 3 дугаар зүйлийн 12 дахь заалт буюу Дөчин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “төсөв,” гэснийг “төсвийн болон” гэж өөрчлөх. Санал гаргасан Н.Амарзаяа, Ж.Батзандан, С.Бямбацогт, Д.Лүндээжанцан, Г.Занданшатар, Д.Тогтохсүрэн, Л.Оюун-Эрдэнэ, О.Содбилэг, Д.Хаянхярваа, Н.Цэрэнбат, М.Энхболд, Н.Энхболд, Д.Эрдэнэбат. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 15 гишүүн оролцсоноос 13 гишүүн буюу 86.7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Дараагийн санал хураалт. Төслийн 3 дугаар зүйлийн 13 дахь заалт буюу Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “тойргийн” гэсний өмнө “шүүхийг” гэж нэмэх шаардлагатай гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал хураалтад 15 гишүүн оролцсоноос 12 гишүүн буюу 80.0 хувийн саналаар энэ санал дэмжигдсэн тул зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Төслийн 3 дугаар зүйлийн 13 дахь заалт буюу Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “тойргийн” гэсний өмнө “шүүхийг” гэж нэмэх. Санал гаргасан Н.Амарзаяа, Ж.Батзандан, С.Бямбацогт, Д.Лүндээжанцан, Г.Занданшатар, Д.Тогтохсүрэн, Л.Оюун-Эрдэнэ, О.Содбилэг, Д.Хаянхярваа, Н.Цэрэнбат, М.Энхболд, Н.Энхболд, Д.Эрдэнэбат. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшилцлийн ажлын хэсгээс гаргасан. 68-ын ажлын хэсгээс гаргасан саналуудаар санал хураалт явагдаж үндсэндээ дууслаа.

Одоо бас гишүүд санал ирүүлсэн байгаа. Санал хураалт явуулъя. Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатар зарчмын зөрүүтэй саналын томьёоллын санал гаргасан.

Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд “Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлд Монгол Улсын Ерөнхийлөгчийг Улсын Их Хурлын өргөтгөсөн бүрэлдэхүүнээс сонгоно” гэж нэмэх.

Х.Нямбаатар гишүүн гишүүнийхээ хувиар гаргасан ийм саналыг. Тэгэхээр яг түрүүний зарчмаар явна. Энэ саналаар санал хураах шаардлагатай юу гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Асуух асуулт, үг хэлэх гишүүд байхгүй байна. Санал хураалт.

Санал хураалтад 15 гишүүн оролцсоноос 8 гишүүн буюу 53.3 хувийн санал авсан байна. Гуравны хоёрын саналаар энэ санал дэмжигдэх ёстой. Энэ санал дэмжигдсэнгүй. Тэгэхээр санал хураах шаардлагагүй гэж үзлээ.

Ингээд горимын санал гаргах юм уу? Та нар. Ороогүй гэсэн хүмүүс байгаа юм уу? Тэгээд. Аан. Би хэлээд, өөрөө хүртэл дэмжлээ.

Холбогдох саналуудаар санал хурааж дууслаа. Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд би танилцуулъя.

Дараагийн хэлэлцэх асуудалдаа оръё.

Хоёр. Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төсөл. /Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан нарын 62 гишүүн 2019 оны 06 дугаар сарын 06-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжлэл/

Хоёрдугаар асуудал. Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулъя.

Ажлын хэсгийг танилцуулъя. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн түрүүнийх хэвээрээ.

Ц.Товуусүрэн Улсын Бага Хурлын гишүүн, Улсын Их Хурлын гишүүн асан, ажлын дэд хэсгийн ахлагч, Р.Хатанбаатар Ардын Их Хурлын депутат, Улсын Бага Хурлын гишүүн асан, ажлын дэд хэсгийн ахлагч, Н.Лувсанжав Монгол Улсын гавьяат хуульч, дэд ажлын хэсгийн ахлагч, О.Мөнхсайхан Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн багш, хууль зүйн ухааны доктор, дэд ажлын хэсгийн ахлагч, Д.Ламжав Ардын Их Хурлын депутат асан, А.Бямбажаргал Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, профессор, хууль зүйн ухааны доктор. Ийм хүмүүс ажлын хэсэг хүрэлцэн ирсэн байна.

Чуулганы хуралдааны дэгийн тухай хууль. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэгтэй холбогдуулаад материалыг Та бүхэнд тараасан байгаа. Асуух асуулттай гишүүд байна уу? Ердийн журмаар явна. Тийм ээ. Дэгийн тухай хуулийн.

Нэг зарчмын зөрүүтэй саналын томъёолол байгаа. Тийм. Дахиад асуугаад. Ж.Батзандан гишүүн асуултаа асууя.

Ж.Батзандан: Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хууль гэж хууль гарна. Энэ хуулийн хүрээнд шүүгч нартай холбоотой, Үндсэн хуулийн цэцийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаатай холбоотой заалтууд орж ирж байгаа. Тухайлбал, 2020 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө томилогдсон анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчид энэ хамаарахгүй гэдэг.

4 дүгээр зүйл дээр болохоор 2020 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө томилогдсон Улсын дээд шүүхийн шүүгчийн бүрэн эрхийн хугацаанд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт хүчин төгөлдөр болсон өдрөөсөө эхлэн 12 жил байна гэж орж ирж байгаа.

Тэгэхээр 2020 оны 7 сарын 01-ний өдрөөс өмнө томилогдсон хэдэн жил ажилласан, хэдэн шүүгчид энэ заалт хамаарахаар байна вэ гэж. 12 жил дээр нэмэх нь гэдэг хугацаа орж ирж байна уу, яг 12 жил гэдэг хатуу хугацаа орж ирнэ гэж та бүхэн тооцож байна уу гэдэг. Энийг надад тайлбарлаж өгөөч.

2020 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө томилогдсон Үндсэн хуулийн цэцийн гишүүний бүрэн эрхийн хугацаа 6 жил гэдгээр нь ийм заалт орж ирж байгаа. Энэ дээр тайлбар авахыг хүсэж байна. Хасагдсан уу? За тэгвэл хоёр дахь хуудсан дээр нь надад тараагдсан хуудсан дээр байгаа. Энэ буруу зүйл тараагдсан байна уу? Алиныг нь хэлэлцэх гэж байгаа юм.

Тэгвэл ар дахь дөрвөн зүйлээс асууя. 2020 оны эхний хагас жилд багтаан шинэчлэн баталсны үндсэн дээр засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний эрх зүйн байдалтай холбогдох хууль, тогтоомжийг Дархан, Эрдэнэт хотыг улсын зэрэглэлтэй хот болгох асуудлыг судлан Улсын Их Хуралд өргөн мэдүүлж шийдвэрлэнэ гэдэг асуудал байгаа юм.

Бид бас ярихдаа Улаанбаатар хотын томоохон дүүргүүдийн асуудлыг бас Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд хот болох асуудал орж ирлээ гэдэг ойлголтоор явсан байгаа. Энэ зохицуулалтыг ямар хугацаанд хийнэ гэсэн бодолтой байгаагаа бас эрх баригч намын нөхдүүд маань бидэнд тайлбарлаж өгөх нь зүйтэй байх. Ард иргэд сонирхон харж байгаа гэж бодож байна.

С.Бямбацогт: Хариулчихъя. Тэгээд Ж.Батзандан гишүүнд гишүүдэд тараасан эхний хуудас байгаа. Материал. Энэ бол нөгөө Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг анх өргөн мэдүүлэхэд 6 сарын 09-нд яг дагалдаж өргөн мэдүүлэгдсэн төслүүд байж байгаа юм. Энийг бид нар хоёр дахь хэлэлцүүлгийн явцад үндсэндээ Ерөнхийлөгчид тавигдах шаардлага, мөн одоо бас шүүгчдэд тавигдах шаардлага, Улсын дээд шүүхийн бүрэн эрхийн хугацаа, Үндсэн хуулийн цэцийн талаарх гээд заалтууд байсан. Түүнтэй холбоотойгоор дагаж мөрдөхдөө ингэж мөрдье гэсэн ийм юм оруулж байсан бол эдгээр маань хоёр дахь хэлэлцүүлгээр бүгд хасагдсан.

Тийм болохоор одоо энэ дагаж мөрдөх журмын тухай хуульд байсан 2, 3, 4, 5. Эдгээр бол бүгд үндсэндээ хасагдана. Тэгээд хасагдаад одоо санал хураалгах гэж байгаа тэр сонгуулийн нөгөө холимог тогтолцоотой холбоотой 2024 оноос үйлчлэхтэй холбоотой зүйл нэмэгдээд эцсийн хувилбараар иймэрхүү болох юм гэдгээ дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг та бүхэнд тараасан байгаа юм. Тийм болохоор зэрэг хоёр дахь хуудас дээрээ илүү ажиллах нь зөв болов уу гэж бодож байгаа. Ийм байдлаар яригдсан асуудлууд байгаа юм.

Тэр Дархан, Эрдэнэтийг хот болгохтой холбоотой, тэр Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хууль, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль гээд хуулиудыг бид нар

Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл батлагдсаны дараа тодорхой хуулийг хэзээ яаж батлах вэ гэдэг төлөвлөгөө гаргана. Хуулийн жагсаалтыг батална. Тэр үедээ саяны таны ярьж байгаа асуудлыг хэлэлцээд яриад тодотгоод явах бололцоотой гэж ойлгож байгаа.

Д.Лүндээжанцан гишүүнд микрофон өгье.

Д.Лүндээжанцан: Энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийг бол Төрийн байгуулалтын байнгын хороо хуралдаад. Хуралдааных нь он, сар, өдрийг үзүүлчихээрэй. Тэгээд гишүүд санал гаргаад 2, 3, 4, 5 дугаар зүйлүүдийг нь хасчихсан. Тэгээд ердөө гуравхан юм үлдсэн.

Одоо энэ дээр нь Улсын Их Хурлын сонгуулийг 2024 оны ээлжит сонгуулиас эхлэн олонхийн болон хувь тэнцүүлэх зарчмыг хослуулан явуулна гэдгээ 2024 оны ээлжит сонгууль гэдгийг оруулахаар. Ганцхан томъёоллоор санал хураагдана.

Тэгээд энэ бол бид нэгдүгээр хэлэлцүүлэг хийж байгаа байхгүй юу. Байнгын хороон дээрээ нэгдүгээр хэлэлцүүлэг хийж байна. Тэр Дархан, Эрдэнэттэй холбоотой асуудлыг эртээд хуралдаан дээр санал хураагаад оруулчихсан. Тэгэхдээ энэ асуудлаар Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн холбогдох хуулийг шинэчлэн батлах хүртэл хугацаанд тухайн харилцааг зохицуулж ирсэн хуулийг баримтална. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт хууль тогтоомжийг нийцүүлэх ажлыг Улсын Их Хурлаас баталсан хуваарийн дагуу хийж дуусгана гэдэг дээр Ж.Батзандан гишүүний сая ярьсан асуудал тавигдаж байгаа. Мөн 2-той нь холбогдуулаад Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний эрх зүйн байдалтай холбоотой хууль тогтоомжийг 2020 оны эхний хагас жилд багтаан шинэчлэн баталлаа гээд үүрэг өгсөн.

Үүнтэй холбогдуулаад Нутгийн удирдлагын хууль бэлэн болж байгаа. Үндсэндээ төсөл нь анхны шатанд. Одоо ингээд Та бүхэн бол тэрэндээ ороод явна. Тэр дотроо нийслэлийн, аймгийн төвүүд. Тийм үү. Томоохон суурин газрууд энэ тэрийн ерөнхий юунууд нь гараад. Тэгээд тэр дагуу нэг нэгээр нь асуудлыг шийднэ шүү дээ. Нэг нэгээр нь. Тийм үү. Оруулж ирж шийднэ гэж. Ж.Батзандан гишүүний нөгөө олон удаа ярьж байгаа энэ нийслэлийн зарим дүүргүүдийг хот болгохтой холбоотой асуудлууд тэнд яригдана гээд. Тэгээд нэг хорин хэдэн хуулийн нэрс гарсан.

Тэгэхээр энэ чуулганы үед, энэ намрын чуулганы үед. Одоо ингээд ирэх долоо хоногоос Сонгуулийн хуульдаа орно. Улс төрийн намын хууль, Нутгийн удирдлагын хууль энэ тэр бол эхний ээлжийн хуулиуд болж таарна. Болж өгвөл шүүхийн хуулиудыг гаргах шаардлага гараад байгаа байхгүй юу. Тийм ээ. Тэгээд энэ мэтчилэнгийн асуудлууд бол ингээд бүгдийг одоо энэ сонгуулийн жил амжих уу, үгүй юу гэдэг асуудал байгаа учраас ямар ч байсан одоо бид бүхэн бол манай Байнгын хороо бол приоритет өгөх хугацаатай. Ямар ямар хуулиудаа эхний ээлжинд оруулж ирэх вэ гэдэг юугаа манай Байнгын хороо оруулж Их Хурлаар батлуулах шаардлага гараад байгаа.

С.Бямбацогт: Д.Эрдэнэбат гишүүн.

Д.Эрдэнэбат: Баярлалаа. Энэ 2 дугаар зүйлийг хэн найруулсан юм бэ? Энийг жаахан бодохгүй бол ийм томъёоллоор орж ирж болохгүй л дээ. Жишээлбэл, 2020 оны эхний хагас жилд багтаагаад энэ хоёр. Энэ хоёр чинь өнөөдөр аймаг шүү дээ. Энэ хоёр аймгийг хотын статустай болгох асуудлыг шийдээ гэж байгаа. Би бол 2020 оны эхний хагас жилд сонгуультайгаа хутгалдаад энэ юу явах манатай юм. Энийг тооцсон юм болов уу, үгүй юм болов уу.

Хоёрдугаарт, энэ томъёолол чинь маш буруу бичсэн. Засгийн газар Дархан, Эрдэнэт хотыг улсын зэрэглэлтэй хот болгох асуудлыг судална гэж байгаа юм. Засгийн газар Дархан-Уул аймаг, Орхон аймгийн гэж бичнэ шүү дээ. Өнөөдөр чинь тийм байгаа биз дээ. Эрх зүйнхээ үндсээр. Яагаад ийм хачин юм хийдэг юм.

Энэ аймгуудыг тэр улсын зэрэглэлтэй гээд. Мэдэхгүй. Зүгээр улсын зэрэглэлтэй гэдэгтэй би санал нэгдэхгүй л яваад өдийг хүрч байгаа. Ер нь хот болгох асуудлыг судлаад Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ гэж томъёолох ёстой шүү дээ. Тэгээд ийм нэг сонин юм орж ирсэн. Энийгээ засахгүй юм уу. Зассан нь дээр байх. Би бол засах ёстой гэж харж байна.

4 дүгээр зүйл байгаа. Улсын Их Хурлын сонгуулийг 2024 онд ээлжит сонгуулиас эхлэн оны олонхийн болон хувь тэнцүүлсэн зарчмыг хослуулан явуулна гэж. Түрүүн Д.Хаянхярваа дарга ярилаа. Ардчилсан нам Ерөнхийлөгчийг Их Хурлаас сонгодог зарчмын байр сууринаас татгалзаагүй шүү дээ. Тийм юм бол байхгүй. Зөвшилцлийн хурал дээр тэр татгалзах тухай асуудал яриагүй. Харин Ардчилсан намаас бусад нь энэ асуудлыг дэмжих боломжгүй байна гэдгээ илэрхийлсэн нь бол үнэн. Илэрхийлсэн нь бол үнэн.

Тэгэнгүүт нь ямар асуудал үүссэн гэхээр хэрвээ та бүхэн энэ Ерөнхийлөгчийн асуудлыг дэмжихгүй гэж байгаа юм бол наад сонгуулийнхаа асуудлыг 2024 он биш 2020 оноос яриа гэдэг шаардлагыг бид нар тавьж байгаа шүү дээ. Энэ бол зарчмын шаардлага байхгүй юу. Тэгэхгүй бол биш ээ. Яагаад гэвэл танайх 2024 он гэж хийснийг бид нар 2025 оноос Ерөнхийлөгчийг парламентаас сонгоё гэдэг хоёр тоог оруулахад 2025 оноос байсан бол 2024 онд бид нар энийг хийж болно гэж ярьсан. Хэрвээ Ерөнхийлөгчийг хүлээж авахгүй юм бол наад асуудлаа эргэж харах ёстой шүү гэж бид хэлж байгаа. Тийм учраас мессежээ зөв явуулаарай. Мессеж зөв байх ёстой шүү.

Тийм учраас өнөөдөр би бол зарчмын зөрүүтэй саналыг гаргана. Улсын Их Хурлын сонгуулийг 2024 оноос биш 2020 оноос явуулах нь зүйтэй гэж үзнэ. Холимог системээрээ явуулахыг. Одоо би энэ дээр өнөөдөр гаргана. Журмын хууль дээр. Энийг бас манай гишүүд бодож үзээрэй. Энэ бол зарчмын асуудал шүү.

С.Бямбацогт: Д.Тогтохсүрэн гишүүн.

Д.Тогтохсүрэн: Өчигдөр Зөвшилцлийн ажлын хэсэг хуралдсан. Улсын Их Хурлын даргын 199 дүгээр захирамжаар байгуулагдсан. Энэ хуралд Ардчилсан

нам байгаа, ШИНЭ нам байгаа, Ерөнхийлөгчийн институцээс байгаа, Монгол Ардын намаас байгаа. Нийт 10 гишүүнтэй. 8 гишүүн хуралд ирж оролцсон.

Энэ хурлаас юу гэж шийдсэн гэхээр нэгдүгээр асуудал буюу Засгийн газрын гишүүнийг Ерөнхий сайд томилж, чөлөөлөхтэй холбоотой асуудлыг дэмжсэн.

Хоёрдугаар асуудал дээр бол холимог тогтолцоон дээр дэмжсэн. Ардчилсан нам бол ямар байр суурь илэрхийлсэн гэхээр холимог тогтолцоон дээр бол дэмжиж байна. Тэгэхдээ 2020 он болгох асуудал дээр та нар яриач ээ гэсэн. Бид нар бол энэ их хүнд асуудал. Ярих боломжгүй гэсэн.

Ардчилсан нам бол ингэсэн. Эхний хоёр асуудал дээр бид нар манай саналыг хүлээж авсан учраас гурав дахь саналаасаа бид нар 2020 он гэвэл буцаж болох юмаа гэж ингэж ярьсан юм.

Тэгээд ажлын хэсгийн гишүүд ярилцаж байгаад гурав дахь санал буюу Ерөнхийлөгчийг парламентаас сонгох асуудлыг Байнгын хорооны болон ажлын хэсгийн хуралд оруулахаа больё. Больё. Эхний хоёр асуудлаа зарчмын зөрүүтэй санал болгож асуудалд оруулъя гээд ажлын хэсгийн хурлаасаа шийдсэн. Энэ шийдлийнхээ дагуу өчигдөр үдээс хойш 14.00 цагаас хуралдсан. Ө.Энхтүвшин даргын 68 дугаар ажлын хэсэг дээр бид нар энийг яриад энэ хоёроор санал хураалгаад явж байгаа. Тийм.

Ажлын хэсгийн шийдвэр ингээд гарсан учраас би намын бүлгээр нэгэнт оруулахгүй асуудлыг намын бүлгээр оруулъя гэж ярих шаардлагагүй гэж ингэж үзсэн байгаа юм шүү.

С.Бямбацогт: Гишүүд асуултаа асууж, үгээ хэлж дууслаа. Одоо зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт.

Төсөлд доор дурдсан агуулгатай 4 дүгээр зүйл нэмэх:

“4 дүгээр зүйл. Улсын Их Хурлын сонгуулийг 2024 оны ээлжит сонгуулиас эхлэн олонхийн болон хувь тэнцүүлэх зарчмыг хослуулан явуулна.”

Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Энэ санал дэмжигдэхгүй бол 2020 оноос болно шүү дээ, тэгээд. Холимог тогтолцоо. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 14 гишүүн оролцсоноос 10 гишүүн буюу 71.4 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Ердийнхөөр явж байгаа. Ердийн дэгтэй.

Дараагийн санал хураалт. Саяных бол ажлын хэсгийн санал байсан. Одоо Д.Эрдэнэбат гишүүний санал байгаа. Энэ бас хураах ёстой байлгүй дээ. Гишүүдийн. Тийм. Санал.

“4 дүгээр зүйл. Улсын Их Хурлын сонгуулийг 2020 оны ээлжит сонгуулиас эхлэн олонхийн болон хувь тэнцүүлэх зарчмыг хослуулан явуулах.” Холимог тогтолцоог 2020 оноос явуулъя гэсэн саналыг Д.Эрдэнэбат гишүүн гаргаж байна. Энэ саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Асуух асуулт, хэлэх үг байна уу? Г.Занданшатар гишүүн.

Г.Занданшатар: Гишүүдийн өдрийн амгаланг айлтгая. Одоо жаахан бас тайван, ул суурьтай хандахгүй бол болохгүй байна.

Энэ өмнөх санал хураалтуудаар 2020 оны 5 сарын 25-наас Үндсэн хуулийг хүчин төгөлдөр болно гээд заачихсан. Энэний дагуу Сонгуулийн хуулийг нэг жилийн өмнө сонгуулийн журмыг хуулиар тогтооно. Хуулийг нэг жилийн өмнө өөрчилж болохгүй. Нэг жилийн дотор өөрчилж болохгүй гээд заачихсан.

Тэгэхээр энэ батлагдсан хуультай чинь энэ санал зөрчилдөөд, хууль зүйн зөрчилд ороод байгаа юм. 2020 оны. Харин энэ хүнээ сонгоно. Энэ тогтолцоо бол 2020 оноос тэртээ тэргүй хэрэгжиж болох цэцийн гурван өөр дүгнэлт байгаа. Тийм учраас Үндсэн хуульд. Сонгуулийн хууль дээр энийг ярилцаад шийдэх бололцоотой. Энэ бол Сонгуулийн хуулиараа хэлэлцэн шийдэх бололцоотой юм билээ.

Сая чинь бол одоо хүнээ сонгоно гээд зарчмаар санал хураалт. Хүнээ сонгоно гэсэн зарчим чинь цэцээр нээлттэй. Улс нэг том тойргоор. Тийм учраас энийг бол ойлголцоод явсан нь зөв байх гэж.

С.Бямбацогт: Юу юм байна. Нэгдүгээрт нь, сая бас Их Хурлын даргын хэлсэн тайлбарыг та бүхэн бас сонссон байх.

Хоёрдугаарт нь, энэ дэгийн хуультай зөрчилдөх юм байна. Дэгийн хуулийн 21.19 дээр төслийн нэг зүйл, хэсэг, заалтын талаар хоёр буюу түүнээс дээш саналын томъёолол гарсан тохиолдолд хамгийн эхэнд ирүүлсэн саналаар санал хураалт явуулахдаа зэрэгцээ саналыг танилцуулж санал хураалгах бөгөөд уг санал дэмжигдвэл бусад санал дэмжигдээгүйд тооцож санал хураалт явуулахгүй.

Нэг зүйл, хэсэг, заалтын талаар. Тийм үү. Нэг зүйл, хэсэг, заалт. Энэ энэ чинь нэг зүйл. Нэг хэсэг. Тийм үү. Нэг заалт. Тэгээд агуулга нь өөр. Тийм. Гэхдээ нэг зүйл, нэг хэсэг, нэг заалт. Тэгэхдээ агуулга нь өөр. Та ойлгож байгаа биз. Тийм ээ. Тийм болохоор хоёр буюу түүнээс дээш санал гарсан тохиолдолд хамгийн эхэнд ирүүлсэн саналаар санал хураалт явуулахдаа зэрэгцээ саналыг танилцуулна гэсэн. Би тэр зэрэгцээ саналыг жаахан бага дутуу танилцуулсан байж магадгүй. Тийм. Танилцуулж санал хураалгах бөгөөд уг санал дэмжигдвэл бусад санал дэмжигдсэнд тооцож санал хураалт явуулахгүй гэсэн дэгийн хуультай юм байна.

Дэгийн хуулиа та хар. Хуулийн зөвлөхүүдээсээ асуугаач. За за. Хураая. За санал хураалт. Хураахаар дэгийн хууль зөрчих гээд байна. Тийм.

Одоо тэгвэл Х.Нямбаатар гишүүний саналаар дахиж санал хураалт явуулъя. Та одоо өөрийнхөө саналыг тайлбарлачих. Х.Нямбаатар биш. Ажлын хэсгийн.

Д.Эрдэнэбат гишүүн саналаа тайлбарлачих. Тэгээд ажлын хэсгийн саналаар дахиж санал хураалт явуулна. Ажлын хэсгийн санал дэмжигдэх юм бол таны санал санал хураагдахгүй. Тамгын газар. Э.Түвшинжаргал дарга. Тайлбарлаад өг. Энд бас хууль зөрчиж болохгүй байх. Дэгийн хууль.

Э.Түвшинжаргал: Чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд 2019 оны 6 сарын 07-нд бас нэмэлт, өөрчлөлт орсон. Д.Эрдэнэбат гишүүн ээ.

Тэгээд ер нь бол яг нэг төслийн зүйл, заалтын талаар гишүүд эсрэг байр суурьтай ийм хоёр санал гаргахад энийг өмнө нь зохицуулах дэгээр боломж бол тун хязгаарлагдмал байсан учраас энэ дэгд өөрчлөлт ороод 21 дүгээр зүйлийн 19-нд шинэ зүйл орсон. Энийг уншиж танилцуулъя.

Төслийн нэг зүйл, хэсэг, заалтын талаар хоёр буюу түүнээс дээш саналын томъёолол гарсан тохиолдолд хамгийн эхэнд ирүүлсэн саналаар санал хураалт явуулахдаа зэрэгцээ саналыг танилцуулж санал хураалгах бөгөөд уг санал дэмжигдвэл бусад санал дэмжигдээгүйд тооцож санал хураалт явуулахгүй гэсэн ийм дэгийн хуулийн заалттай болсон. Саяны тохиолдолд холимог тогтолцоог 2024, 2020 гэсэн хоёр ийм бие биенийгээ мөргөсөн хоёр санал гарсан. 2024 нь дэмжигдсэн.

С.Бямбацогт: Тэгвэл түрүүний 2024 оноос гэдэг саналаа цуцалъя. Тийм. Улсын Их Хурлын сонгуулийг 2024 оны ээлжит сонгуулиас эхлэн олонхийн болон хувь тэнцүүлэх зарчмыг хослуулан явуулна гэсэн санал хураалтыг цуцалъя. Цуцалъя гэсэн томъёоллоор санал хураачихъя. Дахиад хураая.

Санал хураалтад 15 гишүүн оролцсоноос 12 гишүүн буюу 80.0 хувийн саналаар цуцлах санал дэмжигдлээ.

Одоо гэхдээ би танилцуулсан. Хэрвээ 2024 дэмжигдэхгүй бол 2020 болно шүү гэж танилцуулсан. Гэхдээ дахиад хоёр саналыг хоёуланг нь уншиж танилцуулъя. Гаргасан хүмүүс нь саналынхаа үндэслэлийг тайлбарлаарай.

Нэгдүгээрт нь, ажлын хэсгийн санал. Улсын Их Хурлын сонгуулийг 2024 оны ээлжит сонгуулиас эхлэн олонхийн болон хувь тэнцүүлэх зарчмыг хослуулан явуулна. Энэ саналыг Ардчилсан намын зөвлөлөөс байнга гаргаж байсан санал. Ингээд 2024 оноос гэдэг байдлаар бас авъя гээд өчигдөр Зөвшилцлийн ажлын хэсэг дээр ярилцаад шийдсэн санал.

Хоёр дахь санал нь, Д.Эрдэнэбат гишүүний гаргаж байгаа санал. Бас Ардчилсан намын зөвлөлөөс гаргаж байгаа гэж ойлгож байгаа.

4 дүгээр зүйл. Улсын Их Хурлын сонгуулийг 2020 оны ээлжит сонгуулиас эхлэн олонхийн болон хувь тэнцүүлэх зарчмыг хослуулан явуулна гэсэн саналыг гаргаж байгаа. Энд нэг нь 2020 оны сонгуулиас холимог тогтолцоог сонгууль явуулъя. Нөгөөдөх нь 2024 оноос явуулъя гэсэн хоёр өөр санал

байгаа. Саналуудаа тайлбарлаж гишүүд үг хэлэх үү. Үг хэлэх шаардлагагүй юу. Тэгвэл би эхэлж ярьсан, ажлын хэсгээс гарсан саналаар санал хураалт явуулъя. Энэ дэмжигдэх юм бол энүүгээр явна. Энэ хоёр дахь санал хураалтаар санал хураагдахгүй. Дэмжигдэхгүй бол 2024-өөр. Дэмжигдээгүйд тооцогдоно. Тийм.

Хэрвээ дэмжигдэхгүй бол 2020 оноос буюу тийм үү хоёр дахь санал нь дэмжигдсэнд тооцно. Саналын томъёоллыг танилцуулъя.

4 дүгээр зүйл. Улсын Их Хурлын сонгуулийг 2020 оны ээлжит сонгуулиас эхлэн олонхийн болон хувь тэнцүүлэх зарчмыг хослуулан явуулна. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Д.Лүндээжанцан гишүүн.

Д.Лүндээжанцан: 2024 оноос гэдгийг би дэмжсэн. Энэ автомат систем ажилласангүй энэ дээр. Миний энэ дээр бол ер нь бол одоо 60 хувьтай ажиллаж байна шүү дээ. Тэгэхээр ер нь бол бодох хэрэгтэй.

С.Бямбацогт: 15 гишүүн санал хураалтад оролцсоноос 11 гишүүн буюу 11 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

Хоёр дахь санал хураалтаар эхний санал дэмжигдсэнд тооцогдсон учраас хоёр дахь санал хураалт. Д.Эрдэнэбат гишүүний саналаар санал хураалт явуулахгүй. Дэмжигдээгүйд тооцож санал хураалт явуулахгүй. Санал дүгнэлтэд орно.

Зарчмын зөрүүтэй саналаар санал хураагдсан. Д.Хаянхярваа гишүүн.

Д.Хаянхярваа: Би тэр Ерөнхийлөгчийг парламентаас сонгоно гэдэг дээр үг хэлмээр байна. Яагаад гэвэл надад өглөө хэлэхдээ Ардчилсан намын бүлэг татаад авчихсан гэж манай бүлгийн дарга надад тайлбарласан. Тэгээд одоо Ардчилсан намын бүлэг татаад авчихсан учраас хэлэлцэх боломжгүй боллоо гэж хэлэхээр нь би тийм юм байна гэж ойлгосон. Гэтэл өнөөдөр энд ороод ирэхээр Ардчилсан намын зөвлөл бол би татаж аваагүй шүү. Бид нар татаж аваагүй гэж.

Тэгээд бид нар чинь одоо хэрвээ яг үнэнээ хэлэхэд энэ Үндсэн хуулийн амин чухал асуудал бол ерөөсөө л энэ хоёр Засгийн газартай байгаад байгаа юмыг л бид нар нэг талд нь гаргая л гэдэг асуудал. Бид нар энэ асуудлыг ярьж, энэ асуудлыг нэг талд нь гаргах тал руугаа явахгүй юм бол үндсэндээ энэ Үндсэн хуулийн өөрчлөлтийн чинь хамгийн гол юм нь орхигдчихлоо шүү дээ. Тэгээд яагаад энэ асуудлыг бүлэг дээрээ яриад одоо бүлэг шийдээгүй юм. Бүлэг дээр гурван асуудлаа ярих ёстой байтал бүлэг дээр ярилгүй хэсэг бүлэгхэн хүн энүүхэн эндээ тохироод. Одоо Ерөнхийлөгч энийг батлахгүй гээд байгаа юм гэдэг ийм тайлбар хэлээд байгаа байхгүй юу. Би хэлж байна шүү дээ. Хэрвээ батлахгүй бол батлахгүй л биз дээ. Бид нар ямар ч байсан саналаа оруулаад Улсын Их Хурал шийдвэрээ гаргаад Үндсэн хуулийнхаа өөрчлөлтийг батлаад өгөх ёстой. Батламжлах батламжлахгүй нь бол Ерөнхийлөгчийн эрхийн асуудал. Тэр бол ойлгомжтой.

Тэгэхдээ ялангуяа энэ Ерөнхийлөгчийг парламентаас сонгох асуудлыг 2025 оноос гэж хэлж байгаа нь бол одоогийн байгаа Ерөнхийлөгчийг дахиад сонгогдох эрхэнд нь ч бид нар халдаагүй. Өөрөөр хэлэх юм бол 2021 онд дахиад нэр дэвшээд сонгогдох эрх нь хэвээрээ үлдэж байгаа. Тэгээд 2025 оноос, ядахдаа 2025 оноос одоо энэ нэг өнөөгийн байгаа хамгийн зөрчилтэй, хамгийн болохгүй засаглалын хэлбэрт хамгийн хүндрэлтэй байгаа энэ асуудлыг засъя л гэдэг юмаа энэ Үндсэн хуулийн өөрчлөлтөөр бид нар ярих гээд байна шүү дээ. Гэтэл энүүхэн эндээ нэг ордны хуйвалдаан маягийн юм хийгээд би ингээд энийг чимээгүй өнгөрөөгөөд байгаа тохиолдол чинь бол яг чин сэтгэлээсээ дургүй хүрч байна шүү. Энд хуйвалдаан явагдаж байна шүү дээ. Хуйвалдаан явагдаж байна. Д.Лүндээжанцан дарга аа, Д.Тогтохсүрэн дарга аа. Та нар ордны хуйвалдаан маягийн юм хийж байна. Ингэж энэ Үндсэн хуулийн юмыг завхруулж болохгүй. Энэ Х.Нямбаатарын юмыг, гаргасан санал, энэ саналыг бол бүлэг дээр дахиж ярьж байж заавал санал хураах ёстой гэдэг би ийм зарчмын байр суурь илэрхийлж байна.

С.Бямбацогт: Та хэд бүлэг дээрээ ярих нь зөв байх аа. Сая бол хэлэлцээд хэлэлцэх асуудал дууссан. Тийм. Хэлэлцэх асуудал дууссан учраас дахиж одоо ярих бололцоогүй байна. Бүлгийн хурал дээрээ наад асуудлаа ярилцах нь зөв байх аа.

Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа. Байнгын хорооны санал, дүгнэлтийг би танилцуулъя. Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул Байнгын хорооны хуралдааныг хаасныг мэдэгдье. Гишүүд болон ажлын хэсэгтээ баярлалаа.

Дууны бичлэгээс буулгасан:
ПРОТОКОЛЫН АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД